



Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар

МОНГОЛ УЛС

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ
2016 оны 6-р сарын 29-ний өдөр

ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон
Сонгуулийн ажиглах хорооны
Тайлан



Варшав
2016 оны 10-р сарын 4-ний өдөр

ГАРЧИГ

I. ХУРААНГУЙ	1
II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ	3
III. ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН	4
IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БОЛОН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО	5
V. СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРИЛАЛТ	7
VI. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА	8
VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ	11
VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ	12
IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН	15
X. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ	18
XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	20
A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН.....	20
B. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	20
C. ЕАБХАБ/АИХЭГ-ЫН САХ-НЫ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ.....	22
XII. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ	24
XIII. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО	26
XIV. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД	27
XV. СОНГУУЛИЙН ӨДӨР	27
A. ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ.....	28
B. САНАЛ АВАХ БАЙРНЫ НЭЭЛТ БОЛОН САНАЛ ӨГӨЛТ.....	28
C. САНАЛ ТООЛОХ БОЛОН ДҮНГ НЭГТГЭХ.....	29
D. СОНГУУЛИЙН ДҮНГ ЗАРЛАХ.....	30
XVI. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ	31
A. Улс төрийн үйл явц.....	31
B. СОНГУУЛИЙН ДАРААХ ӨРГӨДӨЛ ГОМДОЛ.....	31
XVII. ЗӨВЛӨМЖ	32
A. Нэн тэргүүний зөвлөмжүүд.....	32
B. Бусад зөвлөмжүүд.....	33
ХАВСРАЛТ I – СОНГУУЛИЙН ДҮН	36
ХАВСРАЛТ II – ОЛОН УЛСЫН СОНГУУЛИЙГ АЖИГЛАХ ХОРООНЫ АЖИГЛАГЧДЫН ЖАГСААЛТ	40
ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ	44

МОНГОЛ УЛС
УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ
2016 оны 6-р сарын 29-ний өдөр

**ЕАБХАБ-ЫН АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны
тайлан¹**

I. ХУРААНГУЙ

Монгол Улсын Гадаад хэргийн яамнаас 2016 оны 6-р сарын 29-ний өдрийн УИХ-ын сонгуулийг ажиглахыг урьсан урилгын дагуу ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ/АИХЭГ)-аас Сонгуулийн ажиглах хороо (САХ)-г мөн оны 5-р сарын 20-ны өдөр байгуулав. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгуультай холбогдох олон улсын бусад хэм хэмжээ, түүнчлэн дотоодын хууль тогтоомжууд хэрхэн мөрдөгдөж байгаад үнэлгээ хийсэн. Сонгуулийн өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-той Европын парламентын төлөөлөгчид нийлж, олон улсын сонгуулийн ажиглах хороо (ОУСАХ)-г байгуулан ажиллав. Энэхүү ОУСАХ-д хамтран ажилласан хоёр байгууллага нь Олон улсын сонгуулийг ажиглах зарчмын тухай 2005 оны тунхаглалыг баталсан болно.

2016 оны 6-р сарын 30-нд гаргасан Урьдчилсан тайланд “Жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг хүндэтгэн, өрсөлдөөнтэй сонгуулийн сурталчилгааны дараах санал авах өдөр нь эмх журамтай болж өндөрлөлөө. Гэхдээ энэ нь сонгуулийн хуулинд тулгаж суурь зарчмыг өөрчилсөн нь Монгол Улсын ардчиллын хөгжилд сөрөг үр дагавартай байсныг зөвтгөх аргагүй. УИХ-ын сонгууль хэдийгээр их өрсөлдөөнтэй болсон ч сонгуулийн сурталчилгаанд тавигдсан шаардлагууд нь хэвлэл мэдээлэл зарим талаар улс төрийн ашиг сонирхолд үйлчилж, сонгогчдод хүргэх шударга, өргөн хүрээтэй мэдээллийг хязгаарлав” гэж дүгнэжээ.

Талуудыг оролцуулсан хэлэлцүүлгийн үндсэн дээр сонгуулийн хэд хэдэн хуулийг нэгтгэн сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12-р сарын 25-нд баталсан нь сонгуулийн хууль эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн нэг дэвшилтэт алхам болсон. Гэвч 2016 оны 5-р сард УИХ сонгуулийн холимог тогтолцоог олонхийн буюу мажоритар тогтолцоо болгон өөрчилж, нэг мандат бүхий 76 сонгуулийн тойргийг байгуулан, улмаар тойргуудын нутаг дэвсгэрийг батлах үйл явц нь ил тод бус, олон нийтийн хэлэлцүүлэггүйгээр явагдсан. Хүн амын тоо зэрэг бодит шалгуурыг хайхралгүй орхигдуулсны улмаас тойргуудын хүн амын тоо харилцан адилгүй болж, энэ нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагений баримт бичгийн 7.3 дахь зүйлд заасан иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байх зарчим, мөн олон улсын бусад үүрэг, хэм хэмжээтэй нийцэхгүй байна. Ерөнхийдөө сонгуулийн тогтолцоонд суурь өөрчлөлтүүдийг оройтуулж хийсэн нь энэ удаагийн УИХ-ын сонгуулийн явцад тохиолдсон олон хүндрэлтэй асуудлын шалтгаан болсон юм.

УИХ-ын сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) тэргүүтэй дөрвөн шатны сонгуулийн байгууллага удирдан явуулсан. СЕХ санал авах өдөрт бэлтгэн, үүргээ биелүүлж ажилласан. Гэхдээ СЕХ-ны үйл ажиллагаанд ил тод байдал дутагдаж байв. СЕХ-ноос чухал журмыг хожимдуулан баталсан, доод шатны хороод болон сонгуульд оролцогч талуудтай харилцах харилцаа тогтмол бус, түүнчлэн оролцогч талууд болон олон нийтийн өмнө хүлээх хариуцлага хүлээх байдал хангалтгүй байсан нь сонгуулийн байгууллагад итгэх сонгогчдын итгэлийг бууруулж байв.

Санал тоолох төхөөрөмжийг санал авах байр бүрт ашигласан. СЕХ нь намууд болон иргэний нийгмийн байгууллагуудын өмнө санал тоолох төхөөрөмж дээр мэргэжлийн шалгалт хийж

¹ Энэхүү тайлангийн зөвхөн англи хэл дээрх хувилбарыг албан ёсны баримт бичиг гэж үзнэ. Монгол хэл дээр албан бус орчуулгыг авах боломжтой.

баталгаажуулсан боловч уг төхөөрөмжүүдийн ажиллагааны талаарх мэдээлэл, техник болон програм хангамжийн тухай олон нийтэд мэдээлээгүй. Санал тоолох төхөөрөмжүүдийн техник болон програм хангамжийн хараат бус баталгаажуулалтыг шаардсангүй, хийгдсэн ч үгүй. Санал тоолох төхөөрөмжийн үнэн зөв ажиллаж буйг баталгаажуулах зорилготой арга хэмжээ болох гараар тоолох ажиллагааг явуулах журмыг санал авах өдрөөс хоёрхон хоногийн өмнө эцэслэн гаргасан нь доод шатны хороодод холбогдох сургалт зохион байгуулах цаг хугацаа олгоогүй.

Оролцогч талууд сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдал, бүх сонгогчдыг хамруулсан зэрэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж байлаа. Гэвч олон тооны сонгогчийг санал авах өдрийг тулган түр шилжүүлэх явдал гарсан нь хэд хэдэн тойрог дээр сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдлыг алдагдуулж, сонгогчийн шилжилт хөдөлгөөн үнэн эсэхэд эргэлзэхэд хүргэсэн. Түүнчлэн гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй болон шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бүх этгээд санал өгөх эрхгүй байгаа нь олон улсын хэм хэмжээ, ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг болон сайн туршлагатай зөрчилдөж байна.

Нэр дэвшигчдийн бүртгэл ерөнхийдөө бүх талыг оролцуулан, сонгогчдод улс төрийн өргөн сонголтыг өгсөн. Гэвч хуулиар сонгуульд нэр дэвшихийг хязгаарласан нэмэлт нөхцлүүдийг зааж өгч, албан татварын хугацаа хэтэрсэн өр болон зээлийн өртэй, түүнчлэн хугацаат цэргийн албыг хаагаагүй, гэмт хэрэг үйлдсэн, эсвэл ял шийтгэлийг бүрэн эдэлж дууссанаас үл хамааран ял шийтгэлтэй иргэдийг хассан зэрэг нь сонгогдох эрхийн тухай ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй байна. Түүнчлэн зарим тохиолдолд нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой өргөдөл гомдлыг барагдуулах үйл явц сунжирч байсан нь ижил тэгш үндсэн дээр сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлаж байв.

Сонгуулийн сурталчилгааны заалтууд хатуу чанд байсан хэдий ч жагсаал цуглаан хийх болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэж, нэр дэвшигчид сонгогчдод үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангагдсан. Хэдийгээр зарим ширүүн өрсөлдөөнтэй тойргууд дээрх яриа, илтгэлээс болж сонгуулийн сурталчилгаа илүү хурцадмал байдалд хүрч байсан ч сонгуулийн сурталчилгаа улс орон даяар тайван болж өнгөрсөн. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд санал худалдан авсан гэж сэжиглэж буй хэд хэдэн тохиолдлын талаар мэдээлэл ирж байсан. Заримдаа төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, мөн улс төрийн намуудын зааг ялгаа бүдгэрэх явдал гарч байв.

Сонгуулийн сурталчилгааны зардлыг тайлагнах шалгуур нь бүрхэг, сонгуулийн сурталчилгааны зардлыг санал авах өдрөөс өмнө шалган баталгаажуулах хууль эрх зүйн ямар нэг зохицуулалт байдаггүй. Үндэсний аудитын газар анх удаа нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны зардалд аудит хийхээр болсон хэдий ч зөвхөн сонгууль дууссаны дараа хийхээр зохицуулжээ. Хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал хууль эрх зүйн зохицуулалтуудыг боловсруулаагүй, мөн сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой ноцтой зөрчлүүд, тухайлбал сурталчилгаанд зарцуулах зардлын хязгаарыг зөрчих, хуурамч тайлан гаргах зэрэгт оногдуулах шийтгэл байхгүй байна.

Бүх улс төрийн нам нэр дэвшигчийн жагсаалт дээр 20 хувийн жендэрийн квот мөрдсөн. Сонгогдсон УИХ-ын гишүүдийн 17 хувь нь эмэгтэйчүүд байсан нь жендэрийн тэгш эрхийг хэрэгжүүлэхэд талаар гарсан нэгэн зэрэг алхам байв. Гэвч сонгуулийн тойргийн гуравны нэгээс илүү хувь дээр эмэгтэй нэр дэвшигч байсангүй. СЕХ-ны гишүүд дунд зөвхөн нэг эмэгтэй гишүүн ажиллаж байсан бол, доод шатны хороодод эмэгтэйчүүдийн төлөөлөл илүү сайн байв. Гэсэн хэдий ч улс төрийн амьдралд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага хэвээр байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгуулийн мэдээ мэдээллийг өргөн хүрээтэй нэвтрүүлсэн ч зуучлагчийн үүргээ орхигдуулж, гол төлөв улс төрчдөд шууд нэвтрэх боломж олгож байлаа.

улс төрийн төлбөртэй сурталчилгаа болон сонгуулийн үнэ төлбөргүй сурталчилгааны нэвтрүүлэг нь редакцийн агуулгыг бүрхэгдүүлж, улс төрийн намуудаас бэлтгэсэн сонгуулийн сурталчилгааны материалууд цаг үеийн мэдээний нэвтрүүлэгийн дундуур цацагдаж байсан нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулж байв. Гиймээс мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс сонгогчид бие даасан, аналитик мэдээлэл хүлээн авах боломжоор дуттаг байлаа.

Аливаа иргэн, улс төрийн нам нь сонгуулийн байгууллагын үйл явц, ажиллагааг хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэхэд гомдол гаргах боломжийг хуулиар хангаж өгсөн ч шүүх эрх мэдэлд ил тод байдал дутагдаж байна. СЕХ нь сонгуулийн өмнө 50 орчим өргөдөл гомдол хүлээн авсан бол, шүүх 25 хэрэг хянан хэлэлцэж, цагдаагийн байгууллага 1,000 гаруй гомдлыг шийдвэрлэжээ. Хэдийгээр хууль тогтоомжоор өргөдөл гомдол гаргах үйл явцыг зарим хэмжээнд тодорхой болгож өгсөн боловч сонгуулийн байгууллагад албан ёсны бөгөөд ил тод байдал дутагдалтай, сонгуультай холбоотой маргааныг шүүхээр хянан хэлэлцэхдээ удаашруулах, мөн олон янзаар шийдвэрлэж байгаа зэрэг нь шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг бууруулсан.

Иргэний нийгмийн байгууллагууд сонгуулийн өмнөх орчинд, сонгуулийн сурталчилгааны зардал болон хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн байдалд мониторинг хийж, зөрчил дутагдлыг онцолсон мэдэгдлийг цаг тухайд нь гаргаж байв. Сонгуулийн өдөр 300 орчим иргэний нийгмийн байгууллагын ажиглагчид санал авах болон санал тоолох явцыг ажиглахаар орон даяар ажиллалаа. Эдгээр ажиглагчид нь улс орны хэмжээнд болон орон нутгийн түвшинд иргэдийн боловсрол, сонгогчийн мэдээлэлтэй холбоотой санал санаачилгууд гарахад чухал хувь нэмэр оруулсан.

Сонгуулийн өдөр улс орон даяар ерөнхийдөө дэг журамтай явагдаж өнгөрлөө. Хэдийгээр саналын нууцлал тэр бүр хангагдахгүй байсан ч санал хураалтыг эерэгээр дүгнэв. Санал хураалтыг тоолох болон дүнг нэгтгэх үйл явц илэрхий муу байсан гэж дүгнэсний гол шалтгаан нь процедурын ноцтой алдаа дутагдлууд байсантай холбоотой гэж үзсэн. Санал тоолох төхөөрөмжид итгэх сонгогчдын итгэлийг нэмэгдүүлэх үүднээс техникийн гар тооллогыг зөвшөөрсөн ч санал авах байрны ажилтнууд тоон дээр гарсан ямар нэг зөрүүг тохируулах үүрэг хүлээгээгүй учраас энэхүү хүчин чармайлт нь үр дүн муутай байлаа.

СЕХ нь сонгуулийн дүнг нэгтгэсний дараа шууд урьдчилсан дүнг гаргаж, хоёр өдрийн дараа буюу санал тоолох төхөөрөмжийн үр дүнг гараар тоолсон тооллоготой тулгаж шалгахаас өмнө уг дүнг баталгаажуулав. Парламентэд сонгогдсон гишүүд 2016 оны 7-р сарын 5-нд тангараг өргөж байхад сонгуулийн дүнг эсэргүүцсэн өргөдөл гомдол шүүх дээр хүлээгдэж байлаа. Түүнчлэн сонгуулийн тойрог тус бүрээр гаргасан албан ёсны дүнг СЕХ-ноос мөн оны 7-р сарын 6-нд олон нийтэд мэдээлсэн бол, санал авах байр тус бүрээр гаргасан, гэхдээ нэгтгэн боловсруулаагүй дүн мэдээ зөвхөн өргөдөл гомдол гаргах албан ёсны хугацаа дууссаны дараа бэлэн болсон. Албан ёсны дүнг нийтэд мэдээлсэн, мөн түүнийг баталгаажуулсан байдал нь сонгуулийн дүнгийн талаар гомдол гаргах эрх болон олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээлэл олж авахдаа олон улсын өмнө хүлээсэн үүрэгт заасны дагуу чирэгдэлгүй, шуурхай, үр дүнтэй замаар тухайн мэдээлэлд нэвтрэх эрхээ эдлэх боломжийг тус тус алдагдуулсан.

II. ТАНИЛЦУУЛГА, ТАЛАРХАЛ

Монгол Улсын эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн урилгын дагуу, мөн түүнчлэн 2016 оны 4-р сарын 5-8-ны өдрүүдэд хийгдсэн Урьдчилсан судалгааны тайланд тусгагдсан зөвлөмжийг үндэслэн ЕАБХАБ-ын АИХЭГ-аас САХ-г мөн оны 5-р сарын 20-ны өдөр байгуулав. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны тэргүүнээр Элчин сайд Одри Гловер ажилласан бөгөөд 14 хүний

бүрэлдэхүүнтэй үндсэн баг Улаанбаатар хотод байрлаж, 5-р сарын 27-ны өдрөөс эхлэн 14 урт хугацааны ажиглагч (УХА) тодорхой газруудад байршин ажиглав. Сонгуулийн өдөр ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-той Европын парламент (ЕП)-ын төлөөлөгчид хамтран, Олон улсын сонгуулийн ажиглах хороо (ОУСАХ)-г байгууллаа. ЕП-ын төлөөлөгчдийг Лайма Луциа Андрикиене (Литва Улс) тэргүүлэн ажиллав. ОУСАХ-ны гишүүдийг ЕАБХАБ-ын гишүүн 33 орноос бүрдүүлсэн бөгөөд үүнд ЕАБХАБ/АИХЭГ-аас илгээсэн шинжээч, урт болон богино хугацааны ажиглагчид нийлсэн 208 хүн, мөн Европын парламентын төлөөлөгч 10 гишүүн багтсан юм.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь сонгуулийн үйл явцад ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалт, ардчилсан сонгуультай холбоотой олон улсын бусад хэм хэмжээ, түүнчлэн дотоодын хууль тогтоомжууд хэрхэн мөрдөгдөж байгаа талаар үнэлгээ хийсэн болно. Энэхүү төгсгөлийн тайлан нь 2016 оны 6-р сарын 30-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан хэвлэлийн бага хурал дээр мэдээлсэн Урьдчилсан тайланг үндэслэн, өргөтгөн боловсруулсан.²

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь уг сонгуулийг ажиглах урилгыг ирүүлсэн Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), Гадаад хэргийн яам болон бусад байгууллагуудад дэмжин тусалсан явдалд талархаж байна. Түүнчлэн манай хорооны гишүүдтэй өөрсдийн үзэл бодлыг хуваалцсан иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагуудад, мөн хамтран ажилласан олон улсын байгууллагуудын төлөөлөгчдөд талархаж буйгаа илэрхийлж байна.

Ш. ОРШИЛ БА УЛС ТӨРИЙН ОРЧИН

2016 оны 1-р сарын 29-нд Монгол Улсын парламент УИХ-ын ээлжит сонгуулийг мөн оны 6-р сарын 29-ний өдөр явуулахаар төвлөв. Уг сонгууль нь эдийн засаг зогсонги байдалд орж, олон нийтийн улс төрд итгэл алдарсан нөхцөлд явагдлаа. 2012 оноос хойш Ардчилсан нам (АН) хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн аль алиныг хянаж, улс төрийн давуу эрх мэдэлтэй байсан бөгөөд аймгуудын засаг дарга нарын дийлэнх нь тус намд харьяалагдаж байв.³

Дээд шүүхэд хорин дөрвөн улс төрийн нам бүртгэлтэй бөгөөд тэдгээрийн тав нь бүрэн эрхийн хугацаа нь дуусаж буй УИХ-д төлөөлөлтэй. УИХ-д суудалтай намуудаас АН, Монгол ардын нам (МАН) болон Монгол ардын хувьсгалт нам (МАХН) нь орон нутагт өргөн бүтэц бүрэлдэхүүнтэй ажилладаг.⁴

2016 оны 4-р сард МАН болон МАХН нэгдэн эвсэл байгуулах оролдлого амжилтгүй болсны дараа МАХН-ын зарим томоохон улс төрчид, мөн тус намын орон нутгийн зарим байгууллагууд МАН-д дагаар орсон. Мөн хугацаанд АН ч жижиг намуудын гишүүдийг өөртөө элсүүлэв. Үндсэн хуулийн цэцийн дарга болон Авлигатай тэмцэх газрын даргыг 2016 оны 2, 4-р сард үүрэгт ажлаас нь тус тус чөлөөлөв. Шинэ дарга нарыг 6-р сарын 29-нөөс өмнө томилоогүй байсан нь сонгуулийн үйл явцад чухал үүрэг бүхий энэ хоёр байгууллагыг сонгуулийн кампанит ажлын хугацаанд удирдлагагүй орхигдуулсан нь санаа зовоосон асуудлуудын нэг болов.

² [ЕАБХАБ/АИХЭГ-аас Монгол Улсын талаар гаргасан өмнөх бүх тайланг үзнэ үү.](#)

³ 21 аймгийн Засаг дарга нарын 16 нь, мөн Улаанбаатар хотын захирагч нь АН-ын харьяаллынх байв.

⁴ УИХ-д суудалтай хоёр улс төрийн нам нь Иргэний зориг-Ногоон нам, Монголын үндэсний ардчилсан нам байв.

УИХ-ын сонгууль нь аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуультай нэг өдөр явагдсан. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь зөвхөн УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт хийж, тайлан гаргав.

IV. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БОЛОН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улс нь олон улсын хүний эрхийн үндсэн конвенциудад нэгдэн орсон. 1992 оны Үндсэн хуулиар эдгээр арга хэрэгслийг дотоодын хууль тогтоомжуудад тусган шууд хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж, эдгээрийг шударгаар сахин биелүүлэхийг шаарддаг болсон. Үндсэн хууль нь өөрөө ардчилсан сонгуулийг бэхжүүлэх суурь эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулдаг.

Сонгуулийн хууль эрх зүйн орчин нь Үндсэн хууль, 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ), 2012 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ) болон СЕХ-ны журам зэргээс үндсэндээ бүрдэж байна.⁵ Гэвч СЕХ нь шаардлагатай гэж үзсэн зохицуулалтыг батлах бүрэн эрх байхгүй, зохицуулалт шийдвэрүүдийн цар хүрээ нь СТБТХ болон СТХ-иар хязгаарлагдаж байна.⁶ Энэ нь СЕХ-нд сонгуулийн хууль тогтоомжийг тууштай хэрэгжүүлэхэд саад учруулж байна.

Сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн тогтолцоог ханган баталгаажуулах, мөн түүнийг тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахын тулд сонгуулийн хууль тогтоомжид тодотгон нэмэх шаардлагатай гэж үзсэн зохицуулалт (дүрэм, журам)-ыг батлах бүрэн эрхийг СЕХ-нд олгохоор холбогдох хуулийг дахин хянан авч үзэж болох юм.

СТБТХ-иар СЕХ нь сонгуулийн хууль тогтоомжийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Дээд шүүхэд оруулах эрхтэй. Гэвч 2012 оноос хойш Дээд шүүх нь албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхээ хэрэгжүүлэхээ больсон тул энэ нь сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн хүрээний цаашдын хөгжлийг хязгаарлахад хүргэж байгаа юм.⁷ Улсын Дээд шүүхээс ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлэхдээ хэрэв УИХ-аас Шүүхийн тухай хуульд дээд шүүхийн эрх мэдлийг тодорхойлсон шинэ зохицуулалт оруулж өгөхгүй бол хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбар гаргах боломжгүй гэв.⁸

Дээд шүүх нь СЕХ-ны хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбарыг гаргах бүрэн эрхээ эргэн хэрэгжүүлэх нь зүйтэй. Дээд шүүхийн ажлыг хөнгөвчлөхийн тулд Дээд шүүхээс өгсөн санал зөвлөмжүүдийн дагуу Шүүхийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах талаар анхаарч үзэж болох юм.

Талуудыг оролцуулсан хэлэлцүүлгийн үндсэн дээр сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12-р сарын 25-нд баталсан. Энэ хуульд сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэсэн бөгөөд энэ нь сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн нэг дэвшилтэт

⁵ Холбогдох бусад хуулиудад Улс төрийн намын тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн аудитын тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон шүүх засаглал, хэвлэл мэдээллийг зохицуулах бусад хууль тогтоомжууд орно.

⁶ СТБТХ-ийн 7.1.7 дэх заалтын дагуу СЕХ нь СТХ-нд заасан дүрэм, журам, заавар, баримт бичгийн загвар маягтыг батлах эрхтэй.

⁷ 2012 - 2015 онд СЕХ нь Дээд шүүхэд сонгуулийн хууль тогтоомжийн тухай албан ёсны тайлбар гаргахыг хүсэж хэд хэдэн хүсэлт илгээсэн боловч хариу аваагүй байна. Тиймээс СЕХ нь өргөдөл гомдол илгээхээ зогсоожээ.

⁸ 2015 оны 10-р сард Үндсэн хуулийн цэц нь Шүүхийн тухай хуулийн заалтыг хүчингүй болгосноор Дээд шүүхийн хууль тогтоомжийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах гэсэн бүрэн эрхийг хязгаарласан байна.

алхам болсон.⁹ Уг хуулийн төсөл нь гурван жилийн хугацаанд боловсруулагдсан хэдий ч УИХ-ын сонгууль болохоос зургаахан сарын өмнө батлагдсан. СТХ-нд сонгуулийн хууль эрх зүйн орчинтой холбоотой ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдийн заримыг тусгасан, тухайлбал өргөдөл гомдол гаргах үйл явц болон хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан байна. Гэсэн хэдий ч ихэнх зөвлөмжүүдийг тусгалгүй орхигдуулсан болно. Ерөнхийдөө СТХ-нд иргэдийн сонгох, сонгогдох эрх болон сонгуулийн сурталчилгааны эрх чөлөөг хязгаарласан нэмэлт нөхцлүүд, мөн түүнчлэн хуулийн хийдэл, хоорондоо зөрчилдсөн, тодорхой бус хэд хэдэн заалтууд байна. СТХ-ийг баталсны дараа Үндсэн хуулийн цэцэд УИХ-ын сонгуулийн зарим заалтуудын талаар 10 өргөдөл ирсний дотор сонгогдох эрх болон сонгуулийн сурталчилгааны эрхийг хэтэрхий хязгаарласан байна гэжээ.¹⁰ Ялангуяа, УИХ-ын сонгуулийн тухай өмнөх хуулинд байсан сонгууль болохоос зургаан сарын дотор ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглох тухай чухал заалтыг шинэ хуулиас хасчээ. Улмаар сонгуулийн хууль тогтоомжид оруулсан чухал өөрчлөлтүүдийг, тухайлбал сонгуулийн тогтолцоог өөрчилсөн өөрчлөлтийг хожимдуулж танилцуулахад хүргэв.

Улсын Их Хурал (парламент) нь дөрвөн жилийн хугацаатай сонгогдох 76 гишүүнээс бүрдэнэ. СТХ-ийг батлах үед сонгуулийн хувь тэнцүүлэх болон олонхийн тогтолцоог нэгтгэн, холимог тогтолцоогоор парламентийн сонгуулийг хийхээр төлөвлөж байв.¹¹ Гэвч 2016 оны 4-р сарын 22-ны өдөр Үндсэн хуулийн цэц хоёр өргөдлийг шуурхай шийдвэрлэж, энэ нь улс төрийн намуудыг сонгогчид болон нэр дэвшигчдийн хооронд тавьж байна гэсэн үндэслэлээр сонгуулийн хувь тэнцүүлэх (пропорциональ) тогтолцоо нь иргэний “шууд” сонгох тухай Үндсэн хуулийн эрхийг зөрчиж байна хэмээн хүчингүй болгосон.¹² Энэ шийдвэр нь 2012 онд Цэцээс пропорциональ тогтолцоо нь иргэний “шууд” сонгох эрхийг хангасан сонгуулийн тогтолцоо мөн бөгөөд Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэж гаргаж байсан шийдвэрийн эсрэг гарчээ.¹³ УИХ нь Цэцийн дээрх дүгнэлтийг хүлээн авсан бөгөөд Цэцийг уг шийдвэрээ дахин хянаж үзэхийг шаардах бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй. Хэдийгээр Цэцийн шийдвэрийг хэрэгжүүлэх хуульд заасан хугацаа байхгүй ч 2016 оны 5-р сарын 5-ны өдөр СТХ-нд нэмэлт, өөрчлөлт оруулан бүрэн мажоритар тогтолцоог тогтоон батлав.

УИХ нь Цэцийн дээрх дүгнэлтийг хэрэгжүүлснээс гадна олон мандат бүхий сонгуулийн тойргийн тогтолцоог нэг мандат бүхий тойргийн тогтолцоо болгон өөрчилснөөр мажоритар тойргийн тоо 26-аас 76 болж нэмэгдэв. Түүнчлэн УИХ сонгуулийн тойргийн тоог тогтоох эцсийн хугацааг сонгуулийн өдрөөс 150 хоногийн өмнө байсныг 45 болгож багасгав.¹⁴ Дээрх шинэчлэлтүүдийг нэвтрүүлэхээс өмнө олон нийтийн дунд хэлэлцүүлэг явагдаагүй. Сонгууль болох өдрөөс хоёр сар хүрэхгүй хугацааны өмнө сонгуулийн тогтолцоо болон сонгуулийн

⁹ Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль, аймаг нийслэлийн болон сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийг зохицуулсан дөрвөн хуулийг шинэ сонгуулийн хуульд нэгтгэсэн.

¹⁰ Сонгуулийн пропорциональ тогтолцоо нь үндсэн хуулийг зөрчсөн гэх өргөдлөөс бусад өргөдлийг авч хэлэлцээгүй. Өргөдлүүдийг хянан хэлэлцэхгүй гэсэн шийдвэрийг олон нийтэд мэдээлээгүй байна.

¹¹ Дөчин найман гишүүн олон мандаттай 26 тойрог дээр мажоритар системээр сонгогдож, нэг мандаттай үндэсний хэмжээний тойрог дээр таван хувийн босгоор 28 суудалд сонгогдох ёстой.

¹² Бүрэн эрх нь дуусаж буй парламент сонгуулийн холимог тогтолцоогоор сонгогдсон. 2016 оны 1-р сарын 27-нд гаргасан эхний өргөдлийг хувь тэнцүүлэх тогтолцоо нь Үндсэн хуулийг зөрчөөгүй байна гэсэн үндэслэлээр няцаасан. 2016 оны 2-р сарын 29-нд давж заалдахад өргөдлийг авч хэлэлцсэн. Хоёр дахь өргөдлийг мөн оны 4-р сарын 13-нд гаргасан бөгөөд эхний өргөдөлтэй нэгтгэсэн.

¹³ 2012 онд Үндсэн хуулийн Цэц дунд суудлын хуралдааны дүгнэлтэд “Монгол Улсын Үндсэн хуулиар улс төрийн сонгуулийг мажоритар, пропорциональ, эсвэл холимог тогтолцоогоор явуулна гэж хатуу заагаагүй. Үндсэн хуулийн 21.2 дахь “шууд сонгох эрх” гэсэн заалт нь сонгогч сонгуульд ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өөрөө гаргах бөгөөд сонгуулийн үр дүн нь сонгогчдын саналын үндсэн дээр гардаг гэсэн агуулгыг илэрхийлнэ... Шууд сонгох зарчим нь сонгуулийн дүн сонгогчдын өгсөн саналаар тодорхойлогдох ба холбогдох хуулийн дагуу сонгогч саналаа шууд сонгох эрхийн үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр нууцаар гаргах үед илэрхийлэгдэнэ” гэжээ.

¹⁴ Дараагийн хэсэгт сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалтын талаарх нэмэлт мэдээллийг үзнэ үү.

хуульд ийнхүү суурь зарчмийн өөрчлөлт хийгдсэн нь олон улсын сайн туршлагыг дордуулж буй явдал бөгөөд уг энэ үйл явц нь улс төрийн нөлөөлөлийн дор хийгдсэн байж болох асуудлыг үүсгэж байна.¹⁵ Ингээд УИХ-ын гишүүд нь нэг мандаттай 76 тойрог дээр улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчид болон бие даан нэр дэвшигчдийн дундаас хамгийн олон санал авсан нь ялдаг системээр сонгогдов.

Сонгуулийн хууль тогтоомжуудад аливаа чухал өөрчлөлтүүд оруулахаар бол талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг өрнүүлэхээс гадна сонгуулийн үйл явцад тогтвортой байдлыг болон олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө батлах шаардлагатай.

Түүнчлэн 2016 оны 5-р сард сонгуулийн шинэ хуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байхаар заасан жендэрийн квотыг 20 хувь болгож бууруулав.¹⁶ Үүнээс гадна сонгуулийн бэлтгэл ажил аль хэдийн эхлээд байсан ч УИХ парламентын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч буй Монгол Улсын 150,000 орчим иргэдийн сонгуульд оролцох эрхийг хасав.¹⁷

СТХ-иар сонгуулийн тойрог бүр дээр сонгогчдын ирц 50 хувьтай бол сонгуулийг хүчинтэйд тооцдог. Хэрэв энэ ирц хүрээгүй бол нэмэлт санал хураалтыг эрх бүхий сонгогчдын 50-иас доошгүй хувийн ирцтэй оролцсон хэсгүүд дээр зөвхөн эхний санал хураалтад оролцоогүй сонгогчдоос авна. СТХ-иар нэмэлт санал хураалтыг явуулах эцсийн хугацааг тодорхой зааж өгөөгүй байна.

V. СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХУВААРИЛАЛТ

УИХ нь СЕХ-ноос ирүүлсэн саналыг үндэслэн сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг сонгуулийн жил бүр тогтоодог. Ингэхдээ хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг харгалзан үзэх ёстой. Гэвч сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хуваарилах үйл явц ил тод биш, олон нийтээр хэлэлцэгдээгүй, тогтоосон шалгуурыг дагаж мөрдсөнгүй. 2016 оны 5-р сарын 11-нд СЕХ-ноос УИХ-д сонгуулийн тойрог тус бүрт бүртгэгдсэн сонгогчдын талаар мэдэгдэхүйц ялгааг тусгасан сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг хэрхэн тогтоох тухай саналыг хүргүүлсэн. Энэ ялгаа нь 2016 оны 5-р сарын 12-нд УИХ сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийг дахин хуваарилж, 76 тойргийн нутаг дэвсгэрийг батласнаар бүр нэмэгдсэн. 50 тойрог дээр тойрог тутамд 25,170 сонгогч ноогдож буй улсын дундажаас 15-аас дээш хувиар хэтэрсэний зэрэгцээ хамгийн том тойрог нь хамгийн жижиг тойргоосоо гурав дахин их сонгогчтой болсон.¹⁸ Тойргууд дээр хүн амын тоо ийм зөрүүтэй байх нь иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байх зарчим болон олон улсын бусад сайн туршлагад нийцэхгүй байна.¹⁹

¹⁵ [2002 оны Европын Венецийн Комиссын Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрэм](#), II.2.b. хэсэг (Сайн туршлагын дүрэм)-ээр сонгуулийн хуулийн үндсэн элементүүдэд сонгууль болохоос өмнөх сүүлийн 12 сарын дотор нэмэлт өөрчлөлт оруулах ёсгүй гэж зөвлөдөг.

¹⁶ Бүрэн эрх нь дууссан УИХ-ын гишүүдийн арван дөрвөн хувь нь эмэгтэйчүүд байв.

¹⁷ СТХ-иар, уг хуулийг батлагдах үеэр, мөн өмнөх УИХ-ын сонгуулийн тухай хуулинд гадаадад буй иргэдийн саналыг сонгуулийн пропорциональ тогтолцоогоор авахаар заасан байв.

¹⁸ Хамгийн жижиг тойрог болох Ховд аймгийн 34-р тойрог 13,866 сонгогчтой бол, хамгийн том тойрог болох Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг 41,836 сонгогчтой.

¹⁹ Сайн туршлагын дүрмийн I. 2.2-д “Тойрог бүрт ижил тэгш саналын эрх олгох: сонгуулийн тойргууд дээр суудлын тоог ижил хуваарилсан байх ёстой” гээд [...] iv. дэх заалтанд “Зөвшөөрөгдөх хэм хэмжээнээс гарах зөрүү нь 10 хувиас ихгүй байх ёстой ба онцгой нөхцөл байдал (төвлөрсөн цөөнхийг хамгаалах, хүн ам тархан суурьшсан засаг захиргааны нэгжүүд)-аас бусад тохиолдолд 15 хувиас огт хэтэрч болохгүй гэж зөвлөдөг.

УИХ-ын чуулганы хэлэлцүүлгийн явцад хүн амын нягтрал, аймгуудын нутаг дэвсгэрийн хэмжээ, хөгжлийн хэрэгцээ, түүхэн нөхцөл байдал зэргээр ялгавартай байх шалтгаануудыг жагсаан гаргажээ.²⁰ Гэсэн хэдий ч, СТХ-нд сонгуулийн тойргуудын хуваарилалттай холбоотой энэ мэт асуудлуудыг хүчин төгөлдөр үндэслэл гэж үзсэнгүй. Тойргууд дээр хүн амын тоо ийм зөрүүтэй байх нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагений баримт бичгийн 7.3 дахь хэсэгт заасан иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байх зарчим болон олон улсын бусад үүрэг, хэм хэмжээтэй нийцэхгүй байна.²¹

Шинээр дахин хуваарилагдсан хэд хэдэн тойрог нутаг дэвсгэрийн хувьд хил залгаа биш байв.²² Түүнчлэн сонгогчид нь хоёр, гурван тойргийн дунд хуваагдсан есөн сум байсан. Эрх бүхий хүмүүс ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлэхдээ ийм хуваарилалт хийх олон шалтгаан байсны дотор нэг угсаатан ястнаас бүрдсэн сонгуулийн тойргууд бий болохоос зайлсхийх, мөн УИХ-ын гишүүд нь хот, хөдөө орон нутгийг адилхан төлөөлж байх ач холбогдлыг онцолж өгсөн гэв. Гэвч сонгуулийн тойргийн ийм хуваарилалт нь газар зүйн хувьд хөрш зэргэлдээ байх, мөн орон нутгийн хил хязгаарыг хадгалж байхыг зөвлөдөг олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.

СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалтыг тогтоохдоо сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө хийхээр зааж өгөхийн зэрэгцээ сонгуулийн нэг тойрогт оногдох сонгогчдын тоо нь улсын дундаж тооноос зөрсөн хамгийн их зөрүү нь үндэслэлтэй, хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр байхаар тогтоож өгөх, улмаар саналын тэгш эрхийг хангахад чиглэсэн, орон нутгийн хил хязгаарыг хадгалах тухай асуудлыг харгалзан үзсэн байвал зохино.

VI. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

УИХ-ын сонгуулийг Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ), 22 Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ), 339 Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), 1,998 Сонгуулийн хэсгийн хороо (СХХ) гэсэн дөрвөн шатны сонгуулийн байгууллагууд зохион байгуулав. СЕХ нь есөн гишүүнтэйгээс нэг нь эмэгтэй бөгөөд тэднийг УИХ-аас зургаан жилийн хугацаатай томилжээ. УИХ-аас гаргасан жагсаалтаас УИХ таван гишүүнийг, Ерөнхийлөгч хоёр гишүүнийг, Дээд шүүхээс хоёр гишүүнийг СЕХ-ны гишүүнээр нэр дэвшүүлдэг. Бүх шатны сонгуулийн хороодын гишүүдийг сонгон шалгаруулахдаа төрийн албан хаагч байх гэдгээс өөр шалгуурын талаар хуульд заагаагүй. АНСХ нь долоогоос есөн гишүүнтэй бол, СДСХ болон СХХ нь таваас долоон гишүүнтэй. АНСХ-дын гишүүдийн 43 орчим хувь нь эмэгтэйчүүд буюу доод шатны сонгуулийн байгууллагад ажиллаж буй эмэгтэй ажилтнуудын хувь өндөр байна.

АНСХ, СДСХ болон СХХ-дын ажилтнуудыг орон нутгийн засаг захиргааны бэлтгэсэн жагсаалтаас сонгожээ. СЕХ нь хуулийн хугацаандаа багтан, АНСХ-дын 196 ажилтныг томилсон бөгөөд тэдгээр нь СДСХ-дын 2,000 гаруй ажилтан, СХХ-дын 14,000 орчим ажилтныг

²⁰ Жишээлбэл, 46,589 эрх бүхий сонгогчидтой Хэнтий аймаг гурван тойрогт хуваагдсан бол, сонгогчдын тоо 2,687-оор илүү Дорнод аймаг зөвхөн хоёр тойрог хуваарилагджээ. Ингэснээр Хэнтий аймгийн сонгуулийн тойргууд нь улсын дундажаас хамгийн их зөрүүтэй тойрогт орж байна.

²¹ Нэгдсэн үндэстний байгууллагын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (ИУТЭОУП)-ын 25-р зүйлийн (b), мөн Нэгдсэн үндэстний байгууллагын хүний эрхийн хороо (НҮБХЭХ)-ны 1996 оны Ерөнхий тайлбарын 25-ын 21-р хэсэгт “сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоохдоо, мөн сонгогчдын саналыг хуваарилах арга нь сонгогчдын хуваарилалтыг гажуудуулах, эсвэл аль нэг бүлэг хүмүүсийг ялгаварлан гадуурхах ёсгүй ба иргэдийн өөрсдийн төлөөллийг чөлөөтэй сонгох эрхийг шалтгаангүйгээр хасаж, хязгаарлаж болохгүй” гэж заажээ.

²² Жишээ нь, Увс аймгийн 33-р тойрог хил залгаа бус гурван хэсэгт хуваагджээ. Улаанбаатар хотын гадна орших Багануур дүүрэг дөрвөн хэсэгт хуваагдаж, хэсэг тус бүр нь Баганууртай хил залгаа бус өөр өөр хотын тойрогт хуваарилагджээ.

сонгожээ. Сонгуулийн хороодын ажилтнуудыг томилох нэгдсэн шалгуур ажиглагдсангүй.²³ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд АНСХ болон СДСХ-дын бүрэлдэхүүнд улс төрийн ялгаварлал байна, ялангуяа аймгын засаг дарга нарын тамгын газрын болон нийслэлийн захирагчийн ажлын албаны дарга нар нь сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга нар байна гэсэн олон тооны мэдээлэл ирсэн.²⁴ Энэ нь СТХ-ийг зөрчихгүй байгаа хэдий ч доод шатны сонгуулийн хороодын хараат бус байдалд итгэх оролцогч талуудын итгэлийг алдагдуулахад хүргэж байсан.²⁵ Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтнуудын томилгооны талаар гомдол маргаан албан ёсоор бараг гараагүй ч томилгоог хэрхэн хийх тухай нэгдсэн, ил тод журам байхгүй байгаа нь сонгуулийн байгууллагад итгэх сонгогчдын итгэлд сөргөөр нөлөөлж байна.

Бүх шатны сонгуулийн хороодод ажиллах гишүүдийг томилох, чөлөөлөх механизмыг олон нийтийн дунд, талуудыг оролцуулсан, ил тод байдлаар бий болгоход анхаарах нь зүйтэй.

СТХ-иар бүх шатанд ажиллаж буй сонгуулийн байгууллагууд шийдвэрээ ил тод, нээлттэй, олонхийн саналаар шийдвэрлэж байхыг шаарддаг. Гэхдээ СЕХ-ны ихэнх хурал нь олон нийтэд урьдчилан мэдээлэлгүйгээр гэнэтийн байдлаар явагдаж байсан тул улс төрийн намууд, бие даан нэр дэвшигчид, иргэдийн ажиглагчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын дийлэнх нь эдгээр хуралд хамрагдаагүй байна.²⁶ Түүнээс гадна СЕХ-ны цахим хуудас дээр тус байгууллагаас гаргасан шийдвэрийн зарим нь тавигдаагүй бөгөөд хурлаар хэлэлцсэн асуудлууд, хурлын тэмдэглэлийн аль нь ч нийтлэгдсэнгүй. Ерөнхийдөө СЕХ-нд оролцогч талууд болон олон нийттэй харилцах ил тод, хариуцлагатай байдал дутмаг байсан нь сонгуулийн ажиллагааны найдвартай байдалд итгэх итгэлийг бууруулж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглагчид АНСХ-д болон СДСХ-д нь ил тод байдлын талаар баримталж байсан СЕХ-ны арга барилыг ерөнхийд нь дууриах байдалтай гэж ажиглажээ.

Сонгуулийн байгууллагад талуудын оролцоог хангаж, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ болон доод шатны хороод нь сонгуулийн хугацаанд тогтмол, нээлттэй хурал уулзалтыг хийхдээ олон нийтэд хангалттай хугацааны өмнө мэдэгдэж, хэлэлцэх асуудал, хурлын тэмдгэд, гаргасан шийдвэрийг нэн даруй олон нийтэд мэдээлж, хэвлэн нийтэлж байх нь зүйтэй.

Хэдийгээр сонгуулийн ажлын хуваарь шахуу байсан ч СЕХ санал авах өдөрт бэлтгэж, хуульд заасан цаг хугацааны чухал товчуудыг мөрдөн, үүргээ биелүүлэн ажилласан. Сонгуулийн байгууллагуудад ажиллах ажилтнуудад зориулсан сургалтуудыг гол төлөв сонгуулийн техникийн асуудлуудад анхаарч ажиллах байдлаар зохион байгуулжээ. Түүнчлэн СЕХ нь доод шатны сонгуулийн хороодыг шинээр батлагдсан сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой дэлгэрэнгүй, нэгдсэн удирдамжаар хангаагүй, ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд доод шатны хороодод хуулийг хэрхэн тайлбарлах, ямар журмыг дагаж мөрдөх талаар эргэлзэж тээнэгэлзэх байдал ажиглагджээ.

²³ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд ирсэн мэдээллээр Төв аймгийн АНСХ нь СДСХ болон СХХ-дод ажиллахаар нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг орон нутгийнхаа “төрийн захиргааны байгууллага”-аас авсан бол, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгуудын АНСХ нь хороодод ажиллах нэр дэвшигчдийн жагсаалтыг СЕХ-ноос, харин Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Өмнөговь аймгуудад АНСХ нь жагсаалтыг орон нутгийн захиргаанаас хүлээн авсан гэжээ.

²⁴ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны урт хугацааны ажиглагчид энэ тухай Улаанбаатар хот болон 11 аймаг (Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорнод, Говь-Алтай, Ховд, Төв, Увс, Өвөрхангай)-ийн 10 АНСХ, 35 СДСХ-н дээрээс мэдээлжээ.

²⁵ 2016 оны 5-р сарын 30-нд Өвөрхангай аймгийн Засаг даргын орлогч СЕХ-нд хандан СДСХ-дод ажиллахаар томилогдон, сургалтад хамрагдах төрийн албан хаагчдын мэдээлэлд МАН-ын харьяаллын хүмүүсийг оруулсан, харин АН-ын харьяаллын хүмүүсийн хувьд өмнө нь сонгуульд ажиллаж байсан туршлагатай байсан ч тэднийг хассан гэсэн гомдол гаргажээ.

²⁶ СЕХ-ны зарим гишүүдийн хэлснээр хурлуудыг ихэнхдээ 30-хан минутын өмнө л мэдээлдэг гэжээ.

Хугацаа шахуу байсан нь саналын хуудсыг хэвлэх явцыг ч хүндрүүлж, 500 ширхэг хуудасны загварыг хэдхэн өдрийн дотор батлуулах ч шаардлага гарч байв. Түүнчлэн түр шилжиж буй сонгогчдод зориулж зөвхөн УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийг багтаасан саналын хуудсыг ч хэвлэх шаардлагатай гарч байлаа. Саналын хуудас болон санал авах бусад материалыг холбогдох хэсгийн хороодод цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Санал тоолох төхөөрөмжийг санал авах байр бүрт ашигласан. 2016 оны 6-р сарын 15-19-нд СЕХ нь намууд болон иргэний нийгмийн байгууллагуудын өмнө санал тоолох төхөөрөмж дээр мэргэжлийн шалгалтыг хийж баталгаажуулав. Гэвч хэт олон хүний бөөгнөрөл үүсгэхгүйн тулд СЕХ нь улс төрийн нам болон иргэний нийгмийн байгууллагын ажиглагчдын бүлэг бүрт тодорхой цаг хуваарилан өгч байсан учраас аль ч оролцогч тал энэ үйл явцыг бүхэлд нь ажиглах боломжгүй байв. Мөн төхөөрөмжийг шалган баталгаажуулах ажил улс даяар хөдөө орон нутагт 2016 оны 6-р сарын 24-25-нд хэсгийн хороодын ажилтнууд, цагдаа, зарим тохиолдолд улс төрийн намуудын, ялангуяа АН болон МАН-ын ажиглагчдыг байлцуулан хийгдсэн байна. Ажиглагчид байлцсан үеийнхээ шалган баталгаажуулах ажлыг ерөнхийд нь эерэг гэж үнэлжээ.

СЕХ санал тоолох төхөөрөмжийн ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд нийтэлж мэдээлээгүй, мөн төхөөрөмжүүдийн техник болон програм хангамжийн хараат бус баталгаажуулалтыг шаардаагүй, хийгээгүй.²⁷ СЕХ-ноос оролцогч талуудад төхөөрөмжийн программын эх кодыг хянаж үзэх боломжийг санал болгосон боловч хэн нь ч уг боломжийг ашиглаагүй байна, учир нь төхөөрөмжийг үйлдвэрлэгч компани эх кодыг үзсэн этгээдийг бусдад задруулахгүй байх гэрээнд гарын үсэг зурахыг шаарддаг. Үйлдвэрлэгч этгээд програм хангамжийн баталгаажилтыг тодорхой ажиллагаагаар дамжуулан гүйцэтгэсэн бөгөөд үүнийг СЕХ хангалттай гэж хүлээн авсан. Гэвч баталгаажуулсан тухай тэмдэглэлийг СЕХ-ны цахим хуудсан дээр нийтлээгүй бөгөөд энэ нь ил тод байдал хийгээд олон улсын хэм хэмжээнд заасан олон нийтэд чухал ач холбогдолтой мэдээлэлд нэвтрэх сонгогчдын эрхийг хязгаарласан үйлдэл болжээ.²⁸

Санал тоолох төхөөрөмжийн эх кодыг үзэх боломжийг хуулиар олгож, бодит байдал дээр гуравдагч этгээдээр хянан баталгаажуулж ёстой бөгөөд санал тоолох төхөөрөмжид итгэх сонгогчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд баталгаажуулсан тухай үр дүнг олон нийтэд мэдээлж нийтлэх нь зүйтэй.

МАН-ын санаачилгаар 2015 оны 12-р сард ил тод байдал болон санал тоолох төхөөрөмжид итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор хэсгийн хороодын хамгийн багаар 50 хувьд гараар дахин тоолох тухай заалтыг СТХ-д оруулсан. Гэвч гараар тоолох ажиллагааг явуулах журмыг санал авах өдрөөс хоёр хоногийн өмнө эцэслэн гаргасан нь доод шатны хороодод холбогдох сургалтыг зохион байгуулах цаг хугацааг олгосонгүй. Хуулинд “50 хүртэл хувь дээр” гэж зааснаас өөрөөр гар тооллого явуулах хэсгийн хороодыг хэрхэн сонгох, мөн гараар болон төхөөрөмжөөр тоолоод гарсан үр дүн зөрүүтэй гарвал тэдгээрийг хэрхэн нэгтгэн тохируулах талаар ямар нэг тодорхой удирдамжаар хангаагүй. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглагснаар

²⁷ Европын зөвлөл (ЕЗ)-ийн Электрон системээр санал авахад баримтлах хууль эрх зүй, үйл ажиллагааны болон техникийн стандартын тухай зөвлөмж (2004) 11-ийн 111-рт “Гишүүн орнууд нь баталгаажуулах үйл явцыг нэвтрүүлнэ” гэж заасан байдаг. Мөн ЕЗ-өөс гаргасан Санал өгөх цахим системийг баталгаажуулах тухай заасан 6, 7-р хэсгийг үзнэ үү.

²⁸ НҮБ-ын ИУТЭОУП-ын 19-р зүйлд өгсөн НҮБ-ын ХЭХ-ны Ерөнхий тайлбарын 34-ийн 19-р хэсэгт “Мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэхийн тулд Гишүүн улс орнууд нь олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай Засгийн газрын мэдээллийг олон нийтэд идэвх санаачилгатай хүргэж байх нь зүйтэй. Гишүүн улсууд нь энэ төрлийн мэдээлэлд хялбар дөхөм, шуурхай, үр дүнтэй бөгөөд бодитоор нэвтрэх боломжийг хангахын төлөө бүхий л хичээл зүтгэл гаргах хэрэгтэй” гэж заажээ.

хэсгийн хороодыг сонгох, мөн дүнг нэгтгэх ажлын аль алиныг гүйцэтгэх нэгдмэл арга ажиллагаа дутагдаж байв.²⁹

Доод шатны сонгуулийн хороод мэдээллийг цаг хугацаандаа багтаан дамжуулах, мөн холбогдох сургалтуудыг зохион байгуулах боломжийг олгох үүднээс СТХ-нд сонгуулийн үйл явцад гарч буй аливаа алдаа дутагдал, хийдлийг боломжийн хугацаанд шийдвэрлэх дүрэм журмыг батлан гаргахыг СЕХ-ноос шаарддаг байхаар зааж өгөх нь зүйтэй.

Иргэдийн сонгуулийн боловсрол, мэдээлэлд чиглэсэн кампанит ажил оройтож эхэлсэн бөгөөд санал авах өдрийг хүртэл хоёр долоо хоног үлдээд байхад өргөн нийтлэг байдал ажиглагдсангүй. Гэхдээ 2016 оны 6-р сарын дундаас эхлээд хэвлэл мэдээллийн олон хэрэгслээр сонгуулийн шинэ тогтолцооны чухал элементүүдийг хамарсан телевизийн сурталчилгааг дохионы хэлийг оролцуулан нэвтрүүлж байлаа. Эдгээр сурталчилгааг СЕХ болон бусад төрийн байгууллагууд төдийгүй иргэний нийгмийн байгууллагуудаас бэлтгэн гаргасан бөгөөд улс даяар цацагддаг мэдээллийн хэрэгслүүд болон орон нутгийн радио телевизүүдээр дамжуулсан.

VII. СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ

Гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй болон шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй. Энэхүү ерөнхий заалтууд нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг болон олон улсын хэм хэмжээтэй зөрчилдсөн тэгш бус хязгаарлалтыг бий болгож байна.³⁰

СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, хорих ял эдэлж буй этгээдүүдийн сонгуульд санал өгөх эрхийг хязгаарлахдаа үйлдсэн гэмт хэргийн ангилал буюу хүнд хөнгөнд тохирсон байхыг баталгаажуулах нь зүйтэй. Эрх зүйн бүрэн чадамжгүй хорих ял эдэлж буй этгээдүүдийн санал өгөх эрхийг хязгаарлахдаа санал өгөх эрхийг нь илэрхий хүчингүй болгосон шүүхийн шийдвэр дээр үндэслэсэн байвал зохино.

Сонгогчийн бүртгэл нь иргэдийн шууд сонгох эрхийн үндсэн дээр хийгдэх бөгөөд био-метрийн мэдээллийг ашиглах иргэний үндэсний бүртгэлд тулгуурлана. Сонгогчдын нэрсийн жагсаалт (СНЖ)-ыг Монгол Улсын Үндэсний иргэний бүртгэлийн мэдээллийн сан (ҮИБМС)-гаас гаргаж, давхардахаас сэргийлэн давтан шалгагдсан. Санал авах өдрөөс тавин тав хоногийн өмнө ҮИБМС-г хорих ял эдэлж буй этгээдүүд, шүүхээс эрх зүйн бүрэн чадамжгүй нь тогтоогдсон, гадаадад суугаа, цэргийн алба хааж буй болон нас барсан иргэдийн мэдээллийг тодотгон шинэчилжээ. СНЖ-ыг олон нийтэд зориулан цахим хэлбэрээр 2016 оны 3-р сарын 1-нээс эхлэн байрлуулсан. 2016 оны 6-р сарын 9-нөөс эхлэн СТХ-д заасны дагуу СНЖ-ыг холбогдох санал авах байрууд болон орон нутгийн захиргааны байрууд дээр байршуулсан. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны гишүүдтэй уулзсан хүмүүс ихэвчлэн хот суурин газруудад СНЖ-ыг олж харахад хүндрэлтэй байсан зарим тохиолдлуудыг онцлон мэдэгдэж байв. Үүний зэрэгцээ зарим хүн ам цөөн газруудад СХХ-ны ажилтнууд өөрсдийн санаачилгаар СНЖ дээрх

²⁹ Сонгууль болохоос хоёр өдрийн өмнө ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь гараар тоолох ажиллагааг явуулах журмыг тайлбарлуулахаар 35 СДСХ-г санамсаргүй байдлаар сонгон авсан. Тэгэхэд зөвхөн тав нь л шаардлагатай журмын талаар ойлголттой байв.

³⁰ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн НҮБ-ын Хүний эрхийн хороо (НҮБХЭХ)-ны 25-р Ерөнхий тайлбарын 14 дэх хэсэгт “хэрэв гэмт хэрэгт үйлдсний төлөө шийтгүүлсэн ялд нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэслэл байгаа бол тухайн түдгэлзүүлэх хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон ялтай нь нийцсэн байх ёстой” гэж шаарддаг. Мөн ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагений баримт бичгийн 24 дэх хэсэгт “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах аливаа хязгаарлалтыг холбогдох хуулийн зорилтуудын аль нэгтэй нь холбох ёстой бөгөөд тухайн хуулийн зорилттой хатуу нийцэж байх ёстой” гэж заасныг үзнэ үү.

алдааг сонгогчдод хэлж өгч, тэдгээр алдааг албан ёсоор засуулах тухай хүсэлт тавихыг санал болгож байв. Оролцогч талууд ерөнхийдөө сонгогчдын бүртгэлийн үнэн зөв байдал, бүх сонгогчдыг хамруулсан зэрэгт итгэлтэй байгаагаа илэрхийлж байлаа. Энэ сонгуульд нийт 1,912,901 сонгогч оролцохоор бүртгэгдсэн.

Сонгогчид санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө өөр хэсгийн хороонд түр шилжих боломжтой байдаг.³¹ Ихэнх сонгуулийн тойрогт шилжсэн сонгогчдын тоо нь бүртгэгдсэн сонгогчдын нийт дүнгийн нэг хувиас хэтрээгүй. Гэвч сонгуулийн дөрвөн тойрогт шилжсэн сонгогчдын тоо 20 хүртэл хувьд хүрчээ.³² Түүнээс гадна сонгогчид шилжилт хийлгэх хүсэлтээ биеэр очиж хийлгэх шаардлагагүй тул итгэмжлэлээр дамжуулан санал өгөх сонгогчдыг олноор нь шилжүүлэх тохиолдол Хөвсгөл, Баянхонгор аймгуудад ажиглагдсан. Олон тооны сонгогчдыг хугацаа тулгаж шилжүүлсэн нь СНЖ-ын үнэн зөв байдлыг гуйвуулахад хүргэсэн бөгөөд санал хураах өдрөөс нэг хоногийн өмнө хүртэл СНЖ-ыг эцэслэн гаргаагүй тохиолдлууд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд ажиглагджээ.³³ 2016 оны 6-р сарын 21-нд АН болон МАН-аас сонгогчийн шилжилт хөдөлгөөний явц хууль журмын дагуу, мөн үнэн зөв явагдаж буй эсэхийг лавлаж, СЕХ-нд хандан таван тойрог дээр шилжилт их өндөр байгаа тухай гомдол гаргажээ. СЕХ-ноос дээрх шилжилт хөдөлгөөн нь СТХ-д заасны дагуу явагдсан гэсэн хариу өгсөн.

Сонгуулийн өдөр эрүүл мэндийн шалтгааны улмаас санал авах байранд очиж саналаа өгч чадахгүй сонгогчид, мөн урьдчилан хорих төвд хоригдож буй этгээдүүд сонгууль болохоос таваас доошгүй хоногийн өмнө зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгч болно. Саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгуулийн хэсгийн хороодоос өөр газар байрлаж буй сонгуулийн байгууллагын ажилтнууд, цагдаагийн албан хаагчид зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгч болно. Гэвч эдгээр хүмүүс үйл ажиллагааны хязгаарлалтаас болж тэр бүр саналаа өгөх боломжгүй байв.

Сонгуулийн байгууллагын ажилтнууд болон цагдаагийн албан хаагчдыг оршин суугаа аймаг дотроо өөрсдийн ажиллаж буй хэсгийн хороодод саналаа өгөхөөр шилжих боломжийг холбогдох хуулиар зөвшөөрөх нь зүйтэй.

VIII. НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛ

25 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамж бүхий иргэн нэр дэвшигч байх эрхтэй. Гэвч СТХ-иар сонгуульд нэр дэвшихийг хязгаарласан нэмэлт нөхцөлүүдийг зааж өгсөн бөгөөд албан татварын хугацаа хэтэрсэн өртэй болон зээлийн өртэй, түүнчлэн хугацаат цэргийн алба хаагаагүй, гэмт хэрэг үйлдсэн, эсвэл ял шийтгэлийг бүрэн эдэлж дууссанаас үл хамааран ял шийтгэлийн бүртгэлтэй иргэдийг хассан байна.³⁴ Эрүүгийн хуульд ял шийтгүүлсэн этгээдийн ялтайд тооцогдох хугацаа нь ял эдэлж дууссанаас хойш 1-10 жилийн хооронд байна гэж заажээ. Төрийн жинхэнэ албан хаагч нь нэр дэвшихээр бол сонгуулийн жилийн 1-р сарын 31-

³¹ Нийт 18,309 сонгогч түр шилжих тухай хүсэлт гаргажээ.

³² Увс аймгийн 31-р тойрог руу нийт 2,778 сонгогч шилжих хүсэлт гаргасан нь бүртгэлтэй сонгогчдын тоог 20 орчим хувиар нэмэгдүүлжээ. Баянхонгор аймгийн 9-р тойрог руу 1,909 сонгогч шилжих хүсэлт өгсөн нь бүртгүүлсэн сонгогчдын нийт дүнг 11 хувиар нэмэгдүүлсэн байна. Хөвсгөл аймгийн 39, 37-р тойрог руу шилжих хүсэлтээ гаргасан сонгогчдын тоо нь нийт сонгогчдын тооны долоо, таван хувь орчмыг тус тус төлөөлж байв.

³³ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь Баянгол дүүрэгт СНЖ-ыг 2016 оны 6-р сарын 28-нд өөрчилснийг ажиглажээ. Үүнээс гадна нэг СХХ-ноос ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлэхдээ СНЖ-ыг дөнгөж сонгуулийн өдөр эцэслэн гаргасан гэжээ.

³⁴ Түүнчлэн СТХ-иар улс төрийн нам, эсвэл нь нэр дэвшүүлэхдээ тухайн хүний Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний төлөө оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, шударга ёс, хууль дээдлэх ёс, УИХ-ын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх ёстой.

нээр буюу нэр дэвшүүлэх үйл явц эхлэхээс зургаан сарын өмнө албан үүргээс чөлөөлөгдсөн байх ёстой. Эдгээр хязгаарлалтууд нь сонгогдох эрхийн тухай ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй байна.³⁵

СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаат цэргийн алба хаагаагүй, албан татварын хугацаа хэтэрсэн өртэй болон зээлийн өртэй, ял шийтгүүлж байсан бүртгэлтэй зэргийг үндэслэн нэр дэвшихийг хязгаарласан нэмэлт нөхцөлийг хүчингүй болгох нь зүйтэй. Төрийн албан хаагчдаас нэр дэвшүүлэх ажил эхлэхээс өмнө албан үүргээсээ чөлөөлөгдөхийг шаардах ёсгүй.

Сонгуулийн тогтолцоог тулгаж өөрчилснөөс үүдэн УИХ нэр дэвшигчдийн бүртгэлийн эцсийн хугацааг 55 хоног байсныг 27 хоног болгосон нь СЕХ-нд дарамт шахалтыг бий болгосон.³⁶ Гэсэн хэдий ч нэр дэвшигчдийн бүртгэл нь үндсэндээ бүх талыг хамруулж, сонгогчдод улс төрийн өргөн сонголт олгосон. СЕХ-нд арван хоёр улс төрийн нам, гурван эвсэл бүртгэгджээ.³⁷ Хоёр улс төрийн намыг бүртгэхээс татгалзсан боловч давж заалдсаны дараа Дээд шүүхээс СЕХ-г нэр дэвшигчдийг бүртгэх журмыг буруу хэрэглэсэн гэж үзэж, Иргэний зориг-Ногоон нам (ИЗНН)-ыг бүртгэх шийдвэрийг гаргасан.³⁸ Таван бие даан нэр дэвшигчийг оролцуулан арван гурван нэр дэвшигчийг хэд хэдэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан байна.³⁹ Бүртгэхээс татгалзсан нэр дэвшигчдээс зөвхөн нэг нь буюу МАХН-ын дарга СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцэн шүүхэд гомдол гаргасан боловч уг хэрэг санал хураалтын өдрийг хүртэл шийдэгдэлгүй хэвээр үлдсэн.⁴⁰ МАХН-ын даргын хэргийг шүүх дээр хэлэлцэхдээ удаашруулан, мөн өөр өөр байдлаар шийдвэрлэж байсан нь үйл явцад ноцтой алдаа дутагдал байгааг харуулсан.⁴¹ Түүнчлэн нэр дэвшигчдийн бүртгэлтэй холбоотой 19 хэргээс шүүх ихэнх дээр нь хэрэг үүсгэхээс татгалзсан бөгөөд үүнд хэн нь ч сэтгэл хангалуун байсангүй.⁴²

³⁵ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн НҮБХЭХ-ны 25-р Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүмүүс нь боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл, эсвэл улс төрийн харъяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй” гэж заасан байдаг. ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн 7.5 дахь хэсэгт Гишүүн орнууд нь иргэдийн улс төрийн болон төрийн албан тушаал хаших эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүндэтгэнэ гэж заажээ. Цаашлаад 24 дэх хэсэгт эрх, эрх чөлөөг хязгаарлах хязгаарлалтууд нь “тухайн хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэжээ. Мөн Сайн туршлагын дүрмийн II.1.b хэсгийг үзнэ үү.

³⁶ СТХ-ийн төслийг боловсруулах явцад СЕХ-ноос уг хуулинд нэр дэвшүүлэх хугацааг санал авах өдрийг товлон зарлахаас 10 хоногийн дотор эхлүүлэхээр УИХ-д санал оруулсан байна.

³⁷ Улс төрийн намууд нь санал авах өдрөөс зургаан сараас доошгүй хугацааны өмнө Дээд шүүхэд бүртгүүлж, сонгуульд оролцох эрхтэй байдаг.

³⁸ СЕХ бүртгэлийн баримт бичигт улс төрийн намын даргын гарын үсэг зурагдаагүй байна гэж үзжээ. Гэвч шүүхээс өргөдөл гаргагчийг тус улс төрийн намын удирдагчдын нэг үзсэн бөгөөд холбогдох хуулиар дор хаяж нэг удирдагч нь бүртгэлийн баримт бичигт гарын үсэг зурсан байхыг шаарддаг. Хөдөлмөрийн үндэсний намыг бүртгэлийн баримт бичиг нь зөрчилтэй гэдэг үндэслэлээр бүртгээгүй.

³⁹ Гурван нэр дэвшигч ял шийтгүүлж байсан гэсэн бүртгэлтэй, гурав нь татварын өртэй, эсвэл хугацаа хэтэрсэн зээл, татварын өртэй эсэх тухай шүүхийн лавлагаа байхгүй, нэг нь төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдөөгүй, нэг нь өөр улс төрийн намын гишүүн хэвээр, гурав нь дэмжигчдийн гарын үсгийн тоо гүйцээгүй, хоёр нь бүртгэлийн баримт бичиг дутуу гэсэн үндэслэлтэй байлаа.

⁴⁰ СЕХ-ноос гаргасан нэр дэвшүүлэхээс татгалзсан шийдвэр нь түүний ял шийтгэлтэй гэх бүртгэлийг үндэслэсэн. Цагдаагийн газраас СЕХ-нд өгсөн лавлагаагаар түүний үйлдсэн гэмт хэргийн нэг нь 2015 оны Өршөөлийн тухай хуулиар өршөөлд хамрагдахгүй учраас ял шийтгэлтэй эсэх тухай бүртгэл нь хэвээр байгаа бөгөөд 2017 оны 8-р сард дуусна гэж тайлбарлав.

⁴¹ Нэхэмжлэгч нь хоёр тусдаа шүүхэд нэгэн зэрэг гомдол гаргасан. Нэг нь цагдаагийн тодорхойлолтыг, нөгөө нь СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцсэн бөгөөд хэдэн долоо хоногийн турш хэд хэдэн хурал болж байв. Гэвч уг хэрэг нь 2016 оны 7-р сарын 4-ний өдөр шүүхээс эхний хэлэлцүүлгээр хүчингүй болсон.

⁴² Ихэнх хэрэг нь нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй тухай байв. МАХН-ыг өөрийн нэр дэвшигчийн материалыг хуулийн хугацаа дууссан хойно СЕХ-нд ирүүлсэн гэж үзсэн бол, нэг бие даан нэр дэвшигч нэгэн улс төрийн намыг зориуд сонгогчдын төөрөгдүүлэх зорилгоор адил нэртэй хүнийг нэр дэвшүүлсэн гэж гомдол гаргасныг хянан хэлэлцэхээс тус тус татгалзсан байна.

СЕХ-нд нэр дэвшигчдийг бүртгэх, мөн шүүхээр давж заалдаж буй аливаа хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хангалттай хугацаа олгохыг баталгаажуулахын тулд нэр дэвшигчдийг дэвшүүлэх хугацааг сонгууль зохион байгуулахаар товлон зарлах өдөртэй ойролцоо байлгах нь зүйтэй.

Нийт 498 нэр дэвшигч бүртгэгдсэн бөгөөд 69 нь бие даагч байв. Зөвхөн АН болон МАН бүх тойрог дээр өрсөлдөв. 10 ба түүнээс дээш өрсөлдөгчтэй хэд хэдэн тойрог дээр өрсөлдөөн ширүүн явагдлаа. Зөвхөн 2-хон өрсөлдөгчтэй 2 тойрог байсан. Бүх улс төрийн нам 20 хувийн жендэрийн квотыг мөрдсөн бөгөөд АН, МАН-аас нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн хувь хамгийн бага байв. Хоёр намаас нэр дэвшигчдийн 21 хувь нь эмэгтэйчүүд байв. Бусад жижиг намууд эмэгтэйчүүдийг нэлээд өндөр хувиар нэр дэвшүүлсэн байна.⁴³ Ерөнхийдөө 129 нэр дэвшигч (26 хувь) нь эмэгтэй байсан бөгөөд тэдгээрийн 13 нь бие даагчид (19 хувь) байв. Сонгуулийн тойргийн гуравны нэгээс илүү хувь дээр эмэгтэй нэр дэвшигч байсангүй. Жендэрийн квотыг хангахын тулд хэд хэдэн улс төрийн нам ялах магадлал багатай тойргууд дээр эмэгтэй нэр дэвшигчдийг дэвшүүлсэн гэж зарим хүмүүс мэдэгдсэн.

СТХ-иар чанга яригчийг 23:00 цагаас хойш ашигласан зэрэг бага хэмжээний зөрчил гаргаж, сонгуулийн сурталчилгааны журмыг зөрчсөн бол шүүхийн шийдвэр дээр үндэслэн нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах эрхийг СЕХ-нд олгосон боловч төрийн байгууллагын өмч хөрөнгийг буруугаар ашиглан ноцтой зөрчил гаргасан тохиолдолд бүртгэхээс татгалзах эрх олгогдоогүй. Сонгогдсон нэр дэвшигчдийг сонгуулийн дараа тангараг өргөх өдөр хүртэл бүртгэлээс хасаж болох бөгөөд энэ нь ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагены Баримт бичгийн 7.9 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.⁴⁴

Сонгогдох эрхийг хамгаалах, мөн тэнцвэртэй байдлыг хангахын тулд СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, нэр дэвшигчдийг сонгуулийн сурталчилгаатай холбоотой бага хэмжээний зөрчлийн улмаас бүртгэлээс хасахгүй байхыг баталгаажуулах нь зүйтэй. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалттай нийцүүлэн, хангалттай тооны санал авч, зохих ёсоор сонгогдсон нэр дэвшигчдийн бүртгэлийг хүчингүй болгох заалтуудыг хасах талаар анхаарах нь зүйтэй.

Сонгууль болохоос нэг долоо хоногийн өмнө СЕХ нь нэг бие даан нэр дэвшигч, МАХН-ын нэг нэр дэвшигчийг санал худалдан авах гэсэн, мөн МАХН-ын өөр нэг нэр дэвшигчийг сурталчилгааны материалдаа шашны билэг тэмдэг ашигласан гэх үндэслэлээр бүртгэлээс хасав.⁴⁵ Бүртгэлээс хасагдсан нэр дэвшигчдийн нэртэй саналын хуудас аль хэдийн хэвлэгдсэн байсан бөгөөд санал авах байрны ажилтнуудад эдгээр нэр дэвшигчдийг хасагдсан гэдгийг сонгогчдод мэдэгдэх заавар өгчээ.⁴⁶ Гэвч шашны билэг тэмдэг ашигласан гэх нэр дэвшигчийг санал авах өдрийн тал нь өнгөрсөн хойно бүртгэлээс хассан нь тухайн нэр дэвшигчийн төлөө саналаа өгсөн нэг мянга орчим сонгогчийн саналыг хүчингүйд тооцоход хүргэв.

Сонгогчдын саналыг хасаж, хүчингүй болгохоос сэргийлэхийн тулд СТХ-иар санал хураалт эхэлснээс хойш нэр дэвшигчийг бүртгэлээс хасахыг болиулж, саналын хуудсуудыг хэвлэснээс

⁴³ Жишээ нь, Иргэний Хөдөлгөөний Нам 12 эмэгтэйг нэр дэвшүүлсэн ба энэ нь намаас нийт нэр дэвшигчдийн 44 хувийг төлөөлж байв.

⁴⁴ 7.9 дэх заалтад Гишүүн улсууд нь “хуульд заасан хангалттай тооны санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцон баталгаажуулна” гэж заасан байдаг. ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагений Баримт бичгийн 24 дэх хэсэгт “эрх, эрх чөлөөг хязгаарлах хязгаарлалтууд нь тухайн хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэжээ.

⁴⁵ Энэ хэрэг нь уг нэр дэвшигч сурталчилгааны материалдаа Монгол Улсын шашны хамба ламтай хамт авахуулсан зургаа Бурхан багшийн дүрстэй дэвсгэр дээр хэвлүүлсэн байв.

⁴⁶ СТХ-нд бүртгэлээс хасагдсан нэр дэвшигчийн ямар ч саналын хуудсыг тоолохгүй гэж заажээ. СЕХ-ноос өгсөн мэдээллээр 58 болон 11-р тойргуудад дэвшсэн нэр дэвшигчид 595, 239 саналыг тус тус авчээ.

хойш аливаа нэр дэвшигчийг бүртгэлээс хассан эсэх тухай ерөнхий бүртгэл лавлагааг шаарддаг байх нь зүйтэй.

IX. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ОРЧИН

СТХ-иар зөвшөөрөгдөөгүй бүх төрлийн сонгуулийн сурталчилгааг хориглосон нь сонгуулийн сурталчилгааны хүрээг хэтэрхий хязгаарлан нарийвчилсан шаардлагууд тогтоож өгсөн бөгөөд энэ нь УИХ-ын сонгуулийн тухай өмнөх хуультай харьцуулахад эсрэг алхам болсон.⁴⁷ СТХ-нд сонгуулийн сурталчилгааг хэн, хэзээ, хэрхэн хийх ёстойг нарийвчлан зааж өгсөн.⁴⁸ Үндэсний аудитын газар (ҮАГ) нь улс төрийн намууд болон нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг эдийн засаг ба хөгжлийн тухай хууль, бодлогод нийцэж байгаа эсэхийг шалган урьдчилан батлах ёстой.⁴⁹ Батлагдсан мөрийн хөтөлбөрөөс гадуур сурталчилгаа хийхийг хориглосон. Аудит хийхэд тавигдах бодит, ил тод шалгуур гэж байхгүй бөгөөд үнэлгээний бодит дүнг олон нийтэд мэдээлдэггүй. ҮАГ-аас ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлэхдээ сонгуулийн мөрийн хөтөлбөрүүд нь эхэндээ бүгд шаардлага хангаагүй ба батлагдахаасаа өмнө зохих засвар өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байсан гэв. Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг болон улс төрийн олон эшт үзлийг шаардлагагүйгээр хязгаарлаж байгаа юм. Түүнчлэн хуулийн хүрээний зарим заалтаар сонгуульд албан тушаал хашиж буй хүмүүсийн өөрийн ололт амжилтыг сурталчилсан материалыг сонгуулийн сурталчилгааны материал гэж үзэхгүй байсан нь сонгуульд дахин өрсөлдөж байсан УИХ-ын гишүүдэд ашигтайгаар нөлөөлж байв.⁵⁰ Мөн жижиг намууд болон улс төрд шинээр орогсодод ашиггүй нөхцөл бүрдүүлж буй хуулийн нэмэлт заалтууд байна.⁵¹ 2015 оны 12-р сард батлагдсан СТХ-иар албан ёсны сонгуулийн сурталчилгааны хугацааг 21-ээс 17 хоног болгон богиносгосон.

СТХ-нд сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааг явуулах журамд тавигдах шаардлагуудыг багасгах, мөн сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчдийг сурталчилгаа хийх эрх тэгш нөхцөлөөр хангах нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

СЕХ нь нэр дэвшигчид болон сонгуулийн сурталчилгаа явуулж буй эрх бүхий хүмүүсээс хууль бус сурталчилгаа явуулсан үндэслэлээр хариуцлага хүлээхгүйн тулд сонгуулийн сурталчилгааны шинэ журам, хязгаарласан шаардлагуудыг тайлбарлахыг хүссэн 40 орчим

⁴⁷ Өмнөх хуулинд холбогдох хуулиар хориглоогүй сонгуулийн бүх сурталчилгааг зөвшөөрнө гэсэн заалт байв.

⁴⁸ Жишээ нь, СТХ-нд сонгуулийн сурталчилгааны байр, сурталчилгаа явуулах хүмүүсийн тоог хязгаарласны зэрэгцээ сурталчилгаа явуулж буй хүмүүс, ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийг бүгдийг нь сонгуулийн байгууллагад бүртгүүлэхийг шаардаж, сурталчилгааны штабын ажилтнууд болон сурталчилгаа хийж буй бүх хүмүүсийг сайн дураар ажиллах үүрэг өгч, сурталчилгааны материалын хэмжээ, хуудасны тоог хязгаарлахаас гадна сурталчилгаа явуулах арга, барилын талаар хэтэрхий нарийвчилсан урт жагсаалтыг гаргажээ.

⁴⁹ Мөрийн хөтөлбөрүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бодлогын баримт бичиг болох “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030”-д тус тус нийцүүлсэн байх ёстой.

⁵⁰ Энэ хуулийн заалтаар УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгч, эсвэл орон нутгийн төлөөлөгч нэр дэвшиж байгаа тохиолдолд өөрсдийн хийсэн ажлын тайланг сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө болон сонгуулийн сурталчилгаа дууссан хойно тарааж болно; тэдний хийж гүйцэтгэсэн ололт амжилтыг сурталчилсан материал нь сурталчилгааны материалын хэмжээ, хэлбэрт хамаарахгүй; мөн тэдний материал нь сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаарт хамрагдахгүй.

⁵¹ Жишээ нь, сонгуулийн сурталчилгааны хугацаа богино, сонгуулийн сурталчилгааны ажилтны мөрдөх заалтууд хатуу чанд, мөн төсвийн санхүүжилт зөвхөн парламентад суудалтай намуудад хуваарилагдаж байгаад ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-той уулзсан хүмүүс санаа зовниж байв.

хүсэлтийг хүлээн авчээ.⁵² Гэвч СЕХ нь тодорхой удирдамж өгөхөөс ерөнхийдөө татгалзжээ.⁵³ Харин өөрийн санаачилгаар СЕХ нь “мэргэжил, арга зүйн зөвлөгөө” болгож сонгуулийн сурталчилгааны зарим дүрэм журмыг боловсруулсан боловч энэ нь бодит байдал дээр сурталчилгааг улам хязгаарласан.⁵⁴

Сонгуулийн сурталчилгааны хатуу чанд заалтуудаас үл хамааран, нэр дэвшигчид өөрсдийн үзэл бодлыг сонгогчдод хүргэх боломжтой байсан бөгөөд жагсаал цуглаан хийх болон эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн. ЕАБХАБ/АИХЭГ-т нэр дэвшигчдийг ямар нэг газарт оруулахыг татгалзсан, эсвэл сурталчилгааны үйл ажиллагааг төрийн байгууллагын зүгээс саад хориг хийсэн тухай мэдээлэл ирээгүй. Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа эхлэхээс өмнөх орчин ерөнхийдөө тайван байсан, харин 5-р сарын сүүлээр МАХН-ын даргыг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр СЕХ-ноос гаргах магадлалтай гэж МАХН өлсгөлөн зарлахад байдал хурцадсан. Өлсгөлөн 3 хоногийн дараа зогссон.

Сонгуулийн сурталчилгаа нь 2016 оны 6-р сарын 11-ээс эхэлсэн бөгөөд ажилгүйдлийг бууруулах, орлого нэмэгдүүлэх, авилгатай тэмцэх, нийгмийн хамгааллыг сайжруулах гэх намуудын амлалт болон эдийн засаг, нийгмийн асуудлууд дээр төвлөрсөн бөгөөд улс төрийн томоохон намуудын хооронд үзэл суртлын тодорхой ялгаа байсангүй. Улс төрийн тоглогчид өөрсдийн үзэл баримтлалыг хүргэхийн тулд янз бүрийн арга замыг ашиглаж байв. Сонгуулийн өдрийг хүртэл сонгуулийн сурталчилгааны зурагт хуудас, зарлалын самбарууд хотын төв хэсгээр ихэссэн. Гэвч нэр дэвшигчдийн сурталчилгааны материалыг үзэмжгүй болгож, доромжилсон тохиолдол олон гарчээ.⁵⁵ Улс орон даяар хэмжээ, цар хүрээгээрээ ялгаатай хурал цуглаанууд өрнөж, хаалганаас хаалганд сонгуулийн сурталчилгаа идэвхтэй явагдаж өнгөрөв.⁵⁶ АН болон МАН-ын сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаа илүү ойр ойрхон болж, оролцогчдыг ихээхэн татаж байсан хэдий ч жижиг намууд болон бие даан нэр дэвшигчид мөн хурал цуглаан хийсэн. Өрсөлдөгч намуудын дэмжигчдийн хооронд хурцадмал байдал үүссэн талаар хэд хэдэн мэдээлэл гарч байсан боловч хурал цуглааны үеэр нөхцөл байдал ерөнхийдөө тайван байлаа.⁵⁷ Улс төрийн тоглогчид сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх цагийг худалдан авсан байв. МАН болон АН-ын улс төрийн төлбөртэй сурталчилгааны нэвтрүүлэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр давамгайллаа.⁵⁸ Нийгмийн сүлжээгээр ч сонгуулийн сурталчилгаа

⁵² Жишээ нь, нэгэн нэр дэвшигч малаа бэлчээрлүүлэхээр тойргийн хилийг давсан өөрийн тойргийн сонгогчидтой уулзахын тулд тойргийнхоо хилийг давах эсэхээ асууж байсан. Өөр нэг нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаанд ашиглаж буй тээврийн хэрэгслийн жолооч нарыг сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий хүмүүсийн тоонд оруулж тооцох эсэхийг тодруулахыг хүсэж байв.

⁵³ Ихэнх тохиолдолд СЕХ нь хуулийн зүйл заалтыг иш татаж, эсвэл хуулийг тайлбарлах эрхгүй гэдгээ тэмдэглэж байснаас гадна хуулийг зөрчсөн эсэхийг шүүхээс эцэслэн шийднэ гэж мэдэгдэж байв.

⁵⁴ 2016 оны 6-р сарын 8-нд СЕХ нь бүх улс төрийн намууд болон бие даан нэр дэвшигчдэд хандан “мэргэжил, арга зүйн зөвлөгөө”-тэй холбоотой захидал илгээсэн. Захидалд сонгуулийн сурталчилгаанд оролцогчдыг бүртгүүлэх бүх бичиг баримтыг 6-р сарын 10-наас хоцроолгүй ирүүлэх ёстой бөгөөд бүртгүүлсэн улс төрийн намын сонгуулийн сурталчилгааны ажилтнууд нь намынхаа нэр логог, харин бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны ажилтнууд нь “бие даан нэр дэвшигч” гэсэн бичгийг зүүсэн байна гэжээ.

⁵⁵ Цагдаагийн ерөнхий газар сонгуулийн сурталчилгааны материалыг сүйтгэж доромжилсон тухай 400 гаруй гомдол хүлээн авчээ.

⁵⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь 42 хурал цуглааныг ажигласан (АН-ын 17, МАН-ын 16, жижиг намуудын 6, бие даан нэр дэвшигчдийн 3). Ажиллалт хийгдсэн арга хэмжээнүүдэд оролцсон оролцогчид дундажаар 338 байв. Зарим цуглаан 1,000 хол давсан оролцогчтой ч болж байхад зарим нь ач холбогдол багатай буюу сонгуулийн сурталчилгааны ажилтнууд нь оролцогчдоосоо давж байв.

⁵⁷ Жишээлбэл, 6-р сарын 18-нд Увс аймагт болсон АН-ын хурлын үеэр эмх замбараагүй байдал үүсэж, цагдаагийн албан хаагчид эсэргүүцэгчдийг салгасан байна. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь турхирсан асуулт тавьж буй тохиолдлуудтай таарч байсан бөгөөд нэг тохиолдол дээр АН-ын цуглаанд оролцогчид нэр дэвшигчийг шүүмжилж байсан тул цуглааныг шууд зогсоожээ.

⁵⁸ Хэвлэл мэдээлэлд хийсэн ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны мониторингоор сонгуулийн сурталчилгааны оргил үеэр МАН, АН цацагдсан төлбөртэй нэвтрүүлгийн цагийн 43, 40 хувийг тус тус худалдан авсан байна. МАХН 14 хувьтай гуравт орсон байна.

явагдаж байсан бөгөөд цахим сурталчилгаанд өндөр албан тушаалтай нэр дэвшигчдийг хууль бус арга хэмжээнд оролцож буй гэсэн утга бүхий хэд хэдэн бичлэг цацагдсан. Үүний улмаас сонгуулийн өмнө, мөн сонгуулийн дараа шүүх, хууль сахиулах байгууллагуудад өргөдөл гаргацгааж, сонгуулийн сурталчилгааны уур амьсгалыг хурцатгасан.⁵⁹ Цагдаагийн байгууллагаас тодорхой нэр хаяггүй, гүжирдсэн хэд хэдэн сонгуулийн сурталчилгааны талаар ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд мэдээлсэн.

Сонгуулийн сурталчилгааны цар хүрээ өргөн хүрээнд хэлбэлзэж байв.⁶⁰ Ерөнхийдөө жижиг намуудын нэр дэвшигчид болон бие даан нэр дэвшигчид нь улс орны бизнесийн элит хэсгийн олонхийг төлөөлж байсан МАН, АН-ын нэр дэвшигчид шиг илэрхий байсангүй. Эдгээр тойрог дээр сонгогчдыг олноор нь шилжүүлсэн, санал худалдан авсан хэмээн сэжиглэх явдал нилээд гарч байв.⁶¹

2016 оны 6-р сарын 9-нд иргэдэд өмнө нь үнэ төлбөргүй хуваарилсан төрийн өмчит уурхайн хувьцааны 30 хувийг буцаан худалдаж авахаар Засгийн газар шийдвэр гаргав.⁶² Хөдөө орон нутаг бүрт нэр дэвшигчдээс, эсвэл тэдний нэрийн өмнөөс өмч хөрөнгийг үнэ төлбөргүй тараах амлалтууд гарсан тухай мэдээллүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд ирж байв.⁶³ 2016 оны 6-р сарын 28-нд эрх баригч нам олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд томоохон хэмжээний амлалт өгөв.⁶⁴ Эдгээр алхам нь санал худалдан авах гэсэн гэж сэжиглэгдэн, оролцогч талуудаас эрх бүхий байгууллагуудад хандан гомдол гаргах явцыг өдөөжээ.⁶⁵ Төрийн ба орон нутгийн засаг захиргааны зааг ялгааг бүдгэрүүлж, сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааг заримдаа засгийн газрын болон төрийн өмчийн байруудад, зөвхөн ажилтнуудыг оролцуулахаар зохион байгуулж буй сонгуулийн сурталчилгаа ч ажиглагдсан.

Төрийн захиргааны байгууллагын болон улс төрийн сурталчилгааны заагийг ялгаж салгах алхмыг хийх шаардлагатай. Улс төрийн албан тушаалтнууд нь өөрсдийн сонгуульд үүрэг хариуцлага болон сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаагаа хуулиар хатуу ялган тусгаарлаж байх үүрэг хүлээх ёстой бөгөөд төрийн байгууллагын өмч хөрөнгийг буруугаар ашигласан тохиолдолд оногдуулах шийтгэлийн үр дүнтэй механизмыг бий болгох нь зүйтэй.

Эмэгтэйчүүд сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажигласан хурал цуглааны үеэр хүрэлцэн ирсэн оролцогчдын 53 хувь нь эмэгтэйчүүд байсан бөгөөд илтгэгчийн үүднээс бус ихэнхдээ оролцогчийн үүрэгтэй байв. Ажиглалт хийсэн 42 хурал цуглаан дээр 13 нь л эмэгтэй илтгэгч байлаа. Эмэгтэйчүүдийн

⁵⁹ Улс төрийн томоохон хоёр намын нэр дэвшигчдийн дуун болон дүрс бичлэгүүд нь тэдгээр бичлэгт орсон хувь хүмүүсийн дүр төрх, нэр хүндэд нэлээд сөргөөр нөлөөлсөн гэж үзсэн байна.

⁶⁰ Нэгэн жижиг намын даргын дурдсанаар нам нь нэр дэвшигч бүртээ 40 сая орчим төгрөг (18,000 евро) зарцуулсан гэжээ. Бусад намуудад илүү өндөр тооцоо гарсан мэдээлэл ирсэн бол, зарим нэр дэвшигчдэд санхүүжилт байхгүйгээс сонгуулийн сурталчилгааг идэвхтэй явуулахгүй байгаагаа хэлж байлаа.

⁶¹ Жишээ нь, Баянхонгор, Хөвсгөл, Увс аймгуудад.

⁶² 2012 оны 4-р сард Засгийн газар иргэн бүрт *Эрдэнэс Таван Толгой* төрийн өмчит нүүрсний компанийн 1,072 ширхэг хувьцааг олгоно гэсэн тогтоол гаргасан. Засгийн газрын 6-р сарын 9-ний өдрийн шийдвэрийн дараа сонгуулийн насны 1.65 сая иргэн өөрсдийн хувьцааны 30 хувийг зарах эрхтэй болсон бөгөөд 1.2 сая орчим иргэн нийт 300,426 төгрөг (ойролцоогоор 150 евро)-өөр зарахаар өргөдөл гаргажээ.

⁶³ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд тэмдэглэгдсэнээр *Зэс Эрдэнийн Хувь ХХК*-ийн хувьцааг Эрдэнэт хотын 44,000 орчим иргэдэд үнэгүй тараана гэсэн товхимол тарааж байв. АН-ын нэг нэр дэвшигч тус компанитай холбоотой байв.

⁶⁴ 2016 оны 6-р сарын 28-нд АН-ын нэр дэвшигч Ерөнхий сайд эмнэлэг, цахилгаан станцуудад томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийхийг дэмжиж, Монгол-Оросын хамтарсан зэс боловсруулах *Эрдэнэт* үйлдвэрийн 49 хувийг худалдан авсан тухай мэдэгдсэн. Худалдан авагч нь нэгэн хувийн компани байсан бол, сонгууль болохоос нэг өдрийн өмнө ийм мэдэгдэл хийсэн нь АН-д нааштай хандсан гэж үзэж байв.

⁶⁵ 2016 оны 6-р сарын 13-ны өдөр Монголын уламжлалын нэгдсэн намаас (СЕХ-нд), мөн оны 6-р сарын 16-ны өдөр ИЗНН-аас Захиргааны хэргийн шүүх, Эрүүгийн хэргийн шүүх болон Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан.

улс төрийн оролцооны асуудал зөвхөн дөрвөн цуглаан дээр л хөндөгдөв. Эмэгтэй нэр дэвшигчдийн зурагт хуудас, сурталчилгааны самбар тавигдсан байсан ч тэдний сурталчилгаа олонд хүрч танигдах нь тухайн нэр дэвшигчийн хувийн санхүүгээс хамаарч байлаа. Томоохон улс төрийн намуудаас дэвшүүлсэн эмэгтэй нэр дэвшигчид хүртэл сонгуулийн сурталчилгаагаа үргэлжлүүлэн явуулах хангалттай санхүүжилт олоход бэрхшээлтэй байсныг мэдээлсэн.

Х. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ

Томоохон улс төрийн намууд ерөнхийдөө гишүүдээ гишүүнчлэлийн татвар төлөхийг шаарддаг бөгөөд аймаг, нийслэлийн намын байгууллагад ажиллаж буй гишүүд нь илүүтэйгээр төлдөг. Түүнчлэн УИХ-д суудалтай намууд парламентын суудлын тоогоороо жилд улсын төсвөөс санхүүжилт авдаг, үүний 50 хувь нь УИХ-ын гишүүн бүр өөрсдийн сонгогдсон тойрогт зарцуулагдах ёстой байдаг.⁶⁶ Уулзаж ярилцсан хүмүүс энэ санхүүжилтийн зарим хэсэг нь тухайн гишүүний хийсэн ажлыг сурталчлан таниулах материал хэвлүүлэхэд ашиглагддаг гэж байв.

Сонгуулийн сурталчилгааг хандиваар болон/эсвэл нэр дэвшигчийн өөрийн орлогоор санхүүжүүлнэ. СТХ-иар хандивын хэмжээг иргэний хувьд 3 сая төгрөг, хуулийн этгээдийн хувьд 15 сая төгрөг байхаар хязгаарлаж өгчээ.⁶⁷ Үйлдвэрчний эвлэл, шашны ба төрийн бус байгууллагууд болон гадаадын этгээдээс хандив авахыг хориглосон. Бүх гүйлгээ нь сонгуульд зориулагдсан банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой. Улс төрийн нам, эвсэл бүрт улсын хэмжээнд сонгуулийн сурталчилгаандаа зарцуулах зардлын дээд хязгаарыг тогтоосон байхаас гадна нэр дэвшигч болон сонгуулийн тойрог тус бүрт тухайн тойргийн хэмжээ болон газар зүйн байршилтай уялдуулан зардлын дээд хязгаарыг мөн тогтоож өгсөн болно.⁶⁸ Ялангуяа, өөр өөр сонгуулийн тойрогт сонгогч бүрт нэр дэвшигчээс зарцуулах хэмжээг хязгаарласан ихээхэн зөрүү байна.⁶⁹ Сонгуульд өрсөлдөгчид нь зардлын тайлангаа гаргаж өгөх шаардлагатай тул сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой заалтын биелэлтийг зөвхөн сонгууль дууссаны дараа шалгах боломжтой.⁷⁰

Бидний уулзаж ярилцсан хэд хэдэн хүн олон нэр дэвшигчдээс нам нь нэр дэвшүүлэхийн тулд намдаа хандив өгөхийг хүссэн гэдгийг батлан хэлж байв.⁷¹ Хандивын хэмжээ, цар хүрээ нь тодорхойгүй байв. Улс төрийн намуудын өгсөн мэдээллээр сонгуулийн сурталчилгааны үндсэн зардалд сурталчилгааны ажилтнуудад өгөх цалин (үүнийг СТХ-иар хориглосон), телевизээр нэвтрүүлэх сурталчилгаа, сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалууд болон хурал цуглаан зэрэг орно. Улс төрийн намууд, нэр дэвшигчид нийлээд зарцуулсан нийт зардлын хэмжээг дангаар нь тооцож, шалгах боломжгүй байна. Улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны зардлаа санал авах өдрөөс өмнөх хугацаанд сайн дураар олон нийтэд мэдээлээгүй бөгөөд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ноос нэр дэвшигчдэд тавьсан асуулгын дагуу сонгуулийн сурталчилгааны зардлын талаар үнэн зөв мэдээлэл өгч

⁶⁶ Улс төрийн намын тухай хуулиар сонгуулийн дараа УИХ-д суудалтай улс төрийн намууд хүчинтэй саналын тоогоор 1,000 төгрөг (ойролцоогоор 0.44 евро)-ийг нэг дор авах бөгөөд тэдгээр намууд дөрвөн сар тутам УИХ-ын гишүүний тоо тус бүрээр 10 сая төгрөг (ойролцоогоор 4,400 евро)-ийг нэг дор авна.

⁶⁷ Тус бүр ойролцоогоор 1,300 ба 6,600 евро.

⁶⁸ ҮАГ-аас тогтоож өгсөн сонгуулийн сурталчилгааны зардлын дээд хэмжээ нь сонгуулийн тойрог тус бүрт 85 сая төгрөгөөс 225 сая төгрөг (38,000-101,000 евро) хүртэл янз бүр байв. Улс төрийн нам бүр улсын хэмжээнд явуулах сурталчилгаандаа 4,4 тэрбум төгрөг (1,9 сая евро) зарцуулах боломжтой.

⁶⁹ Энэ нь Сэлэнгэ аймгийн 25-р тойрогт 4,171 төгрөг (1.9 евро)-өөс Ховд аймгийн 41-р тойрогт 8,580 төгрөг (3.9 евро) хүртэл харилцан адилгүй байв.

⁷⁰ Нэр дэвшигчид нь сонгууль болж өнгөрсний дараа 30 хоногийн дотор, улс төрийн нам, эвсэл 45 хоногийн дотор сонгуулийн сурталчилгааны зардлын тайлангаа ҮАГ-т хүргүүлэх шаардлагатай.

⁷¹ Уулзаж ярилцсан хүмүүсийн хэлж байснаар иймэрхүү хандив нь 20 сая төгрөг (9,100 евро)-өөс 100 сая төгрөг (45,000 евро)-ийн хооронд хэлбэлздэг.

чадахгүй байв. Санал авах өдрөөс өмнө олон нийтийн хяналтад хамаарах мэдээлэл ерөнхийдөө дутмаг байгаа нь сонгуулийн сурталчилгааны зардлын тайланд ил тод, хариуцлагатай байх явдлыг хязгаарлаж байгаа төдийгүй бүрэн мэдээлэлтэй байж сонголтоо хийх сонгогчдын боломжийг ч хязгаарлаж байна.⁷² Саяхан улс төрийн намын санхүүжилт, түүн дотроо сонгуулийн сурталчилгааны зардлын ил тод байдлын тухай хуулийг батлах оролдого амжилтгүй болсон.⁷³

Ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд сонгуулийн сурталчилгааны зардлын тайлан, түүн дотроо хандивлагчдын нэрсийг оролцуулан олон нийтэд нийтэлж, тэр дундаа цахим хэлбэрээр ч мэдээлж болох юм. Санал авах өдрөөс өмнө сонгуулийн сурталчилгааны зардлын тайланг УАГ-т улирал тутам ирүүлэхийг шаарддаг байхыг ч анхаарч үзэх нь зүйтэй.

Энэ удаагийн сонгуулиар УАГ анх удаа улс төрийн нам болон нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны зардалд аудит хийхээр болсон. УАГ нь 90 хоногийн дотор сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны зардлын тайланг олон нийтэд нийтлэх ба 1 сая ба 2 сая төгрөгөөс дээш хандив өргөсөн иргэд болон хуулийн этгээдийн нэрсийг тус тус нийтэд зарлана.⁷⁴ Гэвч УАГ-т хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгох хууль эрх зүйн чухал зохицуулалтуудыг боловсруулаагүй бөгөөд энэ удаагийн сонгуулийн сурталчилгааны хугацаа дуусах хүртэл УАГ нь сонгуулийн сурталчилгааны зардалд хяналт хийх талаар ямар нэг зохицуулалт, журам зэргийг олон нийтэд мэдээлээгүй.

Нэр дэвшигчдийг шударга, ижил тэгш нөхцөлд өрсөлдөх боломжоор хангахын тулд оногдуулах шийтгэл нь үр дүнтэй бөгөөд тохирсон байх ёстой боловч сонгуулийн сурталчилгааны зардлыг ноцтой зөрчсөн зөрчилд, тухайлбал сурталчилгааны зардлын хязгаарыг зөрчих, мөн сонгуулийн сурталчилгааны зардлын тайланг худал гаргах зэрэгт шийтгэл ногдуулаагүй болно. Сонгуулийн сурталчилгааны зардлын бусад дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд оногдох торгууль харьцангуй бага байна. Түүнчлэн УАГ-т сонгуулийн сурталчилгааны дансанд аудит хийх, санхүүгийн торгууль шийтгэл оногдуулах эрх мэдэл байхгүй.⁷⁵ Гэвч нэр дэвшигчид хориглосон болон нэр нь үл мэдэгдэх хандивлагчаас хандив авсан тохиолдолд нэр дэвшигчийн бүртгэлээс хасагдах бөгөөд хуулийн хугацаанд сонгуулийн сурталчилгааны зардлын тайлангаа өгөөгүй улс төрийн тоглогчдыг дараагийн сонгуульд өрсөлдөхийг хориглодог.

УАГ-т сонгуулийн сурталчилгааны зардлын хяналт, мониторингийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбогдох байгууллагуудаас шаардлагатай санхүүгийн мэдээллийг хүсэлт гаргасан тохиолдолд нэн даруй хүргүүлэхийг шаардах эрхтэй байх зэргээр хангалттай эрх мэдэл, нөөцийг олгох нь зүйтэй. Аудитын шалгалт хийх тодорхой шалгуурыг боловсруулж,

⁷² Нэгдсэн Үндэсний Байгууллагын Авлигын эсрэг конвенцийн 7(3) дахь зүйлд “Улс орон бүр нийтийн сонгуульд албан тушаалд нэр дэвшүүлэх үйл ажиллагааны зардалд, хэрэв боломжтой бол улс төрийн намуудын санхүүжилтэд ил тод байдлыг дээшлүүлэхийн тулд ... зохих хууль эрх зүйн болон захиргааны арга хэмжээ авахад анхаарах нь зүйтэй” гэж заасан байдаг. ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Улс төрийн намын зохицуулалтын тухай Венецийн комиссын удирдамжийн 2011 оны 194-р хэсэгт “Сонгогчид нь намуудын хариуцлагатай байдлыг хангахын тулд улс төрийн намуудад өгсөн санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээллийг авах ёстой” гэж заажээ.

⁷³ 2014 онд УИХ-ын ажлын хэсэг улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл боловсруулахаар байгуулагдсан. 2016 оны 6-р сард АТГ-ын хүсэлтээр ЕАБХАБ-ын Эдийн засаг, байгаль орчны чиглэлийн үйл ажиллагааны газраас Монгол Улсын Авлигын эсрэг судалгааны тайланг гаргасан бөгөөд үүнд улс төрийн намын санхүүжилтийг сайтар зохицуулах хэрэгцээ шаардлага байна гэж дүгнэжээ.

⁷⁴ Тус бүр ойролцоогоор 470 ба 950 евро.

⁷⁵ Ердийн шүүхээс цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах ажиллагаанд үндэслэн СТХ-нд заасан санхүүгийн бүх торгууль шийтгэлийг оногдуулдаг. ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Улс төрийн намын зохицуулалтын тухай Венецийн комиссын удирдамжийн 2011 оны 214-р хэсгийг үзнэ үү.

тэнцвэртэй бөгөөд урьдчилан сэргийлэхүйц шийтгэлийг оногдуулах эрх мэдлийг ҮАГ-т олгох нь зүйтэй.

XI. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

A. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ОРЧИН

Хэвлэл мэдээллийн салбар нь ил тод ажиллаж байгаа хэдий ч улс төрийн ашиг сонирхлоос улбаалан бие даасан байдал дутагдаж байна. Хэвлэл мэдээлэл болон улс төрийн тоглогчид хоорондоо холбоотой байдаг бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл бүрхэг, тодорхой бус байна. Зар сурталчилгааны зах зээл хязгаарлагдмал хэдий ч 3 сая хүн амд зориулан 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байна. 76 мэдээлэл авах гол эх үүсвэр нь телевиз байсаар, хэвлэмэл мэдээллийн хэрэгслийн эрэлт буурч байгаа бол, хот суурин газарт интернет болон нийгмийн сүлжээний харилцах хэрэгслүүд мэдээ мэдээлэл солилцох өөр нэг сонголт болж байна. Интернетэд нэвтрэхэд ямар нэг хязгаарлалт байхгүй боловч мэдээ, мэдээллийн цахим сайтуудын үйлчилгээ үзүүлэгч компаниудыг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-нд бүртгүүлж, хүнийг доромжилсон утга агуулгатай тайлбар, сэтгэгдлүүдийг хянаж, устгах програм хангамжийг ашиглахыг шаардаж байгаа нь интернетийн эрх чөлөөний тухай олон улсын сайн туршлагатай нийцэхгүй байна.⁷⁷

2006 оноос хойш Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нь олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний байгууллага болж өөрчлөгдсөн бөгөөд хөдөө орон нутагт олон хүнд хүрдэг. MNB телевиз нь телевизийн хоёр, радиогийн таван сувагтай. 2016 оноос хойш нэг суваг нь дан ганц мэдээ, мэдээлэлд зориулагдах болсон. Удирдах зөвлөл нь 15 гишүүнээс бүрдэх ба гишүүдийг нь УИХ (7), Ерөнхийлөгч (4), Засгийн газар (4)-аас тус тус нэр дэвшүүлдэг. Радио, телевизийн тухай хуулинд удирдах зөвлөлийг нь томилох зэргээр өргөн нэвтрүүлгийн редакцийн хараат бус байдлыг хангах арга хэмжээнүүдийг зааж өгсөн байдаг.

B. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хяналт тавих, түүнчлэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хааж хязгаарласан хууль тогтоомжууд батлахыг хориглодог.⁷⁸ Хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомж нь ерөнхийдөө хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрүүл зөв орчинг ханган баталгаажуулдаг.

Сонгуулийн үеэр хүний нэр төрийг гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах зэрэг нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно. Олон улсын хэм хэмжээ болон сайн туршлагаар улс төрчид рүү чиглэсэн шүүмжлэлийн байж болох хэмжээ хязгаар нь жирийн иргэдийнхээс илүү өргөн хүрээнд байдаг гэж үздэг. Тиймээс олны танил хүмүүс хэвлэл мэдээллийн хяналтад илүү ойр

⁷⁶ 2016 оны 6-р сарын 11-ний байдлаар [Харилцаа холбооны зохицуулах хороо](#) нь 93 TV-ийн суваг, 100 радио станц, 90 кабелийн TV-ийн сувгийн жагсаалтыг гаргажээ.

⁷⁷ НҮБ-ын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай Тусгай илтгэгч, ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгчийн газар (ХМЭЧАЭТГ), Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай Америкийн орнуудын Тусгай илтгэгчийн байгууллага, Хүний болон ард түмнүүдийн эрхийн тухай Африкийн комиссын Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах эрх чөлөөний тухай Тусгай илтгэгч нарын [Үзэл бодлоо илэрхийлэх ба Интернетийн тухай 2011 оны хамтарсан тунхаглал](#) -ыг харна уу.

⁷⁸ Хэвлэл мэдээллийг зохицуулах бусад хууль тогтоомжид Олон нийтийн радио телевизийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, СТХ зэрэг багтана.

байна гэдгээ ойлгон, нилээд тэвчээртэй бас нээлттэй байх ёстой.⁷⁹ Үүнээс гадна хүний нэр төрийг гутаан доромжилсон бол өндөр торгууль ноогдуулдаг.⁸⁰ Ийм зохицуулалт нь хувийн цензурыг бий болгодог. ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч (ХМЭЧАЭТ)-өөс ЕАБХАБ-ын гишүүн улс орнуудад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болгох үүднээс гүтгэх хэрэг зөрчилд эрүүгийн ял шийтгэл ногдуулахгүй байхыг дэмжин сайшаадаг.⁸¹

Сонгуулийн үеэр улс төрчдийн нэр төрийг хамгаалах зорилготой нэр төрийг гутаахад ял шийтгэл ноогдуулах тухай эрүүгийн хуулийн заалтууд, түүнчлэн сонгуулийн үеэр гүтгэлэг, худал мэдээлэл тараасан зэрэгт ноогдуулдаг шийтгэлүүдийг хүчингүй болгох нь зүйтэй.

СТХ-иар сонгуулийн сурталчилгааны үеэр хэвлэл мэдээллийг мэдээний болон мэтгэлцээний нэвтрүүлэг явуулах шаардлагуудыг зохицуулсан байдаг. Мэдээний хөтөлбөрийг радио, телевиз тус бүр дээр нэг улс төрийн намд нэг өдөрт таван минут байхаар хязгаарлаж өгсөн ба мэтгэлцээнд улс төрийн намууд болон бие даан нэр дэвшигчдээс дор хаяж дөрвөн төлөөлөгч оролцуулах ёстой. Орон нутгийн зарим телевизүүд мэтгэлцээн зохион байгуулах гэсэн боловч дөрвөөс бага нэр дэвшигчтэй байсан тул мэтгэлцээнт нэвтрүүлэг хийгдээгүй. СТХ-иар санал авах өдрөөс долоо хоногийн өмнө санал асуулга нийтлэхийг хориглодог ба 24 цагийн өмнө сонгуулийн сурталчилгааг зогсоох тухай зааж өгсөн. Төлбөртэй сонгуулийн сурталчилгааны материал нь энэ тухай тодорхой зааж өгсөн байх ёстой бөгөөд нэг улс төрийн намд нэг өдөрт 15 минут байхаас гадна 60 минутаас хэтэрч болохгүй, мөн мэдээний нэвтрүүлгийн цагаар цацахыг хориглоно. 2016 оны 4-р сарын 26-нд СЕХ болон ХХЗХ хамтран сонгуультай холбоотой нэвтрүүлгийн журам баталсан. *MNV* телевизийг төлбөргүй нэвтрүүлгийн цагийг нэр дэвшигчдэд ижил тэгш нөхцөлөөр олгохыг шаарддаг бөгөөд нэр дэвшигч тус бүрт 15 минутыг олгодог. Энэ нь өдөрт хангалттай их буюу долоо хүртэл цаг болж байсан бөгөөд тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл редакцийн хараат бус байдлаа хэрэгжүүлж чадахгүйд хүргэж байв.

СЕХ, ХХЗХ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) нь сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн байгууллагууд хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих үүрэгтэй боловч цаг тухайд нь үр дүнтэй арга хэмжээ авахад хууль эрх зүйн давхацсан зохицуулалтууд саад болж байна. СЕХ нь хэвлэл мэдээллийн зөвлөлийг СТХ болон СТБТХ-ийн хоорондоо зөрчилдсөн заалтуудын улмаас байгуулаагүй. ХХЗХ нь радио телевизүүдийн төлбөртэй нэвтрүүлгийн цагийн хязгаар дээр мониторинг хийжээ. Сонгуулийн сурталчилгааны үеэр 31 радио телевизэд анхаруулга хүргүүлсэн боловч сонгуулийн өдрийг хүртэл өөр нэмэлт арга хэмжээ аваагүй байна.⁸² Хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг барагдуулах төвлөрсөн арга хэрэгсэл байхгүй учир тэдгээрийг шүүх, цагдаа, СЕХ болон ШӨХТГ гэх газруудад хүргүүлсэн байна. ШӨХТГ-т нийт хэвлэл мэдээлэлтэй холбоотой 24 гомдол ирсэн. Үүнээс талууд харилцан тохиролцох, эсвэл цагдаагийн байгууллагад дамжуулах хэлбэрээр 14-ийг нь хэрэгсэхгүйд тооцжээ. 10 хэрэг дээр шийтгэл оногдуулах талаар зөвлөмж өгсөн байна. 2016 оны 6-р сарын 14-нд ШӨХТГ-аас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ХХЗХ нь МАН-ын нэр дэвшигчийн нэр төрд халдан гутаасан гэх 11 цахим хуудасны хандалтыг хаасан. Улмаар 2016 оны 6-р сарын 16-нд цахим хуудсуудын төлөөлөгчидтэй зөвшилцсөний эцэст ШӨХТГ шийдвэрээ хүчингүй болгож, ХХЗХ-д эдгээр цахим хуудсыг нээхийг мэдэгджээ. 2016 оны 6-р

⁷⁹ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19-р зүйлд өгсөн НҮБХЭХ-ны [Ерөнхий тайлбар No. 34](#) –ийн 38-р хэсгийг үзнэ үү.

⁸⁰ Шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн 14.8.1 дэх заалт сонгуулийн үеэр нэр хүндэд халдсан бол эрүүгийн зөрчил гэж үзэх ба Зөрчлийн тухай хуулийн 7.3.1 дэх заалтаар хувь хүнийг 1,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ.

⁸¹ ХМЭЧАЭТГ-ын [2014 оны 8-р сарын 26](#) болон [2015 оны 7-р сарын 22](#) –ны тайланг үзнэ үү.

⁸² 2016 оны 6-р сарын 22-нд хэвлэл мэдээллийн мониторингийн эхний үр дүнг хянан үзсний дараа ХХЗХ-ноос радио телевизүүдэд 15 анхааруулга явуулсан бол, мөн сарын 28-нд 16 анхааруулгыг нэмж хүргүүлжээ.

сарын 24-ний өдөр МАН-ын нэр дэвшигчийн нэр төрд нь халдан гутаасан гэсэн сэжиглэл бүхий гомдлын дагуу цагдаагийн байгууллага урьдчилан мэдэгдэлгүйгээр хэвлэл мэдээллийн компаний байрыг битүүмжилсэн. Энэ мэт арга хэмжээ нь аливаа шийтгэл нь тохирсон байх зарчимтай нийцэхгүй байна.⁸³

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөгчид СТХ-нд буй тодорхой бус, хоорондоо зөрчилдсөн заалтууд, мөн эрх бүхий байгууллагуудаас тодорхой удирдамж чиглэл өгөхгүй байгаад санаа зовж буйгаа илэрхийлж байв. Жишээлбэл, “улс төрийн чансааг тогтоох зорилготой” мэдээллийг тараах тухайд тавьсан ерөнхий хориг нь санал авах өдрөөс долоо хоногийн өмнө санал асуулгын дүнг олон нийтэд мэдээлэхийг хориглосон тухай хоригтой зөрчилдөж байна. Хэд хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ асуудлыг холбогдох байгууллагуудад нь хандан тавьжээ. Гэвч ШӨХТГ, ХХЗХ-ны аль нь ч тэдгээр хэвлэл мэдээллийн байгууллагуудад тодорхой хариу өгөөгүй нь болзошгүй шийтгэлээс, тодруулбал зургаан сарын хугацаанд зөвшөөрлөө түдгэлзүүлэхээс зайлсхийхийн тулд өөртөө цензур тавихад хүргэж байна.⁸⁴

Аливаа сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлтэй холбоотой бүх зохицуулалтыг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавих, мөн хоорондоо давхацсан зохицуулалтууд үүсгэхээс зайлсхийж, цаг тухайд нь үр дүнтэй арга хэмжээ авч байхын тулд хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүрэг хариуцлага бүхий бие даасан хяналтын нэг төвлөрсөн байгууллагатай байх нь зүйтэй.

С. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Хэвлэл мэдээллийн мониторинг

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны мониторинг хийсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь сонгуулийн мэдээ мэдээллийг өргөн хүрээтэй нэвтрүүлсэн ч зуучлагчийн үүргээ орхигдуулж, гол төлөв улс төрчдөд шууд нэвтрэх боломжийг олгож байв.⁸⁵ Төлбөртэй улс төрийн сурталчилгаа болон үнэ төлбөргүй сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нь редакцийн агуулгыг бүрхэгдүүлж, сонгуультай холбоотой нэвтрүүлгийн дундажаар 71 хувийг эзэлж байв.⁸⁶ Тиймээс сонгогчид мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс бие даасан, аналитик мэдээлэл хүлээн авах боломжоор дутагдаж байв.

Редакцийн бие даасан, хараат бус байдлыг дээд зэргээр баталгаажуулахын тулд мэдээ, мэтгэлцээний талаар тавьсан хязгаарлалтуудыг дахин хянаж үзэх нь зүйтэй. Сонгогчдод бие даасан, хараат бус мэдээ мэдээллийг хүлээн авах боломжийг олгохын тулд хэвлэл мэдээллийн байгууллага редакцийн хяналтаа хэрэгжүүлж чаддаггүй шууд нэвтрэх захиалгат нэвтрүүлгийн цагийг хязгаарлах талаар анхаарч үзвэл зохино.

⁸³ Олон улсын хэм хэмжээний дагуу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой (“Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 19-р зүйл дээр НҮБХЭХ-ээс гаргасан [Ерөнхий тайлбар No. 34](#)-ийг харна уу).

⁸⁴ СТХ-ийн 70.1.6 заалт нь 70.2. дахь заалттай зөрчилдөж байна. 2016 оны 2-р сарын 24-нд СЕХ нь ШӨХТГ-т *Зууны мэдээ* сонинг 2-р сарын 19-ны дугаартаа улс төрийн намуудын удирдагчдын рейтинг харуулсан санал асуулгын дүнг нийтэлсэн нь 70.1.6 дэх заалтыг зөрчсөн гэх гомдлыг нийтэлжээ. *Зууны мэдээ* сонин нь ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд уг хэрэг нь цагдаагийн байгууллагаар шалгагдаж байгаа гэж мэдээлсэн. Гэвч 5-р сарын 27-ны байдлаар сонины газар СЕХ, ШӨХТГ-ын аль алианаас ямар нэг мэдэгдэл хүлээн аваагүй бөгөөд гомдлыг хэн гаргасныг ч хэлээгүй. Энэ мэт тодорхойгүй байдал нь хэвлэл мэдээллийнхэнд зүй бус дарамт шахалтын уур амьсгалыг үүсгэж байв.

⁸⁵ 2016 оны 5-р сарын 26-наас 6-р сарын 29-ний хооронд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь таван телевизийн суваг (МҮОНРТ, Ийгл ТВ, Монгол HD ТВ, ТВ5, ТВ9); радиогийн өглөөний мэдээ (МҮОНРТ-ийн Радио 1); 4 сонин (Өдрийн сонин, Үнэн, Өнөөдөр, Зууны мэдээ); 5 онлайн мэдээллийн хэрэгсэл (ikon.mn, news.mn, polit.mn, shuud.mn, sonin.mn) зэрэгт мониторинг хийв.

⁸⁶ ТВ-ийн сувгуудаар цацагдсан үнэ төлбөргүй болон төлбөртэй нэвтрүүлгийн цагийн хувь нь дараах болно: *MNB TV* (86 хувь), *Eagle TV* (54 хувь), *TV5* (64 хувь), *TV9* (55 хувь). *Mongol HD TV* нь сонгуулийг нэвтрүүлээгүй.

Мониторинг хийгдсэн ихэнх телевизийн сувгууд улс төрийн намуудаас бэлтгэж өгсөн, эсвэл төлбөртэй сонгуулийн сурталчилгааны материалыг дамжуулж байсан нь мэдээ мэдээлэл болон улс төрийн сурталчилгааны зааг ялгааг бүдгэрүүлж байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны хэвлэл мэдээллийн мониторингоор өөр өөр телевизээр ижил төстэй мэдээ мэдээллийг нэвтрүүлсэн тохиолдлууд тэмдэглэгджээ.⁸⁷ СЕХ-нд улс төрийн сурталчилгааны үнийн санал хүргүүлсэн ихэнх радио, телевизийн үнийн саналд мэдээний сурвалжлагын үнэ мөн багтсан байв.⁸⁸ Төлбөртэй мэдээ сурвалжлага нэвтрүүлэх нь сонгуулийн нэвтрүүлгийн эрх зүйн заалтуудаас хазайж сонгогчдыг төөрөгдүүлж байлаа.⁸⁹ СТХ-иар ШӨХТГ нь далд сурталчилгааг хянах үүрэг хүлээдэг боловч чадавх, нөөц дутагдалтайн улмаас ийм зөрчлийг илрүүлж чадаагүй. Харин нөгөө талаас, хэвлэл мэдээллийн мониторинг хийсэн иргэний нийгмийн байгууллагууд мэдээний нэвтрүүлгийн үеэр цацагдсан улс төрийн далд сурталчилгаануудыг илрүүлжээ.⁹⁰

Хэвлэл мэдээллийн хяналтын байгууллагад мэдээний нэвтрүүлгийн үеэр цацагдах далд сурталчилгаатай холбоотой СТХ-д заасан зөрчлүүдийг хянахын тулд чадавх, нөөцөөр хангах нь зүйтэй.

MNB телевиз нь мэдээний нэвтрүүлгийн ихэнх хэсгээ томоохон улс төрийн намууд (АН-д 26 хувь, МАН-д 21 хувь) болон Засгийн газрын үйл ажиллагааны талаар (сонгуультай холбоотой нийт нэвтрүүлгийн 42 хувь нь улсын болон орон нутгийн засаг удирдлагатай холбоотой) маш эерэг өнгө аястайгаар бэлтгэн хүргэж байлаа. Олон нийтийн сувгаар төлбөртэй улс төрийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглосон байдаг. Гэсэн хэдий ч сонгуулийн сурталчилгааны туршид Засгийн газрын ололт амжилтын талаар телевизийн мэдээ мэдээлэл цацагдсан. Гэвч энэ нь хуулийн дагуу сонгуулийн сурталчилгаа гэж үздэггүй. Түүнчлэн олон нийтийн радио ч мөн мэдээний нэвтрүүлгийн дийлэнх хэсгээ гүйцэтгэх засаглалд зориулсан. Бусад улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд мэдээний нэвтрүүлгээс маш бага хэсэг оногдсон.⁹¹

Мониторинг хийгдсэн хувийн радио, телевизүүдийн заримд нь аль нэг талыг баримталсан, төлбөртэй улс төрийн сурталчилгаа мэдээний нэвтрүүлгийн дийлэнх хэсгийг нь эзэлж байв.⁹² Ийгл ТВ-ийн хувьд АН, МАН-ыг сайшааж, тус бүрт нь мэдээний нэвтрүүлгийнхээ 26 хувь, ТВ5 нь МАН-ыг сайшаан мэдээний нэвтрүүлгийнхээ 44 хувь, ТВ9 нь МАХН-ыг сайшаан, мэдээний нэвтрүүлгийнхээ 28 хувьд гаргажээ. Эдгээр гурван телевизийн сувгийн мэдээний нэвтрүүлгийн өнгө аяс нь хоёр том намд илүү эерэг хандсан байдалтай байсан. Монгол HD ТВ нь ямар нэг төлбөртэй улс төрийн сурталчилгаа дамжуулаагүйгээс гадна сонгуультай холбоотой мэдээний нэвтрүүлгийг хязгаарлажээ. Монгол HD ТВ-ээс бусад мониторинг хийгдсэн нийт радио телевиз нь нэр дэвшигчдийн дунд мэтгэлцээн зохион байгуулжээ. АН, МАН хамтран нэг удаа *MNB*-ийн мэтгэлцээнд оролцжээ.

⁸⁷ Жишээ нь, МАН-ын Youtube суваг дээрх сонгуулийн материал нь Ийгл ТВ, ТВ5 телевизийн мэдээний нэвтрүүлгээр, түүнчлэн МҮОНРТ-ийн үнэ төлбөргүй нэвтрүүлгийн цагаар давхар цацагдсан байна. 2016 оны 6-р сарын 17-нд МҮОНРТ-ийн оройн 20:00 цагийн мэдээний нэвтрүүлэгч нь АН, МАН-аас ирүүлсэн сонгуулийн материалыг зарлажээ.

⁸⁸ Дөчин гурван ТВ-ийн суваг үнийн саналаа хүргүүлснээс 30-д (70 хувь) нь мэдээний үнийн санал орсон байна.

⁸⁹ Сонгуулийн нэвтрүүлгийн тухай СЕХ ба ХХЗХ-оос гаргасан хамтарсан журмын 2.2-р заалтаар тогтмол мэдээний үеэр сонгуулийн сурталчилгааг явуулахыг хориглосон ба 3.17-р заалтаар далд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон байдаг.

⁹⁰ Шударга сонгуулийн төлөөх Иргэний нийгмийн мониторинг сүлжээ [Глоб Интернетшл Төв](#) таван телевизийн суваг (*MNB*, *TV 9*, *MN25*, *TV 5*, *UBS*)-т мониторинг хийж, сонгуулийн өдрөөс өмнө хоёр тайлан гаргажээ.

⁹¹ Бусад бүх улс төрийн намд *MNB* сувгаар сонгуультай холбоотой мэдээний нэвтрүүлгийн 4 хувь нь оногдсон.

⁹² Төлбөртэй нэвтрүүлгийн цаг, мэдээний нэвтрүүлгийн цагтай харьцах хувь нь дараах болно: *Eagle TV* (54 х 27 хувь), *TV5* (55 хувь х 25 хувь), *TV9* (55 хувь 23 хувь).

News.mn, *Ikon.mn* нь ерөнхийдөө тэнцвэртэй мэдээлэл хүргэсэн байхад бусад онлайн болон сонин хэвлэл зэрэг хэвлэмэл мэдээллийнхний хувьд ижил төстэй туйлшрал харагдаж байв. *Sonin.mn*, *Үнэн* болон *Өнөөдөр* сонин нь МАН-ыг таашаах хандлагатай байсан бол, *Зууны Мэдээ* болон *Polit.mn* нь МАХН-ыг, *Өдрийн Сонин* болон *Shuud.mn* нь АН, МАН-ыг тус тус таашаасан маягтай байлаа.

Мониторинг хийгдсэн мэдээллийн хэрэгслүүдээр эмэгтэй нэр дэвшигчдэд дундажаар мэдээний нэвтрүүлгийн 17 хувь оногдож байсан бөгөөд энэ нь өрсөлдөгчдийн дундах жендэрийн харьцааг илүү харуулж байв. Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээлэл нь сонгуулийн өмнөх өдөр буюу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх хугацааг дагаж мөрдсөн.

ХИ. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө өгсөн зөвлөмжийн дагуу СТХ-иар өргөдөл гомдол гаргах, давж заалдах үйл явцыг тодорхой түвшинд тодруулан өгч, сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх талаар нэгдсэн хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд нэг алхам урагшилсан. Аливаа иргэн, хуулийн этгээд нь “сонгуулийн байгууллагын үйл явц, ажиллагаа”-г хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэхэд сонгуулийн дээд шатны байгууллагад нь хандан 10 хоногийн дотор гомдол гаргах боломжтой. Энэ нь сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаатай холбогдохоос илүүтэйгээр сонгуулийн хороодын шийдвэр, арга хэмжээтэй илүү холбогдож буй уг заалтыг тайлбарлаж байгаа СЕХ-ны тайлбарын дагуу бол өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх сонгуулийн хорооны эрх хэмжээг хязгаарлаж байна. Сонгуулийн хороо нь бүх өргөдөл гомдлыг хүлээн авснаас гурав хоногийн дотор шийдвэрлэх ёстой. СЕХ-ны шийдвэр болон үйлдэл, эс үйлдлийг эсэргүүцсэн нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргах ба улмаар Дээд шүүхэд хандана. Энэхүү шүүхэд нэхэмжлэл гаргах тогтолцоог СТХ-ийг баталсны дараа Дээд шүүхийн зөвлөмж дээр үндэслэн 2016 оны 2-р сард нэмэлт өөрчлөлт оруулан баталсан. СЕХ болон бусад оролцогч талуудтай энэ нэмэлт өөрчлөлтийг оруулахдаа зөвлөлдөөгүй.⁹³ Үндсэн хуулийн цэц нь сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой хэргүүд Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхэд, мөн СЕХ-оос гарч буй шийдвэрүүд, УИХ-ын сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргаж буй шийдвэрүүдийн талаар анхаардаг.

СТХ-иар СЕХ болон доод шатны хороод нь өргөдөл гомдлыг нээлттэй хуралдаанаар шийдвэрлэж, олон нийтэд шийдвэрээ мэдээлэх ёстой байдаг. Бодит байдал дээр ихэнх өргөдөл гомдлыг СЕХ-ны дарга, нарийн бичгийн дарга, эсвэл хорооны ажилтан албан бичгээр, утсаар болон хувийн холбоогоор холбогдон шийдвэрлэсэн байна.⁹⁴ СЕХ-ны хэмжээнд авч хэлэлцсэн нилээд хэдэн өргөдөл гомдлыг албан журмын дагуу шийдвэрлээгүй. Түүнчлэн өргөдөл гомдлын агуулга, тэдгээрийг шийдвэрлэсэн тухай бодит мэдээллийг олон нийтэд хүргэсэнгүй.⁹⁵

СЕХ нь санал авах өдөр болохоос өмнө УИХ-ын сонгуультай холбоотой 50 орчим өргөдөл гомдлыг хүлээн авсан. Эдгээр нь нэр дэвшигчийн бүртгэл, сонгуулийн хороодын томилгоо,

⁹³ СТХ-ийг батлагдах үед СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцсэн нэхэмжлэлийг Дээд шүүхэд шууд мэдүүлэн, эхний ээлжинд 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх, дараагийн удаа 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэхээр зааж өгчээ.

⁹⁴ Жишээ нь, доод шатны сонгуулийн хороодын бүтэцтэй холбоотой хоёр өргөдлийг СЕХ-ны ажилтан шийдвэрлэж, аман хариу өгсөн.

⁹⁵ СЕХ нь улирал тутамд өөрийн цахим хуудсанд хүлээн авсан өргөдөл гомдлын тоог мэдээлдэг боловч өөр мэдээлэл нийтэлдэггүй. Сонгуулийн хугацаанд ч ямар нэг мэдээлэл шинэчлэгдэн тавигдаагүй. Хүлээн авсан өргөдөл гомдлын агуулга, өгсөн хариуг СЕХ нь нууц гэж үздэг.

сонгуулийн сурталчилгаатай холбоотой зөрчил, санал худалдан авах, сонгогчдыг олноор нь шилжүүлсэн тухай болон бусад асуудалтай холбоотой байв. Доод шатны хороод сонгуулийн өдөр болохоос өмнө цөөн гомдол хүлээн авсан бөгөөд эдгээрийн зарим нь хороодын гишүүдийн бүтэц бүрэлдэхүүнтэй холбогдуулан гаргажээ.⁹⁶ Ялангуяа ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-той уулзаж ярилцсан хүмүүс улс төрийн ялгаварлалаас шалтгаалж сонгуулийн байгууллагад өргөдөл гомдлыг алагчлалгүй, шударгаар шийдвэрлэх хүсэл сонирхолд итгэх итгэл бага байгаагаар илэрхийлж байв.

Хэдийгээр процедурын алдаа дутагдалтай байсан ч СЕХ нь өргөдөл гомдлыг ерөнхийдөө цаг тухайд нь шийдвэрлэсэн. Гэвч ихэнх нь зохих ёсоор шийдэгдсэнгүй, учир нь СЕХ тэдгээрийн ихэнхийг өөрийн эрх мэдлийн хэмжээнээс хэтэрсэн гэж үзэж байв. Доод шатны сонгуулийн хороодын ажилтнууд ерөнхийдөө өргөдөл гомдлын талаарх зохицуулалт, өөрсдийн эрх хэмжээг ойлгохгүй, өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй байдал нь СЕХ-ны арга барилыг дууриаж байв. Ерөнхийдөө сонгуулийн байгууллагын хэмжээнд өргөдөл гомдлыг шийдвэрлэж буй үйл явцад албан ёсны болон ил тод байдал дутагдаж байсан нь хуульд нийцэхгүй, мөн ЕАБХАБ-ын үүрэг амлалтуудын дагуу шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг бууруулж байв.⁹⁷

СЕХ нь бүх шатны хороодын хэмжээнд өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааны стандарт журмыг тогтоох нь зүйтэй бөгөөд хороод нь өргөдөл гомдол нэг бүрийг нээлттэй хуралдаанаар шийдвэрлэж, үндэслэл бүхий шийдвэрээ олон нийтэд тухай бүрт нь шуурхай мэдээлэх ёстой. СЕХ нь сонгуулийн оролцогч талуудад сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх эрх мэдлийн хүрээ, арга замаа мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Сонгууль болох өдрөөс өмнө СЕХ-ны шийдвэрийг эсэргүүцсэн 25 хэрэг шүүхэд бүртгэгдсэн. Үндсэн хуулийн цэцэд хэрэг шийдвэрлэх эцсийн хугацааг заагаагүй байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь сонгуультай холбоотой хэргийг 40 хүртэл хоногийн дотор шийдвэрлэх ба Дээд шүүх 21 хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийг шийдвэрлэнэ. Эдгээр хугацаа нь шүүхийн стандарт хугацаанаас богино мөртлөө сонгуулийн байгууллагын үйл явцад шаардагдах хугацаатай уялдаж өгөөгүй байна. Бодит байдал дээр шүүхүүд нь нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой гомдлыг хянан хэлэлцэхдээ хэтэрхий удаашруулж, бүр сонгуулийн сурталчилгааны хугацааг хүргэх, зарим нь дөнгөж санал авах өдрийн өмнө хэлэлцэж байсан нь гомдол гаргагчдын Дээд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжийг хязгаарлаж байв.⁹⁸ Түүнчлэн шүүхүүд сонгуультай холбоотой олон хэргийг хянан хэлэлцэхээс татгалзаж, энэ тухай үндэслэл шалтгаанаа олон нийтэд мэдээлсэнгүй.⁹⁹ Ерөнхийдөө сонгуультай холбоотой хэргүүдийг шийдвэрлэхэд ил тод байдал дутагдаж, ЕАБХАБ-ын үүрэг амлалтын дагуу

⁹⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь СЕХ-ноос сонгуультай холбоотой өргөдөл гомдлын талаар нэгдсэн мэдээлэл гаргадаггүй учраас доод шатны сонгуулийн хороодод улсын хэмжээнд нийт ирсэн өргөдөл гомдлын тоог гаргах боломжгүй байлаа.

⁹⁷ ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагены баримт бичгийн 5.10-р зүйлд “үндсэн суурь эрхийг хүндэтгэж, хууль эрх зүйн шударга байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны гаргасан шийдвэрийг эсэргүүцэн барагдуулах үр дүнтэй арга хэрэгслийг авах эрхтэй байна” гэж заажээ.

⁹⁸ Захиргааны хэргийн тухай хуулиар Дээд шүүхэд нэхэмжлэл гаргахаасаа өмнө Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хэргийг хянан хэлэлцэхээс татгалзсан шийдвэрийг эсэргүүцэн гаргах нэхэмжлэлийг тухайн шүүхээр дахин хянуулах боломжтой байдаг. Гэвч энэ нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явцыг хэтэрхий удаашруулахад хүргэж байсан юм.

⁹⁹ Монгол Улсын шүүх байгууллагуудаас аливаа хэргийг шүүхээр хянан хэлэлцэхээс татгалзсан тухай үндэслэл бүхий шийдвэрээ олон нийтэд мэдээлэхийг шаарддаггүй. Тухайлбал, 2016 оны 6-р сарын 17-нд Үндсэн хуулийн цэц нь шүүхийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон бусад холбогдох хуулинд Үндсэн хуулинд нийцэхгүй байгаа хэд хэдэн нэмэлт өөрчлөлтийн тухай асуудлыг шийдвэрлэжээ.

шүүхээр үр дүнтэй хамгаалуулах эрхийг баталгаажуулахыг шаарддаг шиг сонгуулийн маргааныг цаг тухайд нь шийдвэрлэх баталгааг олгоогүй.¹⁰⁰

Өргөдөл гомдлыг шүүхэд хүлээн авах болон сонгуультай холбоотой хэргүүдийг шийдвэрлэх хугацааг богиносгож, сонгуулийн үйл явцтай уялдуулж өгөх нь зүйтэй бөгөөд сонгуулийн маргааныг шуурхай шийдвэрлэхийн тулд шүүхийн үйл ажиллагааг оновчтой, хялбар болгох шаардлагатай. Үндэслэл бүхий шүүхийн бүх шийдвэр, түүн дотор шүүхээр хэлэлцэхээс татгалзсан шийдвэрийг ч цаг тухайд нь олон нийтэд нийтлэн хүргэж байх хэрэгтэй.

СТХ-ийн дагуу цагдаагийн байгууллага нь сонгуулийн сурталчилгааны журмыг зөрчсөн зөрчлүүдийг шалгах, сонгуулийн сурталчилгааны зохицуулалтыг мөрдүүлэх зэрэгт захиргааны торгууль ноогдуулдаг анхан шатны шүүхтэй хамтран ажиллах шинэ үүрэгтэй болсон. Сонгуулийн сурталчилгааны үеэр Цагдаагийн ерөнхий газраас сонгуультай холбоотой гомдлын тоо, шалтгаан болон мөрдөн байцаалтын шатны талаар тогтмол мэдээлж байсан нь хууль сахиулах ажлын ил тод байдалд хувь нэмэр оруулсан. Сонгууль болох өдрийн өмнө сонгуультай холбоотой 1,000 гаруй гомдол улсын хэмжээнд цагдаагийн байгууллагуудад бүртгэгдсэн бөгөөд тэдгээрийн ихэнх нь бага хэмжээний зөрчлийн тухай байжээ. Гэвч 150 орчим тохиолдол нь санал худалдаж авах, сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох гэж сэжиглэгдсэн агуулгатай байв. Санал авах өдрийн байдлаар 20 орчим хэргийг шүүхэд шийтгэл оногдуулахаар илгээсэн бол, бараг тэн хагас нь одоо хүртэл шалгагдаж байна.¹⁰¹ Ялангуяа, санал худалдаж авах гэсэн бүх хэрэг нь шүүхэд хамаарах бөгөөд эрүүгийн шийтгэл ногдуулахаас илүү захиргааны торгууль шийтгэл ноогдуулахыг зөвлөсөн нь цаашид санал худалдан авах гэсэн оролдлогыг үр дүнтэй зогсоох боломжийг багасгаж байна.

ХШ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Сүүлд хийгдсэн хууль эрх зүйн зохицуулалтуудаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог сайжруулах зорилгоор тэдний сонгуулийн эрхийг хамгаалан, сайжруулсан байна. 2009 оноос хойш Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. 2016 оны 2-р сард батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэдний нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан заажээ. Зарим нэг улс төрийн нам сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой асуудлыг тусгасан ба хурал цуглааны үеэр хөндөж байв. Гэвч сонгуульд өрсөлдөж буй хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үр дүнтэйгээр хүрч ажиллахад хүндрэлтэй байсныг тэмдэглэж байлаа. Учир нь сонгуулийн сурталчилгаа явуулах дүрэм журамд гар утас болон гар утасны текстэн зурвасыг сурталчилгааны нэг арга хэрэгсэл болгож ашиглахыг хориглодог. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог сурталчлахад зориулан хэвлэл мэдээллээр нэвтрүүлэх хөтөлбөр хязгаарлагдмал байлаа. Хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэн сонгуульд өрсөлдсөн.¹⁰²

СТХ-иар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн санал өгөх эрхийг хөнгөвчлөх хэд хэдэн зайлшгүй арга хэмжээнүүдийг заан өгч, хуучин СТХ-ийг сайжруулсан. СЕХ нь санал авах байруудад нэвтрэх боломжийг олгох, брайл хуудсаар хангахын зэрэгцээ бүх санал авах байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дор хаяж нэг бүхээгтэй байх боломжоор

¹⁰⁰ ЕАБХАБ-ын 1990 оны Копенхагены баримт бичгийн 5.10 дахь зүйлийг үзнэ үү.

¹⁰¹ 2016 оны 7-р сарын 5-ны байдлаар холбогдох шатны шүүхээс 30 орчим хэрэг дээр захиргааны шийтгэл оногдуулсан байв.

¹⁰² Параолимпийн алтан медальт тамирчин Тусгаар тогтнол, эв нэгдэл эвслээс нэр дэвшсэн.

хангах ёстой. Хэдийгээр харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа өгөх байдлыг хөнгөвчилсөн сайшаалтай арга хэмжээ хийгдсэн байсан ч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглалт хийсэн санал авах байруудын 35 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод орох боломжоор хангагдсан байлаа. Сэтгэцийн эмгэгтэй иргэдийн саналын нууцлал зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авч байхад заримдаа алдагдаж байгааг ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ ажиглагсан болно.

СЕХ болон улс төрийн намууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн амьдралд бүрэн оролцох боломжийг нэмэгдүүлэхийн тулд тэдний саналаа өгөх, нэр дэвших эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулах нь зүйтэй.

XIV. ИРГЭД БА ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧИД

СТХ-иар иргэд, олон улсын байгууллагаас сонгуулийн ажиглалт хийх боломжийг хангасан байдаг. Гэсэн хэдий ч, сонгуулийг ажиглах эрхтэй байхын тулд иргэний байгууллагууд нь дүрмийн дагуу “төрийн хэргийг удирдахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн” байх шаардлагатай. Үүнээс гадна төрийн албан хаагч нь ажиглагч байж болохгүй. ЕАБХАБ/АИХЭГ САХ-ны уулзаж ярилцсан зарим хүмүүс эдгээрийг хэтэрхий хатуу шаардлагууд гэж үзэж байв. СЕХ нь сонгууль болохоос өмнө гадаадын болон олон улсын байгууллагууд сонгуулийг ажиглах журмыг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан. Хэд хэдэн иргэний нийгмийн байгууллага сонгуулийн өмнөх орчинд, тэр дундаа сонгуулийн сурталчилгааны зардал болон хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн байдалд мониторинг хийж, үйл явцын гол зөрчил дутагдлыг онцолсон мэдэгдлийг, тухайлбал хэвлэл мэдээллээр сонгуулийн сурталчилгаа тэнцвэртэй явагдахгүй байгаа, сонгуулийн сурталчилгааны зардлын талаар мэдээлэл хомс байсан зэргийг цаг тухайд нь мэдээлж байлаа.

СЕХ нь сонгуулийг, тэр дундаа бэлтгэл үе шат, санал тоолох төхөөрөмжийн шалгалт зэргийг ажиглах иргэний нийгмийн таван байгууллагад итгэмжлэл олгожээ. Гэвч төхөөрөмжийн ажиллагааг шалгасныг гэрчлэхийн тулд ажиглагчид ажиглагчдын бүлэг бүрт өгөгдсөн хязгаарлагдмал хугацаанд нарийн хуваарийн дагуу хийх шаардлагатай болж байв. Зарим ажиглагчид СЕХ-ны энэ шийдвэрийг хууль ёсны эсэхийг лавлаж байв. Сонгуулийн өдөр иргэний нийгмийн байгууллагын ажиглагчдын хамгийн том байгууллага болох “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ” нь 200 гаруй ажиглагчийг ажиллуулав. Бусад ажиглагч байгууллагууд 100 орчим ажиглагч ажилуулжээ. СЕХ нь хоёр байгууллагыг бичиг баримтаа оройтуулж ирүүлсэн гэсэн үндэслэлээр итгэмжлэл олгоогүй. Мөн “Иргэний шударга шүүх” ТББ-ын тэргүүн нь өөрөө нэр дэвшигч учраас тус байгууллагыг ажиглагчаар бүртгээгүй. Гэвч СЕХ энэ шийдвэрээ албан ёсоор мэдээлээгүй.

XV. СОНГУУЛИЙН ӨДӨР

Сонгуулийн өдөр улс орон даяар ерөнхийдөө дэг журамтай явагдаж өнгөрлөө. ОУСАХ нь сонгуулийн өдрийн ажиллагаа, саналын хуудсыг тоолох, дүнг нэгтгэх үйл явцыг Говь-Алтай, Завхан аймгуудаас бусад бүх аймагт ажиглав. Санал авах байрны нээлтийг 94 хэсгийн хороон дээр ажигласан бол, санал авах үйл явцыг улсын хэмжээнд ажилласан 1,998 хэсгийн хорооны 784 дээр ажиглав. Саналын хуудсыг тоолох үйл ажиллагааг 91 хэсгийн хороон дээр, харин сонгуулийн дүнг нэгтгэх ажиллагааг 339 СДСХ-дын 60 дээр нь очиж ажиглав.

Ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын гуравны нэг орчимд иргэний нийгмийн ажиглагчид байсан бол, сонгуулийн өдөр улс төрийн намуудын ажилтнууд бараг бүх байруудад ажиллалаа. Гэвч СДСХ-д дээр дүнг нэгтгэж байх үед намын болон нэр дэвшигчдийн төлөөлөгчид зөвхөн

арван хороо тутмын нэг дээр л байлцав.

А. ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН ХАЙРЦГААР САНАЛ ӨГӨХ

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх үйл явц 6-р сарын 28-ны өдөр явагдав. Бүртгэгдсэн сонгогчдын 1.3 орчим хувь нь сонгуулийн өдөр өөрсдийн хэсгийн хороод дээр очиж санал өгөх боломжгүй тул саналаа зөөврийн битүүмжилсэн хайрцгаар өгөв. ОУСАХ нь 76 тойргийн 53 дээр зөөврийн хайрцгаар санал авах үйл явцыг ажиглаж, хот суурин болон хөдөө орон нутагт аль алинд нь зохих журмын дагуу явагдсныг тэмдэглэлээ. Саналын нууцлал 91 ажиглалтын 34 дээр алдагдаж байсан бөгөөд энэ нь гол төлөв сэтгэцийн эмгэгтэй сонгогчдод хамаарч байв. Хоёр ажиглалтын үеэр зөөврийн битүүмжилсэн хайрцгийг зөв лацдаж хаагаагүй байсан бол, найман тохиолдол дээр зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгийг шөнө хамгаалалтад авалгүй хадгалж хонуулжээ.

В. САНАЛ АВАХ БАЙРНЫ НЭЭЛТ БОЛОН САНАЛ ӨГӨЛТ

Ажиглалт хийгдсэн ихэнх санал авах байр товлосон цагтаа, эсвэл 30 минутын дотор нээгдэж, үйл ажиллагаагаа эхлүүлсэн. ОУСАХ нь сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд мэдлэг сайтай, сонгуулийн процедурыг чанд мөрдөж ажиллаж байсныг тэмдэглэв.¹⁰³ Санал тоолох төхөөрөмжийг хоёр хэсгийн хороон дээр зохих ёсоор шалгаж нягтлаагүй байлаа. Сонгогчдын биометр мэдээллийг таних, мөн санал тоолох машинтай холбоотой техникийн хүндрэлээс болоод 17 хэсгийн хороон дээр санал хураалт хугацаа хоцорч нээгдсэн.

Сонгуулийн өдөр гарч байсан гол алдаа дутагдал нь саналын нууцлалт нэг түвшинд мөрдөгдөхгүй байсан явдал юм. ОУСАХ-ны ажигласнаар сонгогчид саналаа нууцаар тэмдэглэж байсан боловч машинд уншуулах үедээ саналын хуудсаа дээш харуулж хийснээр өөрсдийн сонголтыг бусдад харуулах боломж өгч байв. Хэдийгээр санал тоолох төхөөрөмж нь буруу тэмдэглэсэн саналын хуудсыг хүлээн авахгүй байхаар програмчлагдсан ч, сонгогчид төхөөрөмж уншаагүй саналын хуудсыг уншихгүй байгаад гайхаж, хэсгийн хорооны ажилтнаас яаж засах тухай асууж байсныг ажиглагчид тэмдэглэжээ. Энэ нь сонгогчийн өгсөн саналыг хэсгийн хорооны байранд байсан бусад хүмүүст харуулсан явдал болжээ. Ажиглалтын 11 хувьд сонгогчид саналаа өгөх процедурыг ойлгох ойлголт хангалтгүй байсан гэж ОУСАХ дүгнэжээ.

Цаашид саналын хуудсыг уншуулах явцад саналын нууцлалыг хангах арга хэмжээг авах нь зүйтэй.

Санал өгөх үйл явцыг ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын 98 хувьд нь процедурыг жигд хэрэгжүүлж байна гэдгийг онцлон, эерэг гэж үнэлжээ.

ОУСАХ-нд ажиглагдсан асуудлууд нь ажиглалт хийгдсэн хэсгийн хороодын гурав орчим хувь дээр гарсан бүлгээр болон итгэмжлэлээр санал өгөх явдал байв. Ажиглалтын 12 хувьд хэсгийн хороодын гадаа маш олон хүн бөөгнөрч байсан нь харагджээ. Гэхдээ ихэнх тохиолдолд хүмүүс санал өгөх боломжоо хүлээн, тэвчээртэйгээр зогсож байв. Харин зөвхөн Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд түр хугацаагаар шилжин ирсэн сонгогчидтой холбоотой хурцадмал байдал үүссэн гэж ОУСАХ ажиглав.

Ерөнхийдөө санал өгөх эрх хангагдсан байв. Гэвч ажиглалтын 12 хувьд зарим сонгогчид гол төлөв өөрсдийнх нь нэрийг СНЖ дээрээс олдохгүй байна гэсэн шалтгаанаар хэсгийн хорооноос буцаж байв. Сонгогчийг өөр ямар нэг зохисгүй шалтгаанаар буцаасан тохиолдол гарсангүй.

¹⁰³ ОУСАХ-ны ажигласан 94 хэсгийн хорооны 3-аас бусад дээр нээлтийг сайн гэж үнэлсэн.

Санал авах өдрийн сүүлээр зарим хэсгийн хороод дээр саналын хуудас дууссаныг ажиглагчид тэмдэглэжээ.¹⁰⁴ Энэ тухай нэгдсэн дүрэм журам байхгүй тул сонгогчдод саналаа өгөх боломжийг хангахын төлөө хэсгийн хороодын ажилтнууд өөрсдийн чадах хирээр зохицуулж байлаа.

Санал хураалтын өдрийн төгсгөлд Цагдаагийн ерөнхий газар улсын хэмжээнд 84 орчим өргөдөл гомдол хүлээн авсны дотор зарим гомдол санал худалдаж авахтай холбоотой байсан талаар ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-д мэдээлсэн. Хэдийгээр СТХ болон СЕХ-ны журмаар урьдчилан зохицуулж өгөөгүй ч ажиглалтын 23 хувьд хэсгийн хороодын байран дотор цагдаагийн албан хаагчид байлцсан. Ерөнхийдөө тэд дугаарлалтыг хянаж зохицуулахаас өөрөөр үйл явцад хөндлөнгөөс оролцоогүй болно.

С. САНАЛ ТООЛОХ БОЛОН ДҮНГ НЭГТГЭХ

Саналын хуудсыг тоолох, дүнг нэгтгэх үйл явцыг үнэлэхдээ санал хураалтыг эерэг гэж дүгнэсэн ерөнхий үнэлгээнээс илэрхий хол байв. Дүнг нэгтгэх эхний ажиллагааг цахимаар явуулж, санал тоолох төхөөрөмжүүд саналын дүнг СЕХ руу автоматаар илгээсэн бол, харин санал хураалтыг хаах, мөн гараар дахин тоолох ажиллагаа нь хэсгийн хороодын ажилтнуудад сонгуулийг хэрхэн хааж, дуусгах талаар ойлголт мэдлэг, сургалт дутмаг байгааг илтгэн харуулав. Ажиглалт хийгдсэн 91 хэсгийн хорооны 18 дээр ашиглагдаагүй, хүчингүй болсон саналын хуудсуудыг тоолоогүй, мөн шаардлагын дагуу тусад нь багцалж боогоогүй. Түүнчлэн 33 тохиолдол дээр хэсгийн хороодын зарим ажилтнууд санал тоолох төхөөрөмжийн протоколд гарын үсэг зураагүй.

Хуулиар саналын дүнг СЕХ руу илгээсний дараа хэсгийн хороодын 50 хүртэлх хувь дээр гараар дахин тоолох ёстой. СЕХ-ноос эдгээр хэсгийн хороодыг хэрхэн сонгох талаар тодорхой удирдамж гаргаагүйг ОУСАХ-ны ажиглагчид тэмдэглэжээ. Зарим хэсгийн хороодод дүнг илгээсний дараа шууд мэдэгдэж байсан бол, бусад нь мэдээлэл ирэхийг хүлээж байлаа. ОУСАХ-ны ажигласнаар 27 хэсгийн хороон дээр гараар дахин тооллого явагджээ. 13 тохиолдол дээр гараар тоолох ажиллагаа шууд тэр даруй явагдсангүй, учир нь хэрхэн явуулах талаар эргэлзээтэй байв. Тоолох ажиллагааг ажиглалт хийгдсэн 91 хэсгийн хорооны 19 дээр нь муу гэж үнэлсэн, үүний гол шалтгаан нь процедурын ноцтой алдаа дутагдлууд байна гэж үзсэн бөгөөд энэ нь хэсгийн хороодын ажилтнуудад гар тооллого явуулах журмын талаар ойлголт дутмаг байгааг харуулсан.¹⁰⁵ Түүнчлэн есөн тохиолдол дээр санал тоолох ажиллагаанд ерөнхийдөө ил тод байдал дутагдаж байна гэж ажиглагчид дүгнэжээ. 20 тохиолдол дээр гар тооллого хийсний дараа сонгуулийн дүнгийн протоколыг бөглөхөд хэсгийн хороодын гишүүдэд бэрхшээл тулгарч байсан бөгөөд 16 тохиолдол дээр бичигдсэн дүн нь хоорондоо тохироогүй. СЕХ-ны тайлбарласнаар сонгуулийн хэсгийн хороод нь гар болон төхөөрөмжөөр тоолсон дүнд зөрүүтэй гарвал түүнийг тохируулах үүрэг хүлээхгүй гэжээ.

СДСХ-д дээрх материалыг хүлээн авч, дүнг нэгтгэх ажиллагаанд ажиглалт хийгдсэн тохиолдлуудын дөрөвний нэгийг муу гэж үнэлсэн. СДСХ-д дээр энэ үйл явц түргэн шуурхай, системтэй зохион байгуулагдаж чадаагүй гэж ОУСАХ тэмдэглэжээ. Долоон тохиолдол дээр тухайн байр нь материалыг хүлээн авах, дүнг нэгтгэх ажиллагааг явуулахад хангалттай зай багтаамжгүй байлаа. Олон улсын ажиглагчдад ажиглалт хийгдсэн 68 тохиолдлын 41 дээр нь дата мэдээллийг оруулж буй үйл явцыг тодорхой сайн харах боломж дутмаг байсан, түүнчлэн 8 тохиолдол дээр СДСХ-дын ажилтнууд СХХ-дын протоколууд дээрх дүнг өөрчилж байжээ.

¹⁰⁴ Увс аймгийн Тэс, Улаангом сум, мөн Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын СДСХ-дын санал авах байруудад саналын хуудас дутсан. Энэ хоёр аймагт сонгогчдын ирц 80 хувь байсан бол, Увс аймагт сонгогчдынхоо тооноос саналын хуудас нь цөөн байсан нэг тойрог нь түр хугацаанд шилжин ирсэн сонгогчдын тоогоор хамгийн их тойргуудын нэг байв.

¹⁰⁵ ОУСАХ нь 50 тойрог дээр санал хураалтын хаалт, дүнг нэгтгэх үйл явцыг ажигласан.

Ялангуяа долоон СДСХ-н дээр СХХ-доос ирүүлсэн шаардлагатай дүнг огт бөглөж оруулсангүй. Үүнээс гадна СДСХ-дын сонгуулийн ажилтнуудын олон улсын ажиглагч нартай хамтран ажиллах түвшин СХХ-дтой харьцуулахад мэдэгдэхүйц доогуур байв.

Сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө сонгуулийн дүнг татан цуглуулах, тоолох тодорхой бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг бий болгож, сонгуулийн байгууллагын бүхий л шатанд системтэйгээр хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Сонгууль болсноос хойш хоёр долоо хоногийн дараа ч СЕХ гараар техникийн тооллого хийгдэхээр сонгогдсон хэсгийн хороодыг олон нийтэд мэдээлээгүй байсан.¹⁰⁶ Түүнчлэн АНСХ-д дээр нэгтгэсэн сонгуулийн дүнд хэрэв ямар нэг зөрүү гар протоколын дүн болон санал тоолох төхөөрөмжөөс хүлээн авсан дүн дээр үндэслэн гарах тохиолдолд баримтлах албан ёсны зохицуулалт шийдвэр байгаагүй. Тиймээс олон улсын сайн туршлагад заасны дагуу хяналтын бүртгэл ашиглан гараар техникийн тооллого хийж, санал тоолох автоматжуулсан төхөөрөмжид итгэх сонгогчдын итгэлийг бэхжүүлэх гэсэн сонгуулийн байгууллагын ажилтнуудын хүчин зүтгэл үр ашиггүй байсныг батлан харуулав.

Цаашид сонгуулийн дүнг үнэн зөв, шударга байлгахын тулд техникийн тооллогын дүнг санал тоолох төхөөрөмжөөс авсан дүнтэй давхар шалгах үр дүнтэй зохицуулалтуудыг бий болгож, тууштай хэрэгжүүлэх нь зүйтэй.

D. СОНГУУЛИЙН ДҮНГ ЗАРЛАХ

СЕХ нь тойрог тус бүрээр гаргасан урьдчилсан дүнг телевизээр шууд гаргаж, сонгуулийн үйл явц ил тод байхад хувь нэмэр орууллаа. Гэвч энэхүү дүнг санал авах байр тус бүрээр нэг бүрчлэн гаргаагүй төдийгүй СЕХ-ны цахим хуудсанд нийтлээгүй байсан нь бие даасан хяналт хийх боломжийг хязгаарласан юм. 2016 оны 7-р сарын 1-ний өдөр СЕХ сонгуулийн дүнг баталгаажуулж, шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдэд түр үнэмлэх гардуулав.

Сонгуулийн дүнг баталгаажуулах үйл явц нь 15 хоногийн хуулийн хугацаандаа, гэхдээ санал тоолох төхөөрөмжийн дүнг гараар тоолсон техникийн тооллоготой тулгаж шалгахаас өмнө болж өнгөрөв. Түүнчлэн сонгуулийн тойрог тус бүрээр гаргасан албан ёсны дүн СЕХ-ны цахим хуудсанд дээр 2016 оны 7-р сарын 6-нд нийтлэгдсэн бол, санал авах байр тус бүрээр гаргасан боловч нэгтгэн боловсруулаагүй дүн мэдээ нь зөвхөн өргөдөл гомдол гаргах албан ёсны хугацаа дууссаны дараа олон нийтэд тавигдсан.¹⁰⁷ Энэ нь саналын хуудасны аюулгүй, найдвартай байдал, санал тоолох ажиллагаа, түүнчлэн олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээллийг олж авахтай холбоотой олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ сонгогчдын итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ил тод байдал, хариуцлагатай холбоотой арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаарх олон улсын сайн туршлагыг бууруулж байна.¹⁰⁸

СЕХ-ноос сонгуулийн урьдчилсан бүрэн дүнг цогц байдлаар нэгтгэж, санал авах хороо тус бүрээр нэг бүрчлэн гарган авсныхаа дараа шууд цахим хэлбэрээр нийтэлж байхыг хуулиар шаарддаг байх нь зүйтэй.

¹⁰⁶ СЕХ-ноос ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд гар тооллогыг 840 орчим хэсгийн хороод дээр хийсэн бөгөөд энэ нь бүх хэсгийн хороодын 42 орчим хувь байсан гэж мэдээлэв. САХ-нд үүнийг баталсан ямар нэг баримт бичиг өгөөгүй.

¹⁰⁷ Шинээр сонгогдсон УИХ-ын гишүүд нь 2016 оны 7-р сарын 5-нд тангараг өргөв. СТХ-ийн 113.3 дэх заалтаар СЕХ-ны шийдвэр гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргана гэжээ.

¹⁰⁸ “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (ИУТЭОУП)-ын 25 дахь зүйлд өгсөн НҮБХЭХ-ны 25-р зүйлийн 20 дахь хэсэг, мөн ИУТЭОУП-ын 19 дэх зүйлд өгсөн НҮБХЭХ-ны Ерөнхий тайлбар No. 34-ийн 19-р хэсгийг тус тус үзнэ үү.

СЕХ нь нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын ирц 73 хувьтай байсныг зарласан бөгөөд хөдөө орон нутагт, мөн түр шилжин ирсэн сонгогчдын тоо мэдэгдэхүйц олон байсан тойргууд дээр ирц үүнээс өндөр байлаа. СЕХ нь МАН-ын нэр дэвшигчид 76 суудлаас 65 суудал, АН 9 суудал, МАХН нэг суудал авч, мөн нэг бие даан нэр дэвшигч сонгогдсоныг зарлав. Шинээр сонгогдсон УИХ-ын гишүүдийн арван долоон хувь нь эмэгтэйчүүд байсан нь тэгш эрхийг хангахад нэг эерэг алхам боллоо. Сонгуулийн дүн мэдээнд шинжилгээ хийхэд хамгийн олон саналын хувь болон парламент дахь суудлын хуваарийн дунд мэдэгдэхүйц ялгаа байгааг харуулж байна. МАН нийт саналын 45 хувьд ялж, суудлын 85 хувийг авсан байна. Эсрэгээр АН нь саналын 33 хувийг авсан мөртлөө УИХ-ын суудлын 12 хувьд ялалт байгуулжээ. Улсын хэмжээнд нийт 9,886 саналын хуудас (ойролцоогоор өгсөн саналын нэг хувь) хоосон байлаа.¹⁰⁹ СЕХ нь хүчингүйд тооцогдсон саналын хуудсны нийт дүнг олон нийтэд нийтэлж мэдээлээгүй бөгөөд эдгээр хуудас нь санал тоолох төхөөрөмжөөр мөн тоологдсонгүй.

XVI. СОНГУУЛИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

A. УЛС ТӨРИЙН ҮЙЛ ЯВЦ

Сонгуулийн дараах нөхцөл нь улс төрийн эрх мэдэл АН-аас МАН-д маш хурдан шилжиж байснаар онцлог байв. СЕХ-ноос урьдчилсан дүнг танилцуулснаас хойш хэдхэн цагийн дараа МАН болон АН-ын дарга нар сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрсөн бөгөөд бусад улс төрийн намын удирдлагууд удаах өдөр нь хүлээн зөвшөөрсөн. Гэвч дараах өдрүүдэд нь албан тушаалаа өгч буй АН-ын удирдлага эрх мэдлийн шилжилтийг удаашруулах оролдлогыг хийж, УИХ-ын анхдугаар чуулганы хуралдааны товьг зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг эсэргүүцэв.¹¹⁰ Гэсэн хэдий ч, 2016 оны 7-р сарын 5-нд УИХ-ын шинэ гишүүд тангаргаа өргөж, МАН-ын дарга УИХ-ын даргаар томилогдов. Шинэ парламентад гурван нам төлөөлөлтэй болсноос зөвхөн МАН, АН хоёр л намын бүлэг байгуулах тооны суудалтай болжээ. Шинэ Ерөнхий сайдыг 2016 оны 7-р сарын 7-нд сонгов.

B. СОНГУУЛИЙН ДАРААХ ӨРГӨДӨЛ ГОМДОЛ

СТХ-нд сонгуулийн дараа өргөдөл гомдол гаргах үйл явцыг тусгайлан зохицуулаагүй. Ерөнхий зохицуулалтаар сонгуулийн дүнг аливаа иргэн, хуулийн этгээд эсэргүүцэх боломжийг олгодог. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 12 тойрог дээр сонгуулийн дүнг эсэргүүцэн, МАН-ын найм, АН-ын гурав, нэг бие даан нэр дэвшигчийн сонгуулийг хүчингүй болгохыг хүссэн арван зургаан хэрэг бүртгэгджээ.¹¹¹ Үүнээс гадна Үндсэн хуулийн цэц сонгуулийн дараа 25 сонгуулийн тойргийн дүнг эсэргүүцсэн гурван өргөдлийг хүлээн авсан бөгөөд эдгээр нь бүгд сонгуулийн тойргуудын хооронд олон тооны сонгогчдын шилжилт хөдөлгөөний зөрчил гарсан гэж сэжиглэсэн агуулгатай байв.¹¹² Үндсэн хуулийн цэцэд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн зарим заалтууд үндсэн хуулинд нийцэж байгаа эсэх тухай өөр хоёр

¹⁰⁹ СЕХ нь хоосон саналын хуудаснуудын албан ёсны тоог нийтэд мэдээлээгүй, тиймээс ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ нь тойрог тус бүрээр гаргасан албан ёсны дүн дээр үндэслэн хоосон саналын хуудаснуудын нийт тоог гаргав.

¹¹⁰ Ерөнхийлөгч нь УИХ-ын тухай хуульд заасны дагуу анхдугаар чуулганы хуралдааны товьг зарлахдаа УИХ-д суудалтай намуудын удирдагчидтай зөвшилцөөгүй гэсэн үндэслэлээр Үндсэн хуулийн цэцэд нэхэмжлэл гаргажээ.

¹¹¹ АН-ын нэр дэвшигчид ихэнх гомдлыг гаргажээ. Бусад гомдлыг МАН, МАХН, МУНН-ын гишүүд гаргажээ. Жишээ нь, АН-ын нэг нэр дэвшигч нэг сумын гурван баг дээр сонгогчдыг саналаа өгөх гэхэд нь хэсэг бүлэг хүмүүс тэднийг санал авах байрууд руу нэвтрэхэд саад болсон гэсэн үндэслэлээр 9-р тойргийн сонгуулийн дүнг хүчингүй болгохыг хүссэн байна. Өөр нэг тохиолдолд, 37-р тойрогт нэр дэвшсэн АН-ын нэг нэр дэвшигч тус тойрог руу сонгогчдыг хууль бусаар шилжүүлсэн гэж МАН-ын нэр дэвшигчийн сонгуулийг эсэргүүцэн гомдол гаргажээ.

¹¹² АН-ын нэгэн хуульчийн гаргасан өргөдөлд 23-н тойргийн сонгуулийн дүнг эсэргүүцсэн байна.

өргөдөл бүртгэгджээ. УИХ-ын шинэ гишүүд тангараг өргөж байхад сонгуулийн дүнг эсэргүүцсэн бүх өргөдөл гомдол шүүх дээр хүлээгдэж байсан нь сонгуулийн дүнг эсэргүүцэн шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг бууруулсан.

СТХ-нд сонгуулийн дараах өргөдөл гомдлыг зохицуулах хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, сонгуулийн дүнг эсэргүүцсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх боломжийн хугацааг тогтоон, сонгуулийн дүнг эцэслэн гаргахдаа сонгуулийн дараах өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаатай уялдуулж зохицуулах нь зүйтэй.

XVII. ЗӨВЛӨМЖ

Дараах зөвлөмжүүдийг Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, улс төрийн намууд болон иргэний нийгэмд ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг, ардчилсан сонгууль явуулахтай холбоотой бусад хэм хэмжээтэй нийцүүлэн гаргах цаашдын хүчин чармайлтад нь дэмжлэг болгох үүднээс харгалзан үзэхийг хүсэн санал болгож байна. Эдгээр зөвлөмжийг ЕАБХАБ/АИХЭГ-аас өгсөн өмнөх зөвлөмжүүдтэй хамт уншиж танилцах нь зохистой. ЕАБХАБ/АИХЭГ нь Монгол Улсын эрх бүхий байгууллагуудыг цаашид сонгуулийн үйл явцаа сайжруулах, мөн энэ болон өмнөх тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нь туслахад бэлэн байна.¹¹³

A. НЭН ТЭРГҮҮНИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

1. Сонгуулийн хууль тогтоомжуудад аливаа чухал өөрчлөлтийг оруулахаар бол талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг өрнүүлэхээс гадна сонгуулийн үйл явцад тогтвортой байдлыг хангах болон олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө батлах шаардлагатай.
2. СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрийн хуваарилалтыг тогтоохдоо сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө хийхээр зааж өгөхийн зэрэгцээ, сонгуулийн нэг тойрогт оногдох сонгогчдын тоо нь улсын дундаж тооноос давж буй зөрүү нь үндэслэлтэй, хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр байхаар тогтоож өгөх, түүнчлэн саналын тэгш эрхийг хангахад чиглэсэн, орон нутгийн хил хязгаарыг хадгалах зэргийг харгалзан үзсэн байвал зохино.
3. Сонгуулийн байгууллагад талуудын оролцоог хангасан, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ болон доод шатны хороод нь сонгуулийн хугацаанд тогтмол, нээлттэй хурал уулзалтыг хийхдээ олон нийтэд хангалттай хугацааны өмнө зарлан мэдэгдэж, хэлэлцэх асуудлууд, хурлын тэмэгдлэл, гаргасан шийдвэрээ тухайн бүр олон нийтэд шуурхай мэдээлж, хэвлэн нийтэлж байх нь зүйтэй.
4. Төрийн захиргааны байгууллагын болон улс төрийн сурталчилгааны зааг, хязгаарыг ялгаж салгах алхмууд хийгдэх шаардлагатай. Улс төрийн албан тушаалтнууд нь өөрсдийн сонгуультай үүрэг хариуцлага болон сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаагаа хуулиар хатуу тусгаарлаж байх үүрэг хүлээх ёстой бөгөөд төрийн байгууллагын өмч хөрөнгийг буруугаар ашигласан тохиолдолд ноогдуулах шийтгэлийн үр дүнтэй механизмыг бүрдүүлэх нь зүйтэй.

¹¹³ ЕАБХАБ-ын 1999 оны Истанбулын Баримт бичгийн 25 дахь хэсэгт ЕАБХАБ-ын гишүүн орнууд нь “АИХЭГ-ын гаргасан сонгуулийн үнэлгээ, зөвлөмжүүдийг нэн даруй дагах”-д өөрсдийгөө зориулна гэжээ.

5. Ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахын тулд сонгуулийн сурталчилгааны зардлын тайлан, ялангуяа хандивлагчдын нэрсийг жагсаан олон нийтэд нийтэлж, энэ мэдээллийг цахим хэлбэрээр ч мэдээлж болох юм. Санал авах өдрөөс өмнө сонгуулийн сурталчилгааны зардлын тайланг УАГ-т улирал тутам ирүүлэхийг шаарддаг байхыг анхаарч үзэх хэрэгтэй.
6. Аливаа сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлтэй холбогдох бүх зохицуулалтыг хэрхэн дагаж мөрдөж байгаад хяналт тавих, мөн давхацсан зохицуулалтууд бий болохоос зайлсхийж, цаг тухайд нь үр дүнтэй арга хэмжээ авч байхын тулд хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүрэг бүхий бие даасан хяналтын төвлөрсөн нэг байгууллагатай байх нь зүйтэй.
7. СТХ-нд сонгуулийн дараах өргөдөл гомдлыг зохицуулах хууль эрх зүйн хүрээг бий болгож, сонгуулийн дүнг эсэргүүцсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх боломжийн хугацааг тогтоон, сонгуулийн дүнг эцэслэн гаргахдаа сонгуулийн дараах өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаатай уялдуулан зохицуулах нь зүйтэй.

В. БУСАД ЗӨВЛӨМЖҮҮД

Хууль эрх зүйн хүрээ ба сонгуулийн тогтолцоо

8. Сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн хүрээг ханган баталгаажуулах, мөн түүнийг тууштай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахын тулд сонгуулийн хууль тогтоомжид тодотгох шаардлагатай гэж үзсэн зохицуулалт (дүрэм, журам)-ыг батлах бүрэн эрхийг СЕХ-нд олгохоор холбогдох хуулийг дахин хянан авч үзэж болох юм.
9. Дээд шүүх нь СЕХ-ны хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбарыг гаргах бүрэн эрхээ эргэн хэрэгжүүлэх нь зүйтэй. Дээд шүүхийн ажлыг хөнгөвчлөхийн тулд Дээд шүүхээс өгөх санал зөвлөмжүүдийн дагуу Шүүхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар анхаарч үзэж болох юм.

Сонгуулийн байгууллага

10. Бүх шатны сонгуулийн хороодод ажиллах гишүүдийг томилох, чөлөөлөх механизмыг олон нийтийн дунд, талуудыг оролцуулж, ил тод байдлаар зохион байгуулахад анхаарах хэрэгтэй.
11. Доод шатны сонгуулийн хороодод мэдээллийг цаг хугацаанд нь багтаан дамжуулах, мөн холбогдох сургалтыг зохион байгуулах боломжийг олгох үүднээс СТХ-нд сонгуулийн явцад гарч буй аливаа алдаа дутагдал, хийдлийг боломжийн хугацаанд шийдвэрлэх дүрэм журам батлан хэрэгжүүлэхийг СЕХ-ноос шаарддаг байхаар зааж өгөх нь зүйтэй.
12. Санал тоолох төхөөрөмжийн эх кодыг үзэх боломжийг хуулиар бүрдүүлж, бодит байдал дээр гуравдагч этгээдээр хянан баталгаажуулж байх ёстой бөгөөд санал тоолох төхөөрөмжид итгэх сонгогчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд баталгаажуулсан тухай дүнг олон нийтэд нийтлэн мэдээлэх нь зүйтэй.

Сонгогчдийн бүртгэл

- 15 СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, хорих ял эдэлж буй этгээдүүдийн сонгуульд санал өгөх эрхийг хязгаарлахдаа үйлдсэн гэмт хэргийн ангилал буюу хүнд хөнгөнд тохирсон байхыг баталгаажуулах нь зүйтэй. Эрх зүйн бүрэн чадамжгүй хорих ял эдэлж буй этгээдүүдийн

санал өгөх эрхийг хязгаарлахдаа санал өгөх эрхийг нь илэрхий хүчингүй болгосон шүүхийн шийдвэр дээр үндэслэсэн байвал зохино.

- 16 Сонгуулийн байгууллагын ажилтнууд болон цагдаагийн албан хаагчдыг оршин суугаа аймаг дотроо өөрсдийн ажиллаж буй хэсгийн хороодод санал өгөхөөр шилжих боломжийг холбогдох хуулиар зөвшөөрөх нь зүйтэй.

Нэр дэвшигчийн бүртгэл

- 17 СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаат цэргийн албыг хаагаагүй, албан татварын хугацаа хэтэрсэн өртэй болон зээлийн өртэй, ял шийтгүүлж байсан бүртгэлтэй зэргийг үндэслэн нэр дэвшихийг хязгаарласан нэмэлт шаардлагыг хүчингүй болгох нь зүйтэй. Төрийн албан хаагчдаас нэр дэвшүүлэх үйл явц эхлэхээс өмнө албан үүргээсээ чөлөөлөгдөхийг шаардах ёсгүй.
- 18 СЕХ-нд нэр дэвшигчдийг бүртгэх, мөн шүүхээр давж заалдаж буй аливаа хэргийг эцэслэн шийдвэрлэгдэх хангалттай хугацааг олгож баталгаажуулахын тулд нэр дэвшигчийг дэвшүүлэх хугацааг сонгууль зохион байгуулахаар товлон зарлах өдөртэй ойролцоо тогтоох хэрэгтэй.
- 19 Сонгогдох эрхийг хамгаалах, мөн тэнцвэртэй байдлыг хангахын тулд СТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулж, нэр дэвшигчдийг сонгуулийн сурталчилгаатай холбоотой бага хэмжээний зөрчлөөс шалтгаалан бүртгэлээс хасахгүй байхыг баталгаажуулах нь зүйтэй. ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтуудтай нийцүүлэн, хангалттай тооны санал авч, зохих ёсоор сонгогдсон нэр дэвшигчдийн бүртгэлийг хүчингүй болгох заалтыг хасах талаар анхаарах хэрэгтэй.
- 20 Сонгогчдын саналыг хасаж, хүчингүй болгохоос сэргийлэхийн тулд СТХ-иар санал хураалт эхэлснээс хойш нэр дэвшигчийг бүртгэлээс хасахыг болиулж, саналын хуудас хэвлэгдснээс хойш аливаа нэр дэвшигчийг бүртгэлээс хассан тухай ерөнхий бүртгэл лавлагааг шаарддаг байх нь зүйтэй.

Сонгуулийн сурталчилгаа

- 21 СТХ-нд сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааг явуулах журамд тавигдаж буй шаардлагыг цөөлөх, мөн сонгуульд өрсөлдөж буй нэр дэвшигчдэд сурталчилгаа хийх адил тэгш нөхцөлөөр хангах нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Сонгуулийн сурталчилгааны зардал

- 22 ҮАГ-т сонгуулийн сурталчилгааны зардлын хяналт, мониторингийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбогдох байгууллагуудаас шаардлагатай санхүүгийн мэдээллийг тухай бүр нэн даруй ирүүлэхийг шаардах эрхтэй байх зэргээр хангалттай эрх мэдэл, нөөцтэй болгох хэрэгтэй. Аудитын шалгалт хийх тодорхой шалгуурыг боловсруулж, тэнцвэртэй бөгөөд урьдчилан сэргийлэхүйц шийтгэлийг оногдуулах эрх мэдлийг ҮАГ-т олгох нь зүйтэй.

Хэвлэл мэдээлэл

- 23 Сонгуулийн үеэр улс төрчдийн нэр төрийг хамгаалах зорилготой нэр төрийг гутаахад шийтгэл оногдуулах тухай эрүүгийн хуулийн заалтууд, түүнчлэн сонгуулийн үеэр гүтгэлэг, худал мэдээлэл тараасан хэрэгт ноогдуулдаг шийтгэлийг хүчингүй болгох нь зүйтэй.

- 24 Хэвлэл мэдээллийн хяналтын байгууллагад мэдээний нэвтрүүлгийн үеэр цацагдах далд сурталчилгаатай холбоотой СТХ-д заасан зөрчлүүдийг хянахын тулд чадавх, нөөцийг олгох нь зүйтэй.
- 25 Редакцийн бие даасан, хараат бус байдлыг дээд хэмжээнд баталгаажуулахын тулд мэдээ, мэтгэлцээний талаар тавьсан хязгаарлалтуудыг дахин хянаж үзэх нь зүйтэй. Сонгогчдод бие даасан, хараат бус мэдээ мэдээллийг хүлээн авах боломжийг олгохын тулд хэвлэл мэдээллийн байгууллага нь редакцийн хяналтаа хэрэгжүүлж чаддаггүй шууд нэвтрэх захиалгат нэвтрүүлгийн цагийг хязгаарлах талаар анхаарч үзвэл зохино.

Өргөдөл гомдол

- 26 СЕХ нь бүх шатны хороодын хэмжээнд өргөдөл гомдлыг шийдвэрлэх стандарт ажиллагааны журмыг тогтоох нь зүйтэй бөгөөд хороод нь өргөдөл гомдол нэг бүрийг нээлттэй хуралдаанаар шийдвэрлэж, үндэслэл бүхий шийдвэрээ олон нийтэд тэр даруйд нь шууд мэдээлэх ёстой. СЕХ нь сонгуулийн оролцогч талуудад сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх эрх мэдлийн хүрээ, журмыг хүргэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.
- 27 Өргөдөл гомдлыг шүүхэд хүлээн авах болон сонгуультай холбоотой хэргүүдийг шийдвэрлэх хугацааг богиносгож, сонгуулийн үйл явцтай уялдуулж өгөх нь зүйтэй бөгөөд сонгуулийн маргааныг шуурхай шийдвэрлэхийн тулд шүүхийн үйл ажиллагааг оновчтой, хялбар болгох шаардлагатай. Үндэслэл бүхий шүүхийн бүх шийдвэр, түүнчлэн шүүхээр хэлэлцэхээс татгалзсан шийдвэрийг ч цаг тухайд нь олон нийтэд нийтлэн хүргүүлж байх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо

- 28 СЕХ болон улс төрийн намууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн амьдралд оролцох бүрэн боломжийг сайжруулахын тулд тэдний санал өгөх, нэр дэвших эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулах нь зүйтэй.

Санал өгөх, тоолох, нэгтгэх болон сонгуулийн дүнг зарлах

- 29 Цаашид саналын хуудсыг уншуулах явцад саналын нууцлалыг хангах арга хэмжээг авах нь зүйтэй.
- 30 Сонгууль болохоос хангалттай хугацааны өмнө сонгуулийн дүнг татан цуглуулах, тоолох тодорхой бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг бий болгож, сонгуулийн байгууллагын бүхий л шатанд системтэйгээр хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй.
- 31 Цаашид сонгуулийн дүнг үнэн зөв, шударга байлгахын тулд техникийн тооллогын дүнг санал тоолох төхөөрөмжөөс авсан дүнтэй давхар шалгах үр дүнтэй зохицуулалтыг бий болгож, тууштай хэрэгжүүлэх нь зүйтэй.
- 32 СЕХ нь сонгуулийн урьдчилсан бүрэн дүнг цогц байдлаар нэгтгэж, санал авах хороо тус бүрээр нэг бүрчлэн гарган авсныхаа дараа цахим хэлбэрээр шууд нийтэлж байхыг хуулиар шаарддаг байх нь зүйтэй.

ХАВСРАЛТ I – СОНГУУЛИЙН ДҮН

Аймаг	Тойргийн дугаар	Бүртгэгдсэн сонгогчдын тоо ¹¹⁴	Шилжин ирэн сонгогчид ¹¹⁵	Шилжин явсан сонгогчид ¹¹⁶	Бүртгэгдсэн сонгогчдын эцсийн дүн	Ирц (%)	Нийт хүчинтэй саналын тоо	АН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал ¹¹⁷	Хувь	МАН-ын нэр дэвшигчдэд өгсөн	Хувь	МАХН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Бусад нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Хоосон саналын хуудас ¹¹⁹
Архангай	1	20,233	561	77	20,717	82	17,000	6,434	38	9,817	58	167	1	496	3	86
	2	18,795	177	130	18,842	73	13,696	4,816	35	7,036	52	945	7	797	6	102
	3	19,441	603	49	19,995	80	15,986	5,252	33	9,704	61	886	6			144
Баян-Өлгий	4	19,377	25	105	19,297	86	16,588	7,992	49	8,441	51					155
	5	19,218	59	66	19,211	83	15,976	7,129	45	8,143	51			597	4	107
	6	17,924	7	12	17,919	85	15,174	7,251	48	6,880	46	924	6			119
Баянхонгор	7	17,001	255	15	17,241	82	14,158	6,491	46	7,138	51	216	2	240	2	73
	8	17,827	97	12	17,912	80	14,244	6,747	48	6,845	48	344	2	200	1	108
	9	18,534	1909	26	20,417	79	16,082	7,679	48	7,900	49	226	1	188	1	89
Булган	10	39,378	238	118	39,498	75	29,669	10,293	35	16,329	55	1,595	5	1,230	4	222
Говь-Алтай	11	35,428	161	89	35,500	80	28,430	9,814	35	14,439	51	239	1	3,772	13	166
Дорноговь, Говьсүмбэр	12	20,629	125	51	20,703	78	16,110	6,040	38	8,900	56	777	5	171	1	222
	13	30,774	92	109	30,757	74	22,643	5,543	25	15,606	70	778	3	425	2	291
Дорнод	14	25,278	102	27	25,353	72	18,348	7,311	40	8,964	49	2,073	11			0
	15	23,998	115	25	24,088	71	17,090	4,454	26	8,094	48	749	4	3,716	22	77
Дундговь	16	28,965	772	86	29,651	76	22,501	6,559	29	6,437	29	3,115	14	6,263	28	127

¹¹⁴ СЕХ-ны цахим хуудас. Сонгогчдын шилжилт дуусахаас өмнө нийтлэгдсэн мэдээлэл. СЕХ-ны цахим хуудсанд нийт сонгогчдын нэгтгэсэн дүн байхгүй.

¹¹⁵ Улсын бүртгэлийн ерөнхий газраас ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд өгсөн мэдээлэл.

¹¹⁶ Улсын бүртгэлийн ерөнхий газраас ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-нд өгсөн мэдээлэл.

¹¹⁷ СЕХ-ны цахим хуудас, тойрог бүрээр гаргасан эцсийн дүн.

¹¹⁸ СЕХ-ны цахим хуудас, тойрог бүрээр гаргасан эцсийн дүн.

¹¹⁹ СЕХ-ны цахим хуудас, тойрог бүрээр гаргасан эцсийн дүн.

Аймаг	Тойргийн дугаар	Бүртгэгдсэн сонгогчдын тоо	Шилжин ирсэн сонгогчид	Шилжин явсан сонгогчид	Бүртгэгдсэн сонгогчдын эцсийн дүн	Ирц (%)	Нийт хүчинтэй саналын тоо	АН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАХН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Бусад нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Хоосон саналын хувьдас
Завхан	17	23,544	370	44	23,870	86	20,423	8,599	42	8,466	42	2,500	12	811	4	47
	18	21,257	230	52	21,435	81	17,432	7,077	41	6,643	38	425	2	3,232	19	55
Өвөрхангай	19	25,142	412	107	25,447	76	19,269	6,932	36	10,139	53	1,058	6	979	5	161
	20	21,613	100	64	21,649	71	15,264	2,994	20	9,655	64	449	3	2,043	13	123
	21	24,883	393	36	25,240	80	20,304	7,158	36	9,391	47	404	2	3,196	16	155
Өмнөговь	22	20,491	86	89	20,488	74	15,207	6,640	44	7,434	49	1,036	7			97
	23	20,318	144	121	20,341	72	14,717	6,847	47	6,912	47	867	6			91
Сүхбаатар	24	38,624	177	124	38,677	81	31,411	14,402	46	16,133	52	435	1	234	1	207
Сэлэнгэ	25	23,734	77	123	23,688	72	16,980	6,550	39	7,616	45	679	4	2,063	12	72
	26	24,560	98	140	24,518	71	17,390	4,319	25	7,962	47	3,962	23	777	5	370
	27	20,059	456	120	20,395	76	15,518	7,145	47	6,466	42	1,730	11			177
Төв	28	18,967	63	72	18,958	75	14,234	4,278	30	8,289	59	1,000	7	526	4	141
	29	19,060	23	85	18,998	73	13,900	4,053	30	7,896	58	1,779	13			172
	30	21,796	740	97	22,439	77	17,193	6,463	38	8,154	48	2,371	14			205
Увс	31	16,483	2778	61	19,200	85	16,297	7,737	48	8,358	51			159	1	43
	32	16,481	145	78	16,548	83	13,763	5,648	41	8,021	59					94
	33	15,732	377	41	16,068	84	13,426	5,532	41	7,611	57	217	2			66
Ховд	34	13,866	161	29	13,998	84	11,714	4,492	38	4,228	36	382	3	2,582	22	30
	35	16,582	160	28	16,714	81	13,560	5,370	40	6,602	49	1,356	10	199	1	33
	36	20,335	409	47	20,697	79	16,370	7,757	48	7,914	49	453	3	193	1	53

Улсын Их Хурлын сонгууль, 2016 оны 6-р сарын 29-ний өдөр
ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Тайлан

Аймаг	Тойргийн дугаар	Бүртгэгдсэн сонгогчдын тоо	Шилжин ирсэн сонгогчид	Шилжин явсан сонгогчид	Бүртгэгдсэн сонгогчдын эцсийн дүн	Ирц (%)	Нийт хүчинтэй саналын тоо	АН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАХН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Бусад нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Хоосон саналын хувь
Хөвсгөл	37	25,362	1195	19	26,538	73	19,287	7,290	38	10,711	56	362	2	797	4	127
	38	30,850	82	37	30,895	73	22,417	7,218	32	14,291	64	440	2	332	1	136
	39	25,774	1708	45	27,437	75	20,703	7,691	37	12,075	59	547	3	249	1	141
Хэнтий	40	15,482	175	94	15,563	77	11,956	4,885	41	6,623	56			309	3	139
	41	14,568	191	25	14,734	80	11,797	4,246	36	6,232	53	436	4	810	7	73
	42	16,539	115	45	16,609	75	12,479	5,426	44	5,841	47	1,050	9			162
Дархан-Уул	43	21,867	297	279	21,885	71	15,568	3,128	20	6,553	42	452	3	5,344	35	91
	44	20,247	298	287	20,258	71	14,430	3,640	25	6,716	47	2,145	15	1,871	13	58
	45	21,266	99	188	21,177	69	14,669	4,209	29	6,320	43	1,399	10	2,609	18	132
Орхон	46	22,526	342	290	22,578	71	16,041	3,413	21	5,751	36	3,112	20	3,650	23	115
	47	20,839	87	257	20,669	71	14,682	3,188	22	2,882	20	4,222	29	4,336	30	54
	48	21,800	42	312	21,530	69	14,945	4,628	31	4,725	32	1,830	12	3,660	25	102
Улаанбаатар	49	35,440	18	678	34,780	69	23,961	6,282	26	7,616	32	2,357	10	7,563	32	143
	50	30,514	106	853	29,767	77	22,859	7,461	33	11,408	50	1,434	6	2,437	11	119
	51	33,319	19	731	32,607	67	21,933	4,784	22	8,660	40	2,446	11	5,914	27	129
	52	37,896	13	509	37,400	69	25,685	7,755	30	8,985	35	2,471	10	6,240	25	234
	53	30,433	49	515	29,967	71	21,302	8,491	40	7,677	36	1,616	8	3,391	16	127
	54	37,689	14	516	37,187	71	26,507	4,105	16	6,574	25	1,283	5	14,383	55	162
	55	25,952	16	570	25,398	74	18,776	5,548	30	6,331	34	2,296	12	4,511	24	90
	56	27,003	29	1040	25,992	78	20,286	5,517	27	9,648	48	1,006	5	4,040	20	75
	57	24,767	12	445	24,334	73	17,847	5,296	30	4,318	24	1,667	9	6,403	36	163
	58	22,807	23	364	22,466	73	16,338	5,174	32	5,688	35	2,308	14	3,038	19	130

Аймаг	Тойргийн дугаар	Бүртгэгдсэн сонгогчдын тоо	Шилжин ирсэн сонгогчид	Шилжин явсан сонгогчид	Бүртгэгдсэн сонгогчдын эцсийн дүн	Ирл (%)	Нийт хүчинтэй саналын тоо	АН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	МАХН-ын нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Бусад нэр дэвшигчдэд өгсөн санал	Хувь	Хоосон саналын хувьд
Улаанбаатар	59	23,337	7	449	22,895	76	17,443	5,084	29	8,043	46	1,202	7	3,048	18	66
	60	25,061	27	474	24,614	72	17,811	5,146	29	8,299	47	1,197	7	3,058	17	111
	61	24,716	21	364	24,373	69	16,767	5,570	34	7,340	44	1,464	9	2,228	13	165
	62	32,053	98	428	31,723	72	22,720	7,834	35	8,233	37	1,621	7	4,839	21	193
	63	41,836	5	571	41,270	75	30,790	7,548	25	12,704	42	3,548	12	6,768	22	222
	64	25,944	14	396	25,562	68	17,409	4,804	28	6,590	38	2,192	13	3,630	21	193
	65	26,217	4	347	25,874	67	17,417	3,479	20	6,058	35	2,194	13	5,537	32	149
	66	32,225	6	456	31,775	66	20,878	4,713	23	6,844	33	2,485	12	6,586	32	250
	67	35,033	19	873	34,179	73	25,121	8,295	33	9,268	37	3,139	13	4,316	17	103
	68	31,420	13	736	30,697	72	22,106	6,661	30	10,614	48	1,731	8	2,970	14	130
	69	29,827	11	616	29,222	73	21,447	7,477	35	6,190	29	1,797	8	5,855	27	128
	70	31,398	70	590	30,878	75	23,164	6,687	29	7,672	33	1,281	6	7,427	32	97
	71	32,425	123	692	31,856	74	23,417	5,166	22	9,241	40	2,127	9	6,804	29	79
	72	28,824	51	801	28,074	72	20,259	5,753	29	9,486	47	2,436	12	2,477	12	107
	73	26,289	22	449	25,862	71	18,385	4,132	23	9,577	52	2,014	11	2,536	14	126
	74	33,989	10	704	33,295	68	22,634	5,659	25	8,106	36	3,455	15	5,240	23	174
75	37,427	169	705	36,891	71	26,303	6,277	24	9,673	37	7,360	28	2,780	11	213	
76	35,613	10	894	34,729	70	24,399	7,883	33	12,190	50	2,844	12	1,284	5	198	
НИЙТ		1,912,901	18,307	21,199	1,910,009	74	1,421,005	467,341	33	636,316	45	113,103	8	194,359	14	9,886

ХАВСРАЛТ II – ОЛОН УЛСЫН СОНГУУЛИЙГ АЖИГЛАХ ХОРООНЫ АЖИГЛАГЧДЫН ЖАГСААЛТ

Богино хугацааны ажиглагчид

Европын Парламент

Laima Liucija	ANDRIKIENĖ	Литва	Төлөөлөгчдийн тэргүүн
Georg	MAYER	Австри	Парламентын гишүүн
Nikolay	BAREKOV	Болгар	Парламентын гишүүн
Jozo	RADOŠ	Хорват	Парламентын гишүүн
Norbert	NEUSER	Герман	Парламентын гишүүн
Joachim	ZELLER	Герман	Парламентын гишүүн
Timothy	BODEN	Их Британи	ЕП Нарийн бичгийн дарга нарын газар
Karl	MINAIRE		ЕП Нарийн бичгийн дарга нарын газар
Alyson	WOOD		ЕП Нарийн бичгийн дарга нарын газар
Ambroise	PERRIN	Франц	

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Богино хугацааны ажиглагчид

Theresa	BAUMANN	Австри
Clemens	DROESSLER	Австри
Christian Oliver	HYNEK	Австри
Andrea	JAKOBER	Австри
Donald	MCKENNA	Австрали
Krishan	PRATHAPAN	Австрали
Denis	CHOUINARD	Канад
Nancy	FOSTER	Канад
Diane	TISDALL	Канад
Glen	ZYZANSKI	Канад
Vaclav	DOBES	Чех Улс
Oldrich	ZAJICEK	Чех Улс
Katerina	JOSELOVA	Чех Улс
Martin	NEKOLA	Чех Улс
Jan	NEMEC	Чех Улс
Martin	PIZINGER	Чех Улс
Ivan	BAEHR	Дани
Peter	BOHLBRO	Дани
Bente	RASMUSSEN	Дани
Grete	SKOV	Дани
Michael Vallentin	STRAND	Дани
Kati	JÄÄSKELÄINEN	Финланд
Jaana	KERTTULA	Финланд
Christian	WALLIN	Финланд
Elizabeth	BARSACQ	Франц
Griselda	BASSET	Франц
Raphael	DROSZEWSKI	Франц
Jean-Florent	FILTZ	Франц
Anais	GRIVOT	Франц
Hanane	ACHAHBOUN	Франц
Caroline	ANTUNES	Франц
Benoit	BOUYSSOU	Франц
Pascal	DELUMEAU	Франц
Ossama	KAMEL	Франц
Catherine	PASCAL	Франц
Juergen Klaus	BINDER	Герман
Katharina Franziska	BRAIG	Герман
Nora	BRANDECKER	Герман

Erich Reinhard	BRYSCH	Герман
Ingo	BUETTNER	Герман
Hans Thomas	DOEHNE	Герман
Kathrin Rosemarie	GEYER	Герман
Susanne	GREITER	Герман
Harald Georg	HAENDEL	Герман
Marco	HANITZSCH	Герман
Sophie Charlotte	HARING	Герман
Michael	HAUBMANN	Герман
Dagmar	HOFMANN	Герман
Clemens Herbert	JUERGENMEYER	Герман
Christian Michael	KEILBACH	Герман
Anke	KERL	Герман
Agnes	KOLODZIEJ	Герман
Laura	KORN	Герман
Bernd Wolfgang	LEBER	Герман
Joerg	LEHNERT	Герман
Kristin Beatrix	LIEDTKE	Герман
Ruth Monika	LINDEN	Герман
Markus	LORENZ	Герман
Angelika Ursula	MATTKE	Герман
Regine Luise	REIM	Герман
Jochen Michael	RINCK	Герман
Ursula	SCHULZE-ABOUBACAR	Герман
Marlene	SIECK	Герман
Peter	VOGL	Герман
Soenke Friedrich	ZIESCHE	Герман
Georgina	BERNÁTH	Унгар
Zsolt Istvánné	HEJCSER	Унгар
Szabina	KOZMA	Унгар
Cintia	OROSZ DR.	Унгар
Bence	TAMÁS	Унгар
Reka	DOMONKOS-GYUGE	Унгар
Karoly	DOMONKOS	Унгар
Mihaly	GALOSFAI	Унгар
Axel Arnar	NIKULASSON	Исланд
Berglind	SIGMARSDOTTIR	Исланд
Fiachra	O'LUAIN	Ирланд
Patricia	DONNELLY	Ирланд
Brendan	GOGARTY	Ирланд
Suhail	AHMAD	Ирланд
Elaine	BYRNE	Ирланд
Eun Mi	LEE	Өмнөд Солонгос
Mijin	YUN	Өмнөд Солонгос
Jueun	MOON	Өмнөд Солонгос
Boyoung	KIM	Өмнөд Солонгос
Leesu	KIM	Өмнөд Солонгос
David Ludovic	BOURSON	Люксембург
Paul Nicolas	KRIDEL	Люксембург
Sébastien Shanti C.	RIES	Люксембург
Julie	WAGNER	Люксембург
Gijsbert Roelf	BAKKER	Нидерланд
Jacobus Wilhelmus	HUURMAN	Нидерланд
Pauline Christine	KRIKKE	Нидерланд
Robbert Hans	SEDEE	Нидерланд
Tjitske Albertha	ZWERVER	Нидерланд
Inger Marie	BAKKEN	Норвег
Julian Yehudi	KRAMER	Норвег
Synve Fosse	OPSAHL	Норвег
Narve	RIO	Норвег
Siri	SKARE	Норвег
Romulus	BANU	Румын
Ion	BULETEANU	Румын
Adina Cristiana	CANDREA IUSCO	Румын
Iulia Ramona	CHIRIAC	Румын
Doina Laura	DOROFTEI	Румын
Dragos	DUMITRACHE	Румын
Radu Horia	GAVRILA	Румын
Octavian Alin	GREBLA	Румын
William Anton	KORBL	Румын

George Adrian	LIXANDRU	Румын
Ruxandra-Maria	MANGU	Румын
Madalina-Ioana	MORARIU	Румын
Miruna	NASTASE	Румын
Mihaela-Ionelia	POPESCU	Румын
Alexandra-Diana	RADU	Румын
Bogdan	STEFAN	Румын
Gabriel	SZEKELY	Румын
Ioana	UDRISTE	Румын
Iulia	ZAMFIRESCU	Румын
Constantina-Raluca	ZANFIR	Румын
Andrey	ALEKSEEV	ОХУ
Sergey	BABURKIN	ОХУ
Artur	BALAOV	ОХУ
Alexander	BEDRITSKIY	ОХУ
Boris	BODROV	ОХУ
Kristina	BOGDANOVA	ОХУ
Artem	BOGOMOLOV	ОХУ
Elizaveta	BORISOVA	ОХУ
Alexey	DOROVSKIKH	ОХУ
Andrei	EFIMOV	ОХУ
Vladislava	FADEEVA	ОХУ
Ksenia	GAVRYUSHINA	ОХУ
Anna	GOZHINA	ОХУ
Dmitry	GROSHEV	ОХУ
Konstantin	GUZ	ОХУ
Dmitry	IAKOVLEV	ОХУ
Vasily	KORCHMAR	ОХУ
Vasilii	KOSHKIN	ОХУ
Dmitry	MAKAROV	ОХУ
Aleksei	MALENKO	ОХУ
Nina	MISHCHENKO	ОХУ
Aleksei	NOVOSELOV	ОХУ
Sergey	OVERCHENKO	ОХУ
Olga	PERFILIEVA	ОХУ
Andrey	PIKALEV	ОХУ
Yana	RAGOZINA	ОХУ
Inna	ROMANCHENKO	ОХУ
Roman	SAIKO	ОХУ
Marina	SHKURENKO	ОХУ
Alexey	SINEGUBOV	ОХУ
Vilyam	SMIRNOV	ОХУ
Anatoly	TABOLKIN	ОХУ
Kirill	TARASOV	ОХУ
Svyatoslav	TERENTYEV	ОХУ
Pavel	TOLMACHEV	ОХУ
Anastasia	TSEDENBAL	ОХУ
Ksenia	VERKHOLANTSEVA	ОХУ
Petr	VOLOKOVYKH	ОХУ
Sergey	ZHDANOV	ОХУ
Andrei	ZIUZIN	ОХУ
Felix Maria	LOPEZ DE DICASTILLO ALBIZUA	Испани
Guillermo	MARIN CASADO	Испани
Celia	SANZ RODRIGUEZ	Испани
Manuel	MUHLEBACH	Швейцарь
Gabriella	SPIRLI	Швейцарь
Berit Ing-Marie	BERGLUND	Швед
Hans Niklas	LINDSKOG	Швед
Maria Magdalena	THAM LINDELL	Швед
Catherine	ARNOLD	Их Британи
Louise	EDWARDS	Их Британи
Christopher	HURD	Их Британи
Simon John	LONGWORTH	Их Британи
Catherine	ARNOLD	Их Британи
Helen	BARTON	АНУ
Richard	BINDRUP	АНУ
Colleen	CRENWELGE	АНУ
Shine	KIM	АНУ
Sean	LOUW	АНУ
Mckenzie	MALINOWSKI	АНУ

Улсын Их Хурлын сонгууль, 2016 оны 6-р сарын 29-ний өдөр
ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Тайлан

James	MOFFITT	АНУ
Michael	RICHMOND	АНУ
Ashleigh	WHELAN	АНУ
Onejin	WU	АНУ
Cody	SWYER	АНУ

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Үндсэн баг

Audrey	GLOVER	Их Британи	Хорооны тэргүүн
Inta	LASE	Латви	
Marla	MORRY	Канад	
Kerstin	DOKTER	Герман	
Giuseppe	MILAZZO	Итали	
Ahmad	RASULI	Киргизстан	
Tomasz	JANCZY	Польш	
Roman	RAILEAN	Румын	
Sergey	RADCHENKO	ОХУ	
Ivana	STANOJEV	Серби	
Anders	ERIKSON	Швед	
Karolina	RIEDEL	Швед	
Noah	LANE	АНУ	
Rokey	SULEMAN	АНУ	

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны Урт хугацааны ажиглагчид

Pir	QORRI	Албани
Christian	WIND	Австри
Petra	NETUKOVA	Чех Улс
Lene Tybjaerg	SCHACKE	Дани
Jessica Lucy	DE LEPARDA	Франц
Kati	HOETGER	Герман
Thomas Klaus	OYE	Герман
Eleonora	BULAT	Молдав
Hans	DIESET	Норвег
Trude Studstroed	JOHANSSON	Норвег
Sergei	ERMAKOV	ОХУ
Vsevolod	PEREVOZCHIKOV	ОХУ
Nadiia	PASHKOVA	Украин
Alexander	KASHUBIN	Узбекистан

ЕАБХАБ-ЫН АИХЭГ-ЫН ТУХАЙ

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын үндсэн институт болох Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ-ын АИХЭГ) нь өөрийн бүрэн эрхт гишүүн орнуудад “хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн хүндэтгэсэн байдлыг хангах, хууль дээдлэх ёсыг сахих, ардчиллын зарчмыг болон (...) хөхүүлэн дэмжих, ардчилсан институциудыг байгуулах, бэхжүүлэх, хамгаалах, түүнчлэн нийгмийг бүхэлдээ харилцан хүндэтгэлтэй хандах хандлагыг хөхүүлэн дэмжих”-д туслалцаа үзүүлэх зорилготой (1992 оны Хельсинкийн Дээд хэмжээний уулзалтын баримт бичиг). Энэ нь ЕАБХАБ-ын хүний хэмжүүр гэж тооцогдоно.

Польш Улсын Варшав хотод байрладаг ЕАБХАБ-ын АИХЭГ нь 1990 оны Парисын Дээд хэмжээний уулзалтын үеэр Чөлөөт сонгуулийн төлөө газар нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 1991 оны 5-р сараас үйл ажиллагаагаа эхэлжээ. Тус байгууллагын эрх нь хүний эрх, ардчилалтай холбоотой асуудлаар өргөжсөн тул жилийн дараа уг байгууллагын нэрийг өөрчилсөн. Өнөөдөр тус байгууллагад 130 гаруй ажилтан ажиллаж байна.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **сонгуулийн ажиглалт явуулах** чиглэлээр Европод тэргүүлдэг байгууллага юм. ЕАБХАБ-ын бүс нутагт явагдаж байгаа сонгуулиуд ЕАБХАБ-ын үүрэг амлалт, ардчилсан сонгуулийн төлөөх олон улсын бусад хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоожийг даган мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх олон мянган ажиглагчдыг томилох ажлыг жил бүр зохион байгуулдаг. Тус байгууллагын өвөрмөц аргачлал нь сонгуулийн үйл явцад бүрэн ажиглалт хийх боломж олгодог. ЕАБХАБ-ын АИХЭГ нь туслалцаа үзүүлэх төрөл бүрийн төслөөр дамжуулан бүрэн эрхт гишүүн орнуудынхаа сонгуулийн хууль эрх зүйн тогтолцоог сайжруулахад тусалдаг.

ЕАБХАБ-ын **ардчиллын** үйл ажиллагаанд хууль дээдлэх ёс, хууль эрх зүйн дэмжлэг, ардчилсан засаглал, шилжилт хөдөлгөөн, шилжин суух эрх чөлөө, жендэрийн тэгш байдал багтана. ЕАБХАБ-ын АИХЭГ нь ардчилсан бүтцийг хөгжүүлэхийг эрэлхийлэн, жил бүр тусламжийн зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь түүнчлэн бүрэн эрхт орнууддаа ЕАБХАБ-ын хүний эрх, ардчилалтай холбоотой цогц хэм хэмжээ, үйл ажиллагааны үүрэг амлалтын дагуу **хүний эрх**, үндсэн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих, хамгаалах үүргээ биелүүлэхэд нь тусалдаг. Ингэхийн тулд хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тухайлсан буюу сэдэвчилсэн чиглэлээр, үүний дотор терроризмтэй тэмцэх явцад хөндөгдөх хүний эрх, хүний наймааны гэмт хэргийн хохирогчдын эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсрол, сургалт, хүний эрхийн мониторинг хийж, тайлан гаргах болон эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлын талаарх чадавхыг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах чиглэлээр янз бүрийн түншүүдтэй хамтран ажилласны дүнд амжилттай ажиллаж байна.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь **бусад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхах** чиглэлийн хүрээнд бусдыг үзэн ядах гэмт хэрэг, арьсны үзлийн зөрчил, гадаад иргэдийг үзэн ядах үзэл, семитийн эсрэг үзэл болон бусад хэлбэрийн үл хүндэтгэсэн үйлдэлд хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлэхэд гишүүн орнууддаа тусладаг. ЕАБХАБ-ын АИХЭГ-ын бусад хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлан гадуурхахтай холбоотой үйл ажиллагаа нь дараахь асуудалд чиглэнэ. Үүнд хууль тогтоомж; хууль биелүүлэх тухай сургалт; үзэн ядалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх арга хэмжээг хянах, тайлагнах, нягтлах; түүнчлэн бусад хүндэтгэлтэй хандах, хүндэтгэх болон хамтын ойлголцлыг хөхүүлэн дэмжсэн боловсролын арга хэмжээ зэрэг багтана.

ЕАБХАБ-ын АИХЭГ нь гишүүн орнуудынхаа **Ром болон Синтичууд** (Roma and Sinti) талаар баримтлах бодлогод нь зөвлөгөө өгдөг. Мөн тэднийг чадавхжуулах, сүлжээ үүсгэх асуудлыг хөхүүлэн дэмжихийн зэрэгцээ бодлого боловсруулах түвшинд тэдний төлөөллийг оруулцуулахыг дэмждэг.

АИХЭГ-ын бүх үйл ажиллагааг ЕАБХАБ-ын гишүүн орнууд, ЕАБХАБ-ын болон түүний чиглэл хариуцсан байгууллагууд, түүнчлэн олон улсын бусад байгууллагуудын нягт хамтын ажиллагаа, уялдаатайгаар хэрэгжүүлдэг.

Дэлгэрэнгүй мэдээлэлтэй АИХЭГ-ын (www.osce.org/odihr) цахим хуудаснаас танилцана уу.